



МОНГОЛ УЛСЫН
ЕРЭНХИЙЛЭГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



ЭРҮҮЛ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН МОНГОЛ ХҮН



2023 он №2



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх: Эрүүл мэнд эрхэм баян гэдэг, нөгөө талаар аливаа улс орны хөгжлийн тулгуур нь эрүүл бие, саруул ухаантай иргэн билээ.



8

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан: “Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн” бол судалгаанд суурилсан нийтийн эрүүл мэндийн ИНТЕРВЕНЦ юм.

24

Я.Содбаатар: Хүний хөгжлийн гол хэмжүүрийн нэг нь эрүүл мэнд

26

Монгол улсын ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг, түүний хэрэгжилт, үр дүн

30

“Архи, согтууруулах ундааны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлд хийгдсэн ажлууд

38

Мэргэжлийн хүмүүс тамхины тухай юу хэлэв
“Тамхи татдаг хүн, татдаггүй хүнээс 25 дахин илүү уушгины хорт хавдраар өвчлөх эрсдэлтэй”



22

“Эрүүл монгол хүн” – хөдөө орон нутагт



41


Та электрон тамхины талаар юу мэдэх вэ?
“Монгол Улсад жил бүр тамхины нөлөөнөөс 4300 орчим амь насаа алдаж, үүний 12 хувь нь дам тамхидалтаас үүдэж байна”

52

Зүрх судасны өвчлөл 3-4 дахин нэмэгдэх хандлагатай байна

53

Зүрхний олдмол гажиг нь ихэвчлэн амны хөндийн эрүүл ахуйн улмаас үүсдэг



56

Сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтыг тогтолцоог бий болгох эрх зүйн орчин бүрдээд байна”

58

Чихэрлэг ундааны хэрэглээ таргалалт ба зарим архаг өвчин үүсэхэд нөлөөлөх нь

62

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 45.6% эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй

64

Т.МӨНХСАЙХАН: Манай улсын хүн амын ердөө 17 хувь нь идэвхтэй дасгал, хөдөлгөөн хийдэг, спортоор хичээллэдэг

69

Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлд хийгдэж буй ажлууд

78

М.БОЛД: Аймаг бүрд стандартын шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай байгуулна

84

“ЭРҮҮЛ – ЭКО” жишиг хан-уул дүүргийг бий болгоно

94

“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөдөлгөөний үйл явдлын хураангуй



2023 /12 CAP
ДУГААР №2

Эрхлэн гаргагч:

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн тамгын
газрын
“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” төсөл
хөтөлбөр хариуцсан алба

Ерөнхий эрхлэгч:

О.Чимэдсүрэн

Референт:

С.Жаргалсайхан

Эдитор:

Б.Ундрах

Дизайнер:

А.Дашням





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ

*ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯН
ГЭДЭГ, НӨГӨӨ ТАЛААР
АЛИВАА УЛС ОРНЫ
ХӨГЖЛИЙН ТУЛГУУР
НЬ ЭРҮҮЛ БИЕ, САРУУЛ
УХААНТАЙ ИРГЭН БИЛЭЭ.*



Эрхэм уншигч танд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Эрүүл бие, саруул ухаантай хүн улс орны хөгжлийн тулгуур нь билээ.

Монгол Улсын хүн амын дунд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой халдварт бус өвчний шалтгаант өвчлөл, нас баралт жилээс жилд нэмэгдэж байгаа нь хотжилт, орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, хувь хүний амьдралын хэв маяг, зан үйл, нийгмийн хүчин зүйлсээс шууд хамаарч байна. Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс өөр хоорондоо нягт уялдаа холбоотой “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнүүдийг санаачлан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр холбогдох зарлиг шийдвэрийг гарган хэрэгжүүлж эхлээд байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь судалгаанд суурилсан Нийтийн эрүүл мэндийн интервенц юм. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, тухайлбал хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон хэрэглэж, архины хэрэглээг багасган, тамхинаас татгалзан биеийн жингээ хэвийн хэмжээнд барьж, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшвэл зүрх судасны өвчин, тархины

харвалт, чихрийн шижинг 80%, хорт хавдрыг 40%-иар бууруулах боломжтойг шинжлэх ухаан нотолсон байдаг. Ялангуяа эрүүл мэндийн гол дарамт, эрсдэл болж буй согтууруулах ундаа, тамхины зохисгүй хэрэглээнээс үүдсэн өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлд онцгой анхаарч 2022 онд 43 тоот зарлиг гарч, холбогдох хууль эрх зүйн баримтуудад өөрчлөлт орж 2024 онд хэрэгжсэнээр эерэг өөрчлөлтүүд гарч буйг цохон тэмдэглэхэд таатай байна.



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй гурван тулгуурт үндэсний хөдөлгөөний нэг нь “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн бөгөөд нийтийн эрүүл мэндийг дэмжих замаар эрүүл чийрэг, саруул сэтгэхүй бүхий эрүүл үндэстэн болоход хөдөлгөөний эрхэм зорилго чиглэгдэнэ. Энэ хөдөлгөөний хүрээнд хүн амын өвчлөл, эндэгдэлийн тэргүүлэх шалтгаан болж буй халдварт өвчний эрсдлийг бууруулахын тулд судалгаанд суурилан, хүн амд чиглэсэн суурь болон анхдагч сэргийлэлтийг үр дүнтэй, оновчтой аргаар салбаруудын оролцоог ханган хэрэгжүүлэх юм.



Эрүүл мэндийн тухай хуульд хүн амд үзүүлэх тусламжийн тэргүүлэх чиглэлийг Нийгмийн эрүүл мэнд гэж тодорхойлсон бөгөөд хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, ажиллаж, амьдарч, сурч байгаа орчиндоо эрүүл мэндэд таатай нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлэхэд нь хувь хүн, олон нийт, байгууллага, хамт олонд туслах, салбаруудын хамтын үйл ажиллагааг уялдуулах нь нэн чухал учраас уг үндэсний хөдөлгөөн ч энэ чиглэлд жишиг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулахаар “Намайг алгас”, “Та татгалз”, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхээр “Цаг гарга”, хүүхдийн чихрийн хэрэглээг бууруулахаар “Сахараа багасгая” зэрэг нөлөөллийн ажлуудыг тодорхой давтамжтайгаар холбогдох төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран явууллаа.

Эрхэм уншигч таныг өөрийн болон гэр бүл, хамт олныхоо эрүүл мэндийг эрхэмлэн, амьдралын эрүүл хэв маяг, зөв дадал зуршлыг дадал болгон Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөнд нэгдэн хувь нэмрээ оруулаарай хэмээн уриалж байна.

Эрүүл Монгол хүн эх орны баялаг

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

Эрүүл мэндийн боловсрол, амьдралын зөв дадал нь эрүүл мэндэд нөлөөлөх тэргүүлэх хүчин зүйл учраас бид боловсролын бүх шатны байгууллагаар дамжуулан эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл, зөв зан үйл, идэвхтэй дасгал хөдөлгөөнтэй, эрүүл мэндийн боловсролтой иргэдийг төлөвшүүлэхээр зорьж байна.

ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ГЭДЭГ НЬ:

1. Эрүүл, чийрэг бие бялдартай
2. Зөв зан үйлтэй
3. Саруул оюун ухаантай
4. Амьдралын зөв, хэв маяг хэвшилтэй, эрүүл орчныг бүтээгч.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан:



**ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН
БОЛ СУДАЛГААНД
СУУРИЛСАН НИЙТИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ИНТЕРВЕНЦ ЮМ**





Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан:

Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх болсон гол шалтгаан юу вэ? өмнө хэрэгжиж байсан хөтөлбөр, төслүүдээс юугаараа ялгаатай вэ?

Монгол Улсын хүн амын нас баралтын 77%-ийг эрүүл бус зан үйл, амьдралын хэв маягаас үүдэлтэй халдварт бус өвчин эзэлж, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг хожуу шатны өвчний өртөг өндөртэй оношилгоо, эмчилгээнд зарцуулж байна. Гэсэн хэдий ч өвчлөл, нас баралт төдийлөн буурахгүй байгааг та бүхэн мэднэ. Тиймээс бид өвдсөнийх нь дараа бус өвчлөл үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч эрүүл, зөв, амьдралын хэв маяг, дадал зуршилтай, эрүүл мэндийн боловсролтой иргэдийг бий болгох зорилго бүхий нийтийн эрүүл мэндийн интервенц гэдгээрээ ялгаатай.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Судалгаанаас харахад манай улсын хүн амын ердөө 3.9 орчим хувь нь л эрсдэлгүй, эрүүл зан үйлтэй амьдарч байна. Хүн амын дунд өнөөдрийн байдлаар эрүүл мэндийн салбарт дарамт болж буй тэргүүлэх эрсдэлд зохисгүй хооллолт, архи тамхины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, түүнээс үүдсэн илүүдэл жин, таргалалт, артерийн даралт ихсэлт орж буй. Эдгээрээс шалтгаалсан хүн амын дундах өвчлөл, эндэгдлийг бууруулахын тулд хүн амыг соён гэгээрүүлэх, нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл орчин, эрүүл хүнсээр хангах, эрүүл, амьдралын хэв маяг, дадалтай иргэдийг бий болгохын төлөө бид судалгаанд тулгуурлан эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт, түүний суурь үзүүлэлтийг тогтоон шинжлэх ухаанчаар оновчтой үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна. Иймээс “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөн нь судалгаанд суурилсан НЭМ-ийн олон талт арга хэмжээ - интервенц юм.



“СУРГУУЛЬД СУУРИЛСАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТАНДАЛТЫГ ТОГТОЛЦООГ
БИЙ БОЛГОХ ЭРХ ЗҮЙН
ОРЧИН БҮРДЭЭД БАЙНА”

Эрүүл амьдралын хэв маяг, дадал зуршилтай иргэдийг хэрхэн бий болгох талаараа тодруулахгүй юу?

Хөдөлгөөний хүрээнд үндэсний хэмжээний цогц бодлогыг салбар яамд болон хэрэгжүүлэгч агентууд гээд холбогдох газруудтай хамтран судалгаанд суурилан бодлогоо тодорхойлж байна. Үүнээс нэг жишээг онцлон дурдъя. Тодруулбал бид БШУЯ-тай хамтран сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлгийн тандалтын тогтолцоог бий болгох эрхзүйн орчныг бүрдүүлээд байна. Өөрөөр хэлбэл 2024 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулиудаар дамжуулан сурагчдын эрүүл мэндийг давтамжтайгаар тогтмол хянаж, шаардлагатай хүүхдүүдэд эрүүл мэндийн дараагийн шатны тусламжийг үзүүлж, эрт үед нь оношилж эмчлэх боломжтой боллоо. Мөн эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн хөтөлбөр шинэчлэл болон эрүүл мэндийн хичээлийг заах тусгай багшийг бэлтгэж эхлээд байна. Өөрөөр хэлбэл та бидний хүүхдүүд сургуулиараа дамжуулан эрүүл мэндээ тогтмол хянуулах боломжтойн дээр нас, бие, физиологийн онцлогт таарсан эрүүл мэндийн боловсролыг мэргэжлийн багшаас авах нөхцөлийг бүрдүүлээд байна. Мэдээж үүнийг дагалдан сургуулийн орчны эрүүл ахуй, сурагчдын үдийн хоолны шим тэжээл агууламж, хоол зүйч, стандарт гал тогоо, биеийн тамирын стандарт заал танхим, багш гээд бидэнд шийдэх олон асуудлууд мөн бий. Мэдээж энэ бүгдийг алга урвуулахтай адил нэг дор бүгдийг шийдэх боломжгүй ч шат дараатайгаар шийдэхээр ажиллаж байна.

Сурагчдын хувьд 6-18 насандаа сургуулиараа дамжуулан эрүүл мэндээ тогтмол хянуулаад явна гэж ойлголоо. Харин бусад насны иргэдийн хувьд эрүүл байлгах тал дээр та бүхэн ямар ажлуудыг төлөвлөн хийж хэрэгжүүлж байна вэ?

Түрүүн хэлсэнчлэн зохисгүй хооллолт, архи тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин, таргалалт гээд хувь хүний амьдралын буруу дадал, зуршил, хэв маягаас шалтгаалсан өвчлөл эндэгдлийг бууруулахын тулд буруу хэрэглээг зөв болгох нь чухал. Иймээс



иргэд, олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд нийгмийг хамарсан соён гэгээрлийн нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах, нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах гээд зөвд уриалсан, хандлагыг өөрчлөх ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Жишээлбэл, архи согтууруулах ундааны нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилго бүхий “Намайг алгас” аян, эрүүл мэнддээ “Цаг гаргая” нөлөөллийн ажил, “Архигүй сар шинэ” арга хэмжээ, хэтрүүлж биш, хэмжээнд нь “Сахараа багасгая” нөлөөллийн ажил, нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааг сурталчлах “Эрүүл Монгол хүн” үндэсний фестиваль, архины хэрэглээг бууруулах чиглэлд “Та татгалз” ерөнхий арга хэмжээ зэрэг нийтийг хамарсан нөлөөллийн ажлуудыг цаг үетэй нь уялдуулан зохион байгуулжээ. Мэдээж бодлогоор зохицуулалт хийх шаардлагатай архи, тамхи, сахарын хэрэглээ гэх мэт асуудалд бид судалгаанд суурилан олон улсын сайн туршлагыг хөрсжүүлэх байдлаар мөн ажиллаж байна.

Та судалгаанд суурилсан нийтийн эрүүл мэндийн арга хэмжээ гэж онцоллоо. Үүнийг тодруулж өгнө үү, тухайлбал ямар судалгаа хийгдсэн, яагаад судалгаа хийх нь чухал байна вэ?

Аливаа хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ одоогийн нөхцөл байдлыг тогтоох тухайлбал хүн амын эрүүл мэнд хир байна, ямар өвчин эмгэг давамгайлж, юу нөлөөлж байна, үүнийг яаж бууруулах гэсэн шийдлийг гаргахын тулд зайлшгүй тоо баримт, статистик мэдээлэл чухал. Бид 2021-2023 онуудад “Архи, согтууруулах ундаа, тамхи, чихэрлэг ундаанд ноогдуулах онцгой албан татварын тооцоолол, эрүүл мэнд, эдийн засгийн үр

нөлөө”, “Тамхины хяналтын суурь конвенци ба түүний хэрэгжилт”, “Хүн амын согтууруулах ундаа, тамхины хэрэглээг эдийн засгийн бүлгээр тогтоох”, “Оюутан залуусын эрүүл мэндийн үнэлгээ”, “Зургаан настай хүүхдүүдийн зүрхний эмгэг илрүүлэг”, “Сурагчдын шүдний эмгэгийн судалгаа” зэрэг хэд хэдэн томоохон судалгаа хийсэн, одоо ч зарим судалгаа үргэлжилж байна. Мөн Баянхонгор аймгийн хүн амын төлөөлөл 8900 орчим, Налайх дүүргийн хүн амын төлөөлөлийг хамруулан ХБӨ-ний анхдагч эрсдэлийг тогтоох судалгааг аймаг, дүүргийн удирдлага, эрүүл мэндийн төв, НЭМҮТ-тэй хамтран явууллаа. Энэ судалгаанд тулгуурлан Эрүүл сум, Эрүүл аймаг, Эрүүл дүүрэг хэмээх интервенцийн шалгуур, түүний суурь үзүүлэлт гарч улмаар 2022 -2024, 2025 – 2027, 2027-2030 он гэсэн 3 шаттай хэрэгжих юм. Бидэнд хийх ажлаа төлөвлөх, хэрэгжилтийн явцыг хянах, эргэн төлөвлөх, эрчимжүүлэх гэх мэт бүхий л шатанд бодит тоо баримт, шинжлэх ухааны нотолгоо зайлшгүй чухал тул энэ хөдөлгөөний салшгүй нэг хэсэг нь судалгаа юм.

Та бүхний бодлогын ажлуудаас онцлох нь Ерөнхийлөгч зарлиг гаргаж үүний хүрээнд архины хэрэглээ анх удаа буурсан талаар та бүхэн мэдээлсэн. Та энэ талаар тодруулж өгнө үү

Согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой эмгэгийн тархалт Монгол улсад 4.44 хувь байгаа нь дэлхийн дундаж (1.4%-аас 3 дахин их, архины хортой хэрэглээнээс үүдсэн цаг бусын нас баралтаар Монгол Улс 100 000 хүн амд 123.24 буюу дэлхийд тэргүүлж байна. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний нэг бүрэлдэхүүн нь Эрүүл эрчүүд, Эрсдэлгүй гэр бүл бөгөөд энэ хүрээнд согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдсэн эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хор хөнөөлийг бууруулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч 43 дугаар зарлигийг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг МУЗГ-г чиглэл болгосон. Уг зарлигийн хэрэгжилтийг хангах үүднээс УИХ-аар 2022 оны 07 дугаар сард “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архиан согтуурахтай тэмцэх тухай”, Онцгой албан татварын тухай хууль (ОАТХ), Засгийн газрын сангийн тухай хууль зэрэг дагалдах 10 гаруй хуульд өөрчлөлт оруулж 2023 оны 01 дүгээр сараас дээрх хуулиуд хэрэгжиж эхлэсэн. Энэ нь сүүлийн 20 жилийн хугацаанд хийгдээгүй хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт юм. эдгээр хуулиудын



хэрэгжилтийн үр дүнд манай улсад анх удаа архи, согтууруулах ундааны хэрэглээ буурсан үзүүлэлттэй гарлаа. Энэ бол зөв бодлогын үр дүн юм.

Та хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн мэдээллээс хуваалцахгүй юу?

Согтууруулах ундаанд ялангуяа хатуулгаас хамааран ногдуулах онцгой албан татварын хэмжээ нэмэгдэж байхаар ОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулсан. ОАТ болон борлуулалтын орлогын эхний 6 сарын мэдээгээр татварын хэмжээ 13 тэрбум, борлуулалтын орлого 8.5 тэрбумаар өссөн байна. Мөн импортоор орж ирсэн согтууруулах ундааны ОАТ-ын хэмжээ 2021 онтой харьцуулахад 9.7 тэрбум, 2022 онтой харьцуулахад 4.3 тэрбумаар нэмэгдсэн дүн гарчээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан нээсэн. Тус хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу уг сан нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай. Онцгой албан татварын тухай хуулийн 6.11-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутмаас 100-300 төгрөгийн орлогыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлэхээр тусгасан. Эхний 6 сарын байдлаар - 14,616,856.63 литр согтууруулах ундаа борлуулагдаж, уг санд 4.3 орчим тэрбум хуримтлагдаад байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээнээс харахад сүүлийн 5 жил согтууруулах ундааны хэрэглээ,



“СҮҮЛИЙН 20 ЖИЛИЙН
ХУГАЦААНД ХИЙГДЭЭГҮЙ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРЖ, АНХ УДАА
МОНГОЛ УЛСАД АРХИНЫ
ХЭРЭГЛЭЭ БУУРЛАА”

үйлдвэрлэл тасралтгүй нэмэгдсэн байдаг. 2022 оны статистикаас харахад нэг хүнд ногдох архи, дарс 8.9 литр, шар айраг 37.1 литр болж, сүүлийн 5 жил тасралтгүй нэмэгдсээр байна. (2018 онд 37.3 литр байсан бол 2022 онд 46 литр)

Согтууруулах ундааны борлуулалтын хувьд 2022 оны эхний хагаст 16,8 сая литр, харин 2023 оны мөн үед 14,6 сая литр болж, архины худалдан авалт 2.2 сая литрээр багассан эерэг өөрчлөлт гарсан. Үүнийг өргөн хэрэглэдэг 0.5 литрээр тооцож үзвэл 4.4 сая шил архи хэрэглэхээс зайлсхийсэн, насанд хүрсэн 1 хүнд ноогдох архи 2 шил архиар багассан гэж үзэж болох юм. Мөн импортолсон согтууруулах ундааны хэмжээ 150 мянган литрээр багассан зэрэг эерэг үзүүлэлтүүд гараад байна. Эдгээр нь Монгол Улсад анх удаа архи, согтууруулах ундааны хэрэглээ буурсан үзүүлэлт юм.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хувьд

- Гарсан өөрчлөлтийг харьцуулан зарим тоо баримтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.8 хувиар
- Шалгагдсан зөрчил 13.6 хувиар
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, торгуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасуулсан зөрчил 26.0 хувиар
- Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол 41.3 хувиар тус тус буурсан байна.





*ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН
БОЛ СУДАЛГААНД СУУРИЛСАН НИЙТИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ИНТЕРВЕНЦ ЮМ*





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН



ЧУУЛГАНД ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ, БОЛОВСРОЛ, БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ЭРДЭМТЭН, СУДЛААЧ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖИЙН 800 ГАРУЙ ЗОЧИД, ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦОВ.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний үзэл баримтлал, хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд танилцуулан хэлэлцүүлж, эрчимжүүлэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн ордноо “Эрүүл Монгол хүн” үндэсний чуулган зохион байгууллаа.

Чуулганд эрүүл мэнд, спорт, боловсрол, болон хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаач, олон улсын байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн 800 гаруй зочид, төлөөлөгч оролцов



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ОНЦЛОХ ЭШЛЭЛҮҮД

Монгол Улсын хамгийн том баялаг бол Монгол хүн. Тиймээс Монгол төрийн бодлогын цөмд хүний хөгжил тэр дундаа Монгол хүний эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчин, эрүүл хүнс нь тулгуур гурван асуудал байх учиртай юм. Энэ ч утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч өөр хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнүүдийг санаачлан улс орон даяар хэрэгжүүлж байна.

Хөрс, хүнс, хүн гурав хүйн холбоотой. Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл байна. Тиймээс Төрийн тэргүүний санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнүүд өөр хоорондоо нягт уялдаа холбоотой хэрэгжих ёстой.

Ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах нь засаг захиргааны бүх шатны төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, бүтээлч, ажил хэрэгч санал санаачилга, үүрэг хариуцлагаас шууд хамаарна. Тиймээс “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд Та бүхний оролцоо, манлайлал, дэмжлэг хамгийн чухал болохыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд онцлон тэмдэглэж байна.

Монгол хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах их үйлсэд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж байгаа эрүүл мэнд, хууль сахиулах байгууллага, төв, орон нутгийн засаг захиргааны ажилтан, албан хаагч Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай.

/ Чуулганы нээлтийн үгнээс ... 2023 оны 04 дүгээр сарын 28/



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх



Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хариуцан ажиллаж байгаа зөвлөхийн хувьд, мөн эмч хүний хувьд аливаа өвчлөлийг үүсгэж буй суурь шалтгааныг цогцоор арилгахад бодлого чиглэгдэнэ гэдгийг онцлон хэлмээр байна. Хөдөлгөөний хүрээнд бид сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгоно.

Өөрөөр хэлбэл сурагчдад хичээлийн дүн тавьдагтай адилаар сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлтийг давтамжтайгаар үзэж, хянадаг тогтолцоог бий болно. Энэ нь эрүүл орчин, эрүүл, зөв зохистой хооллолт, эрүүл зан үйл, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийн боловсрол гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжих юм. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь нэг үеийг эрүүл зан үйлтэй, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг, эрүүл мэндийн боловсролтой, эрүүл орчныг бүтээгч тийм иргэдийг бий болгохоор зорьж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх
Т.Мөнхсайхан



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ОНЦЛОХ ЭШЛЭЛҮҮД

Монгол Улсын хүн амын дунд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчнөөс сэргийлж, тархалтыг бууруулснаар өвчлөл, нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг 50 хүртэлх хувиар бууруулах боломжтой юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн нь цаг үеэ олсон, нэн чухал арга хэмжээ болж байна. Эрүүл Монгол иргэний төлөө бид хамтдаа хичээн ажиллах болно.



Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг:

”

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл залуу үеийг дэмжих цаг үеэ олсон, хамгийн чухал санаачилга юм. Олон улсын эрүүл мэндийн байгууллагын хийсэн судалгаагаар эрүүл мэндийн өвчлөл, эрсдэлийг бага наснаас илрүүлж, зохих арга хэмжээ авч чадвал насанд хүрэгчдийн дундах өвчлөл буурдаг гэсэн дүгнэлт байдаг. Энэ нь хүүхэд, залуучуудын эрүүл мэндэд боловсролын салбар чухал хувь нэмэр оруулж чадна гэсэн үг юм.




Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан:

”

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар эрүүл Монгол хүнийг бий болгох тогтолцоог нэвтрүүлэх цогц ажил өрнөж байгаад бид туйлийн талархалтай хандаж байна. “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн нь эрүүл мэндийг нийгмийн үнэт зүйл болгон эрхэмлэн дээдэлж, архи, тамхины хэрэглээг бууруулах, эрүүл хооллолт, эрүүл мэндийн боловсрол, нийтийн спорт, эрүүл орчныг дэмжиж байгаа нь нэн чухал юм. Монгол хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах энэхүү чухал ажилд ДЭМБ гар бие оролцож байгаа нь бидний хувьд нэр төрийн хэрэг билээ.



ДЭМБ-ын Монгол улс дахь Суурин төлөөлөгч Др. Сокорро Эскаланте:



**ЭРҮҮЛ
МОНГОЛ
ХҮН** **ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨН**





”

**“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН”
ФЕСТИВАЛИ
УЛС ОРОН ДАЯАР ӨРНӨВ**

”





ОРНОО МАНДУУЛЪЯ

ЭРЧҮҮЛ МОНГОЛ ХОЛБ

Achilles

ЭРЧҮҮЛ
МОНГОЛ
ХҮН

ЭРЧҮҮЛ
МОНГОЛ
ХҮН

ЭРЧҮҮЛ
МОНГОЛ
ХҮН

М

онгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэд, олон нийтэд эрүүл мэндээ дэмжих, хамгаалах, зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир, спортын ач холбогдлыг таниулан сурталчлах зорилгоор “Эрүүл Монгол хүн” үндэсний фестивалийг 2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр улс орон даяар олон нийтэд нээлттэй хэлбэрээр зохион байгууллаа.



Анх удаагаа Спортын холбоодыг нэгтгэн, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлан таниулж буй энэхүү фестиваль нь “Бүх нийтийн эрүүл мэндийн төлөө” уриан дор үндэсний хэмжээнд улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулагдснаараа онцлог боллоо. Нийслэл Улаанбаатар хот дахь Жанжин Д.Сүхбаатарын талбайд болсон тус фестивальд 30 гаруй мэргэжлийн холбоодын идэвх, санаачилгаар тэдгээрийн 2500 орчим гишүүд, дэмжигч, багш, тамирчид фестивальд оролцож, 24 нэр төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулж, нийт 1939 иргэнийг хамруулсан ба үүнээс 54 шагналт байрыг шалгаруулан урамшуулжээ.

Холбоод, клубийн багш, дасгалжуулагч, тамирчид өдрийн турш өөрсдийн 18 асарт үйл ажиллагаагаа сурталчлан, сонирхсон олонд анхан шатны техникийн мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааг үнэ төлбөргүйгээр явуулж, давхардсан тоогоор 6318 хүнд хүргэн ажилласан байна.

ХОЛБООД: Фестивальд Монголын таеквондогийн холбоо, Монголын эрүүл мэндийн гүйлтийн холбоо, Монголын скэйтбоард сонирхогчдын Уухай холбоо, Монголын шатрын холбоо, Моголын даамын холбоо, Монголын иогчдын холбоо, Ахиллис Монгол ОУБ, Гар дээр сунгалтын нэгдсэн холбоо, Бодибилдинг, фитнесийн хөгжлийн холбоо, Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв, Монголын шугаман бүжгийн холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоо, Монголын хөгжөөн дэмжигч тамирчдын холбоо, Ширээний теннисний холбоо, Монголын модон барилдааны холбоо, Монголын савлуур, дүүжигнүүрийн Дайчид холбоо, Паралимпийн холбоо, Газрын теннисний Тегри клуб, Монголын уулчдын үндэсний холбоод өөрсдийн клубүүд, тэдгээрийн дэмжигч 2500 орчим тамирчин, дасгалжуулагч, сонирхогч, гишүүдийн хамтаар оролцлоо.

ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ: Фестивалийн нийтийн биеийн тамир, спортын хэсэгт хүүхэд, багачууд, залуусын дунд шатар, даам, сагсан бөмбөг, жудо, модон барилдаан, гар дээр сунгалт, турникийн тэмцээн, хүндийн болон гир өргөлтийн тэмцээн, каратэ, таеквондогийн үзүүлбэр сургалт, газрын болон ширээн теннисийн тэмцээн, гар зургийн уралдаан, дугуйн үзүүлбэр, уралдаан, скэйтбоардын тэмцээн, амьсгал задлах дасгалын тэмцээн, хурдан өшиглөлтийн тэмцээн, нуувч олъё гүйлтийн тэмцээн, буухиа хөгжөөнд тэмцээн, АХА тэмцээн, сугалаатай сунгалт гэх мэт спорт, оюуны олон төрлөөр өдрийн турш фестиваль үргэлжиллээ.



ФЕСТИВАЛЬД ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭГДЛҮҮД

Иргэн Ц.Мөнхбат: Ийм өргөн хүрээний олон төрлийн эрүүл мэнд, спортын үйл ажиллагааг нэг дор нэгтгэн зохион байгуулж байгаатай анх удаа таарч байна. Хамгийн их таалагдсан зүйл гэвэл сонирхсон спортын төрлөөрөө шууд багштай хичээллэж үзэх боломжтой нь их таалагдлаа. Жишээ нь, би газрын теннисийг сонирхож очсон. Багш нь мэдээлэл өгч, найрсагаар цохиураа хэрхэн барихаас эхлүүлэн анхан шатны техникийг нь заагаад хамт тоглосон нь үнэхээр их таалагдлаа. Багштайгаа яриад газрын теннисээр хичээллэхээр болсондоо баяртай байна. Олон жил бодож явсан зүйлээ биелүүлэх гэж байна /инээв/



Баянгол дүүргийн Хүүхэд залуучуудын ордны багш Б.Батсайхан: Миний зүрх их муу байсан. Таргалалттай байсан. Одоо бол зүрхний өвчин, зовиур байхгүй болсон. Би өнөөдрийн фестивалд нийтийн шугаман бүжиг бүжиглэхээр ирээд байна. Дасгал, хөдөлгөөний ач тусыг энд ирсэн олон нийтэд сурталчлахаар манай хамт олон ирээд байна. “Эрүүл Монгол хүн” үндэсний фестиваль үнэхээр хэрэгтэй үйл ажиллагаа болж байна. Үүнийг тогтмол жил бүр зохион байгуулж байгаасай гэж мөн хүсэж байна.



Худалдаа эрхлэгч О.Ууганбаяр: Зохион байгуулагч нартаа баярлалаа. Маргааш хүүхдийн баяр. Би өнөөдрийн үйл ажиллагаанд хүүхдэд ээлтэй бэлэг худалдаалж оролцож байна. Фестиваль надад маш их таалагдсан. Учир нь гол санаа нь иргэдэд эрүүл амьдрахад нь туслах зорилготой олон үйл ажиллагааг нэг дор зохион байгуулж байна.



ФЕСТИВАЛЬ СОНИРХОГЧИД:

Санаандгүй энэ хавиар явж байгаад, сонирхоод явж байна. Бид ангиараа найзуудаараа явж байгаа. Тэгсэн их гоё арга хэмжээ болж байна. Тэр 3*3 сагсны тэмцээнд манай найз орсон. Бид найзыгаа дэмжээд, гэхдээ хожигдчихлоо. (инээлдэв)

Ажлынхаа цонхоор хараад гарч ирээд сонирхоод явж байна. Шатар, даамны олон ширээ, тоглож байгаа хүмүүсийг хараад ганц нүүхээр гараад ирлээ. Хаа сайгүй олон төрлийн спортын арга хэмжээ болж байгаа нь сонирхолтой санагдаж байна. Одоо тийшээ явж ганц, нэг бөмбөг шиднээ.



Хаа сайгүй яг өнөөдрийнх шиг талбай дүүрэн спортын олон олон тоглоом байвал залуучууд чөлөө цагаа зөв өнгөрөөхөөр санагдлаа. Сагс, хөл бөмбөг, ширээний теннис, газрын теннис гээд эд нар нь тоглоход бэлэн энд тэндгүй олон болоосой гэж хүсэж байна.

Надад хамгийн их таалагдсан зүйл гэвэл хоолны хэсэг байлаа. Хүн эрүүл байхад хоол, хүнс их чухал. Хоолны шим тэжээл болон ашигтай, ашиггүй, үл зохицох хоол хүнсийг модель болгон, тайлбартай нь тавьж, зөвлөгөө өгч байсан нь их таалагдлаа. Би өөрөө сахартай хүн л дээ. Тиймээс хэрэгтэй олон мэдээлэл авч, хоолны жороо хүртэл бичүүлж авлаа.





Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан:

Олон нийтэд эрүүл зан үйлийг сурталчилсан өнөөдрийн үйл ажиллагаа их сайхан болж байна. Бид иргэддээ явал эрүүл аж төрөх үү гэдэг дээр тасралтгүй мэдээлэл өгч ажиллах үүрэгтэй. Тиймээс ч өнөөдөр улс орон даяар эрүүл мэнд, спортын олон үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл амьдралын хэв маягт уриалж байна.



Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн хэлстийн дарга Н.Баасан:

Хүн эрүүл байхад спорт, дасгал, хөдөлгөөн маш чухал. Өнөөдрийн “Эрүүл Монгол хүн” үндэсний фестиваль улс орон даяар зохиогдож эрүүл зан үйлийг нийтэд сурталчилж байгаад баяртай байна. Бид хүүхэд, залуусыг багаас нь спортод дурлуулж өсгөвөл ирээдүйн эрүүл, чийрэг иргэнийг бий болгох юм. Олон холбоод, клубийг нэгтгэн үйл ажиллагааг нь сурталчлах энэхүү үйл ажиллагааг тогтмол зохион байгуулваас илүү өргөжиж, нийтэд ач тусаа, нөлөөгөө хүртээнэ гэж харж байна.



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн төлөөлөл:

Бүх нийтийн эрүүл мэндийн төлөө уриатай “Эрүүл Монгол хүн” үндэсний фестиваль нь өмнө нь зохион байгуулагдаж байсан олон арга хэмжээнүүдээс онцлог санагдлаа. Учир нь иргэдийн амьдралын хэв маягийг зөв болгоход чиглэсэн үзлэг, зөвлөгөө хүргэж ажиллалаа. Амьдралын хэв маягт нь таарсан эрүүл амьдралын жор бичиж өгсөн нь хүмүүст их таалагдаж байсан.



Өсвөрийн таеквондочин 12 настай Г.Бадамханд:

Би таеквондоогоор хичээллэснээр би их тэсвэр, твчээртэй болсон. Бас хатуужилтай болж олон зүйл сурсан. Энд ирсэн үеийнхээ хүүхдүүдэд таеквондогийн техникээсээ зааж, хамтдаа хичээллэж байна. Хүүхдүүд их дуртай сурж, багшийн заасныг дагаж хийж байна. Маш олон хүүхдүүд, бас том хүмүүс таеквондог сонирхож биднийг дууриан хийж байна.



ШУТИС-ийн багш, дэд профессор, хоол судлаач М.Пүрэвжав:

Бид хоол, шим тэжээлийн зөвлөгөө, мэдээлэл иргэдэд өгч өнөөдрийн фестивалд оролцож байна. Манай улсад 839 ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д 680,8 мянган сурагчид суралцаж байна. Үүнд 34 073 үндсэн багш ажиллаж байна. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний гол бүрэлдэхүүн болох эрүүл, зөв, зохистой хооллолт, түүнтэй уялдах зөв мэдлэг, мэдээллийг ЕБС-ийн сурагчдад зөв хооллолт, эрүүл зан үйл, идэвхтэй дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийн боловсролоор нь дамжуулан системтэйгээр, цогцоор нь өгөхөөр ажиллаж байна.

“Uuree dance” бүжгийн клубийн үүсгэн байгуулагч Ж.Үүрийнтуяа:

Хүссэн хүн бүр бүжиг бүжиглэх боломжтой гэдгийг уриалж анх бүжгийн клубээ нээж байсан. Манай клубт хүмүүс бүжиглэж, дасгал хөдөлгөөн хийж, өөрсдөдөө гоё зүйл мэдрэхээр ирдэг. Тэрнээс биш бүжигчин болох гэж ирдэггүй. Өнөөдөр бид клубийнхээ 500 гишүүний оролцоотой флашмоб хийж цугласан олныг огшоож чадлаа. Нийтэд бүжиг бол хүссэн хэн бүхэн хийх боломжтой гэдгийг гэдгийг уриалж байна.



Монголын явган алхалтын холбооны төлөөлөл:

Өнөөдөр их сайхан арга хэмжээ болж байна. Бид өргөн бүрэлдэхүүнээрээ ирж оролцож байна. Алхалтын ач тусыг сурталчилж, холбоо, клубтээ сонирхсон иргэдийг элсүүлж, алхалтын багаа өрөгжүүлсэн сайхан өдөр байна. Алхалт бол хэн бүхэнд хийх боломжтой спорт юм. Та гүйж чадахгүй байсан ч, та фитнес хийж чадахгүй нь хамаагүй алхалтаар өөрийгөө эрүүлжүүлж болдог гэдгийг бид өөрсдөөрөө сурталчилж байна.



Газрын теннисний “Тегри” клубийн багш Д.Эрдэнэбаяр:

Улаанбаатар хотод газрын теннисний стандарт талбай тун цөөхөн. Нийтэд ил тод талбай цөөн учир хүссэн иргэд нь сонирхоод оролдоод үзэх боломж нь хязгаарлагдмал байдаг. Өнөөдөр талбай дээр сонирхсон иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах боломж олдож байна. Мөн иргэд ч ихээр сонирхож, хичээллэх хүсэлтэй хүмүүс мөн олон байна. Нийтийн спортын талбайг олонг бий болговол иргэд маш ихээр сонирхож спортод дурлагсад нэмэгдэнэ гэж бодож байна.





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ХӨДӨӨ ОРОН НУТАГТ

“Бүх нийтийн эрүүл мэндийн төлөө” уриан дор олон нийтийг эрүүл амьдралын зан үйл, идэвхтэй дасгал хөдөлгөөнд уриалах, нийтийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэхэд иргэдийн оролцоо, салбарын уялдааг хангах чиглэлд “Эрүүл Монгол хүн” үндэсний фестивалийг улс орон даяар зохион байгуулагдлаа.



Энэ хүрээнд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний бодлого хэрэгжилтийг нийслэлийн болон 21 аймгийн төрийн захиргааны байгууллагууд, эрүүл мэндийн газрууд, өрхийн эмнэлгүүд, биеийн тамир, спортын хороодыг хамруулан ЕТГ-ын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга О.Чимэдсүрэн болон Нийгмийн эрүүл мэндийн төвийн захирал С.Өнөрсайхан нар холбогдох байгууллагуудын удирдлагуудыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж “Эрүүл Монгол хүн” үндэсний фестивалийг улс орон даяар зохион байгууллаа.





“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ФЕСТИВАЛЬ ХӨДӨӨ ОРОН НУТАГТ





Я.СОДБААТАР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ГОЛ ХЭМЖҮҮРИЙН НЭГ НЬ ЭРҮҮЛ МЭНД

-Төрийн тэргүүний санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний гол онцлог, үзэл баримтлалыг та уншигчдад товч танилцуулна уу?

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар Хүнсний хувьсгал, Тэрбум мод, Эрүүл Монгол хүн гэсэн харилцан бие биеэ тэтгэсэн гурван тулгуурт үндэсний хөдөлгөөнийг орон даяар амжилттай хэрэгжүүлж байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь монгол хүний дундаж наслалтыг уртасгах, эрүүл мэндийг нь тэтгэх, бие бялдрыг нь анагаахын шинжлэх ухааны үндэстэй эрүүл чийрэг болгон хөгжүүлэхэд чиглэсэн нийтийн эрүүл мэндийн арга хэмжээ юм. Ер нь хүний хөгжлийг тодорхойлохдоо эрүүл мэнд, боловсролыг чухалчилдаг. Чанартай, эрүүл амьдрал буюу дундаж наслалтын үзүүлэлтээр нь улс орнуудыг харьцуулдаг. Монголчуудын хувьд эрчүүд эмэгтэйчүүдээс 9.4 жил богино насалж байгаа нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдолоос үүдсэн илүүдэл жин, архи, тамхины хортой хэрэглээнээс хамаарч байгаа нь олон судалгаагаар тогтоогдсон. Өөрөөр хэлбэл хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгаан нь тухайн хүний өдөр тутмын амьдралдаа хэвшүүлсэн зан үйл, эрүүл мэндийн боловсролоос ихээхэн хамаардаг юм байна. Монголчуудын хувьд урьдчилан сэргийлж болохуйц өвчин буюу даралт ихсэлт, хавдар, зүрх судасны эмгэг зэрэг эзэлж байгаа бөгөөд энэ нь улам залуужиж байгаа учраас бид бүх түвшинд анхаарах нь чухал байна. Үүнтэй уялдаад амьдрал ахуйн эрүүл орчин бүрдүүлэх, аюулгүй, хүртээмжтэй хүнсээр хүн амаа хангах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, нийтийн биеийн тамираар чийрэгжүүлэх замаар “Эрүүл Монгол хүн”-ийг төлөвшүүлэх үндэсний хөдөлгөөнийг Төрийн тэргүүн санаачлан хэрэгжүүлж байгаа юм. Энэ хөдөлгөөнийг хэрэгжүүлэхдээ ялангуяа эрүүл мэндийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчныг нь сайжруулах, тогтолцоонд нь өөрчлөлт оруулах, жишиг төсөл хэрэгжүүлэн түүнийхээ үр дүнд тулгуурлан



үндэсний хэмжээнд хөдөлгөөнөө хэрэгжүүлэх зарчмыг баримталж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2022 онд 43 тоот зарлиг гаргасан. Энэ зарлиг үндэсний хөдөлгөөнтэй хэрхэн уялдаж байна вэ?

Өмнө дурдсанчлан, манай улсын хүн амын өвчлөлийг өсгөж байгаа гол эрсдэлт хүчин зүйлд архи, согтууруулах ундааны хортой, зохисгүй хэрэглээ байгаа. Тиймээс бид олон улсын байгууллага, мэргэжлийн судлаачид, эрдэмтэдтэй хамтран судалгаа хийсний үндсэн дээр тэр эрсдэлт хүчин зүйлийн хортой нөлөөг бууруулах шийдлийг бодлогын түвшинд боловсруулан, хэрэгжилтийн явцын үнэлгээг хийж байна.

Нэг жишээ дурдъя. Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн хийсэн судалгаагаар, насанд хүрсэн хүн амын 6 орчим хувь нь архинд донтсон, тэдний нэлээд хувь нь архийг хэтрүүлж хэрэглэж байгаа гэсэн үр дүн гарсан байна. Эрчүүд эмэгтэйчүүдээс бараг 10 жилээр богино насалж байгаа нь ч архины хортой хэрэглээ, түүнээс үүдсэн осол гэмтэл, хэрэг зөрчил гээд эрүүл мэнд болон нийгмийн амьдралд архи олон хор хөнөөлийн суурь болж байна. Энийг ер нь хүн бүр мэднэ, гэхдээ тууштай, зохион байгуулалттай арга хэмжээ авахгүй явсаар эрчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү дэндүү их болжээ. Энэ нь цаанаа эмэгтэй хүний амьдралд асар их сөрөг нөлөөтэй. Хань ижил нь богино насална гэдэг бол

хүн үлдсэн амьдралаа ганцаардаж өнгөрүүлэх гол нөхцөл мөн. Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгч “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор 43 дугаар зарлигийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Зарлигт, архины хатуулгийг жил бүр бууруулах, онцгой албан татварыг нэмэх, иргэдээ соён гэгээрүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлд нөлөөллийн ажлыг өргөн далайцтай хэрэгжүүлэх, донтох эмгэгийн үед үзүүлэх тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал заалт тусгаж Засгийн газарт чиглэл өгсөн. Мөн уг зарлигийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Засгийн газрын сангийн тухай, “Онцгой албан татварын тухай зэрэг хуулиудад өөрчлөлт орж 2023 оноос хэрэгжиж эхлээд байна. Эдгээр эрх зүйн шинэчлэл нь иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, согтууруулах ундааны хортой хэрэглээг бууруулах, монгол хүн урт насалж, чанартай амьдрахыг нь дэмжсэн бодлогын томоохон шинэчлэл болсон гэж үзэж байна.

Нэлээн олон хуулиудад өөрчлөлт орсон байна. Та зарим онцлох заалт, түүний хэрэгжилтээс дурдана уу?

Энэ оны эхний 8 сарын байдлаар, хатуулаг өндөртэй согтууруулах ундаанд ногдуулах 2023 оны онцгой албан татвар 7 тэрбум, нийт татварын хэмжээ 9 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн хууль хэрэгжсэнээр, импортоор орж ирсэн хатуулаг өндөртэй архины хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар буурсан өөрчлөлт гарлаа. 2023 оны эхний 08 сард согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна гэсэн мэдээллийг Цагдаагийн ерөнхий газраас өгч байна.

Гол нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож өөрийн болоод бусдын амь нас, эрүүл мэнд, гоо сайхныг хохироох, торгуулж өөрийнхөө эдийн засгаа хохироох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж ажил амьдралдаа хоцрогдол гаргах зэрэг зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 8264 буюу 26.0 хувиар буурсан эерэг үр дүн гарчээ. Эдгээр эерэг өөрчлөлт нь бодлогын шинэчлэл, нөгөө талаар хүн амд чиглэсэн нөлөөллийн ажлуудтай холбоотой. Тухайлбал Ерөнхийлөгчийн Тамгын газраас холбогдох талуудтай хамтран зохион байгуулсан “Намайг алгас”, “Та татгалз” зэрэг архины хор хөнөөлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн ажлууд энд тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж үзэж байна. Ер нь хүн хэлэхээс, цааш чичихээс наашгүй гэж үг бий шүү дээ.

Цаашид энэ хөдөлгөөний хүрээнд ямар ажлуудыг хэрэгжүүлэх вэ?

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь эрүүл мэндийн боловсрол, идэвхитэй хөдөлгөөн, эрүүл зан үйл, эрүүл орчин гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй юм. Тус хөдөлгөөнийг эрчимжүүлэх, тасралтгүй байдлыг хангах зорилгоор бид УИХ тогтоол батлуулахаар ажлын хэсэг гарч холбогдох яам, агентлаг, төр, хувийн хэвшил, судалгааны багуудтай хамтран суурь судалгаа хийн, тогтоолын төслийн эхний үзэл баримтлалыг боловсруулаад байна. Ингэснээр хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, сэргийлэхэд чиглэсэн нийтийн эрүүл мэндийн цогц арга хэмжээг олон талын оролцоотой хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм. Түүнчлэн хүүхэд залуусын электрон тамхины хэрэглээг эсч эрүүл мэндийн эрсдлийг нэмэгдүүлж байгаатай уялдан бид тамхидалтыг бууруулах чиглэлд бусад улс орны хэрэгжүүлж буй сайн туршлага, эрүүл мэндэд учрах эрсдэл болон эдийн засгийн дарамт, хууль эрх зүйн шинэчлэл хийх хэрэгцээг судлан ажиллаж байна. Энэ чиглэлд ч нэлээн олон ажлууд хийгдэх болно.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 43 ДУГААР ЗАРЛИГ


Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор 2022 оны 4 сарын 5-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 тоот зарлиг гаргасан. Яагаад зарлиг гарсаныг дараах хэдэн тоо баримтаас харж болно. Тухайлбал Монголчуудын согтууруулах ундааны хэрэглээнээс шалтгаалсан цаг бусын нас баралт 100 000 хүнд дэлхийн дундаж 35 байхад Монгол улсад 123.2 буюу 3.5 дахин их, шууд ба шууд бус нөлөөлөлийн улмаас жилдээ 4000-4500 орчим хүн эндэж байна. Гарч буй гэмт хэргийн 60-70 хувь, нийт гэмтлийн 10-12 хувь нь архи согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотой байна.

26

АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЛЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Дугаар 43 Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нэг. Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор "Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийн хүрээнд "Эрүүл Монгол Хүн" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар(Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай:

Зарлигт тусгасан зарим заалтаас дурьдахад:

- Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;
- Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүр мөсөн хориглох;

Зарлиг гарсанаар ямар хууль, эрх зүйн өөрчлөлт:

Уг зарлигийн хэрэгжилтийн хангах үүднээс УИХ-аар 2022 оны 7 сард “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай”, Онцгой албан татварын тухай хууль Засгийн газрын сангийн тухай хууль, зэрэг дагалдах 10 гаруй хуульд өөрчлөлт орж 2023 оны 1 сараас хэрэгжиж эхлээд байна.

Согтууруулах ундаанд ялангуяа хатуулагаас хамааран ноогдуулах онцгой албан татварын хэмжээ нэмэгдэж байхаар ОАТ хуульд өөрчлөлт оруулсан. ОАТ, болон борлуулалтын орлогын эхний 6 сарын мэдээгээр татварын хэмжээ 13 тэрбум, борлуулалтын орлого 8.5 тэрбумаар өссөн байна. Мөн импортоор орж ирсэн согтууруулах ундааны ОАТ хэмжээ 2021 онтой харьцуулахад 9.7 тэрбум, 2022 онтой харьцуулахад 4.3 тэрбумаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан нээсэн. Тус хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу уг сан нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай байна. Онцгой албан татварын тухай хуулийн 6.11-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн

орлогыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлэхээр тусгасан. Эхний 6 сарын байдлаар - 14,616,856.63 литр согтууруулах ундааны борлуулж уг санд 4.3 орчим тэрбум хуримтлагдсан байна. Уг төсвийг архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх боломж, эх үүсвэр бүрдсэн байгаа бөгөөд үүний хэрэгжилт, зарцуулалтыг анхаарах нь чухал байна.

Согтууруулах ундааны хэрэглээнд өөрчлөлт гарсан уу, энэ талаар тооцоо, судалгаа:

Үндэсний статистикийн хорооны мэдээнээс харахад сүүлийн 5 жил согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл тасралтгүй нэмэгдсэн байдаг. 2022 оны статистикаас харахад нэг хүнд ноогдох архи, дарс 8.9 литр, шар айраг 37.1 литр болж сүүлийн 5 жил тасралтгүй нэмэгдсээр байна. (2018 онд 37.3 литр байсан бол 2022 онд 46 литр)

Согтууруулах ундааны борлуулалтын хувьд 2022 оны эхний хагасд 16,8 сая литр, харин 2023 оны мөн үед 14,6 сая литр болж архины худалдан авалт **2.2 сая литрээр** багассан нь эерэг өөрчлөлт гарсан. Үүнийг өргөн хэрэглэдэг 0.5 литрээр тооцож үзвэл **4.4 сая** шил архи хэрэглэхээс зайлсхийсэн, насанд хүрсэн 1 хүнд ноогдох архи 2 шил архиар багассан гэж үзэж болох юм. Мөн импортолсон согтууруулах ундааны хэмжээ 150000 литрээр багасан байна.



Хууль зүйн
үндэсний хүрээлэн

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/



Автомат машин ашиглан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хаягаар хүргэхийг хориглосон. /шагийн архи/ 21.1.4 дэх хэсэг



Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардахыг хориглосон /28.2 дахь хэсэг/

Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардаж гэм хор учруулсан бол согтууруулах ундаа хэрэглэхийг шаардсан этгээдэд хариуцлага хүлээлгэнэ./архи шахах/



Барилгын батлагдсан зураг төслөөс өөрөөр орон сууц, орц, хонгил, суурийн давхарт 18-аас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх./20.1.7 дэх хэсэг/



Согтууруулах ундаагаар үйлчлэх байгууллага нь танхимдаа халуун, хүйтэн зуушаар үйлчлэх ба ундны усаар үнэ төлбөргүй үйлчилнэ./24.4 дэх хэсэг/



Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг ХХААХҮ-ийн ямаас 5 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тухай бүр сунгаж болно. /14.8 дахь хэсэг/



Гадаад улсад экспортлох, агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд тусгай зориулалтаар, захиалгаар нийлүүлэхээс бусад тохиолдолд 18 түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг 0.33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно./12.6 дахь хэсэг/



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 43 ДУГААР ЗАРЛИГИЙН ХЭРЭГЖИЛТ

Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 тоот зарлиг гаргасан.

- Онцгой албан татварын ангилал, шатлалд өөрчлөлт оруулах замаар 38 хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааны хатуулгийг 10 жилийн хугацаанд жил бүр 2 хувиар бууруулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;

ЗАРЛИГИЙН ДАГУУ ГАРСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Уг зарлигийн хэрэгжилтийн хангах үүднээс УИХ-аар 2022 оны 7 сард

1. “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай”,
2. Онцгой албан татварын тухай хууль
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан нээсэн

Согтууруулах ундаанд ялангуяа хатуулагаас хамааран ноогдуулах онцгой албан татварын хэмжээ нэмэгдэж байхаар ОАТ хуульд өөрчлөлт оруулсан. ОАТ, болон борлуулалтын орлогын эхний 6 сарын мэдээгээр татварын хэмжээ 13 тэрбум, борлуулалтын орлого 8.5 тэрбумаар өссөн байна. Мөн импортоор орж ирсэн согтууруулах ундааны ОАТ хэмжээ 2021 онтай харьцуулахад 9.7тэрбум, 2022 онтой харьцуулахад 4.3 тэрбумаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг

дэмжих сан нээсэн. Тус хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу уг сан нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай байна. Онцгой албан татварын тухай хуулийн 6.11-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 150-300 төгрөгийн орлогыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлэхээр тусгасан.

ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Үндэсний статистикийн хорооны мэдээнээс харахад сүүлийн 5 жил согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэл тасралтгүй нэмэгдсэн байдаг. 2022 оны статистикаас харахад нэг хүнд ноогдох архи, дарс 8.9 литр, шар айраг 37.1 литр болж сүүлийн 5 жил тасралтгүй нэмэгдсээр байна. (2018 онд 37.3 литр байсан бол 2022 онд 46 литр)

Согтууруулах ундааны борлуулалтын хувьд 2022 оны эхний хагасд 16,8 сая литр, харин 2023 оны мөн үед 14,6 сая литр болж архины худалдан авалт 2.2 сая литрээр багассан нь эерэг өөрчлөлт гарсан. Үүнийг өргөн хэрэглэдэг 0.5 литрээр тооцож үзвэл 4.4 сая шил архи хэрэглэхээс зайлсхийсэн, насанд хүрсэн 1 хүнд ноогдох архи 2 шил архиар багассан гэж үзэж болох юм. Мөн импортолсон согтууруулах ундааны хэмжээ 150000 литрээр багасан байна.

Архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг зөрчлийн хувьд

Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний нийгмийн сөрөг нөлөөг харуулах үзүүлэлтүүдийг бид харьцуулж үзэхэд 2023 оны эхний 08 сард 25392 гэмт хэрэг бүртгэгдсэний 3289 буюу 13.0 хувь нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж, 46.5% нь нийслэлд, 2089 буюу 53.5% нь орон нутагт тус тус бүртгэгдсэн. Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүний 3911 буюу 92.1 хувь нь эрэгтэй, 335 буюу 7.9 хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг. Гарсан өөрчлөлтийг харьцуулан зарим тоо баримтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дурьдахад:

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр нэг хүнд ногдож байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэлийн хэмжээ

Бүтээгдэхүүн	2010	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Архи, дарс /л/	7.7	7.2	7.9	8	9.2	8.5	9.8	7.6	8.3
Шар айраг /л/	17	25.3	25	26.6	28.9	28.8	30.3	28.8	31



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 05 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУльд НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

- 1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.3.25 дахь заалт:

"5.3.25. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан."

2/21³ дугаар зүйл:

- "21³ дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан

сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан

21³.1. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүү зориулалттай байна.

21³.2. Дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 05 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт


[Хэвлэх](#)

1.1. Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэхэд оршино.


- 2 дугаар зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомж

[Хэвлэх](#)


2.1. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөвшөөрлийн тухай хууль, [Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай](#) хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Гаалийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.8 хувиар



Шалгагдсан зөрчил 13.6 хувиар буурсан



Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, торгуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасуулсан зөрчил 26.0 хувиар



Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол 41.3 хувиар



Эрүүлжүүлэгдсэн хүн 76.0 хувиар тус тус буурсан байна



“АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ХИЙГДСЭН АЖЛУУД

“АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ НЬ” СЭДЭВТ САЛБАР ДУНДЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО



“Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах нь” сэдэвт салбар дундын удирдах ажилтны зөвлөгөөнийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албанаас 2023 оны 10 дугар сарын 09-ний өдөр зохион байгууллаа.

Зөвлөгөөнөөр архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилго бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай болон дагалдах 10 гаруй хуульд орсон өөрчлөлт, түүний хэрэгжилтийн явцыг хэлэлцэх, улмаар цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр нөлөөг эрчимжүүлэх чиглэлд салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор холбогдох төрийн байгууллагуудын удирдлагууд санал солилцлоо.

Зөвлөгөөнд ЭМЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Аддиктологийн төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, ДЭМБ зэрэг 15 байгууллагын 60 гаруй төлөөллүүд оролцлоо.



Монголчуудын өвчлөл, эндэгдлийн дийлэнхийг бидний буруу дадал зуршил, тэр дундаа зохисгүй хооллолт, хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй. Эрүүл монгол хүнийг буй болгох энэхүү үйлсийг эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгч, иргэн бүр ойлгон дэмжиж хэрэгжүүлэхийг уриалж байна.



Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар



Өнгөрсөн хугацаанд манай улсын эрүүл мэндийн салбар эмнэлэг шүтсэн бодлого баримталж ирсэн. Тийм ч учраас жил ирэх тусам элдэв өвчлөл, эндэгдэл өсөн нэмэгдсээр байна. Өнөөдөр манай улсын хүн амын ердөө 3,7 хувь нь л эрүүл зан үйл, эрүүл амьдралын хэв маягтай амьдарч байгаа судалгаа гарсан. Мөн манай улсын хүн амын 17 хувь л идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг байна. Энэ үзүүлэлт Ази тивд 60 хувь байдаг. Энэ үзүүлэлт хүн амын 60 хувиас дээш байж гэмээнэ эрүүл зан үйлтэй, эрүүл иргэдтэй нийгмийг бий болгох боломжтой юм. Энэ хувийг өсгөхөд бид нийгмийн эрүүл мэндийн суурь урьдчилан



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан

сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж нийтийн эрүүл мэндийн тогтолцоог бий болгохоор “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн судалгаанд суурилан ажиллаж байна. Би эмч хүн, мөн энэхүү Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хариуцан ажиллаж байгаа хүний хувьд аливаа өвчлөлийг үүсгэж буй суурь шалтгааныг цогцоор арилгахад бодлого чиглэгдэнэ гэдгийг онцлон хэлмээр байна. Үүний тулд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн эрүүл орчин, эрүүл, зөв зохистой хооллолт, эрүүл зан үйл, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийн боловсрол гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжих юм.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь нэг үеийг эрүүл зан үйлтэй, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг, эрүүл мэндийн боловсролтой, эрүүл орчныг бүтээгч тийм иргэдийг бий болгохоор зорьж байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн нь боловсролын бүх шатны байгууллагаар дамжуулан эрүүл иргэдийг бий болгох нийгмийн эрүүл мэндийн интервенц юм. Сурагчдад хичээлийн дүн тавьдагтай адилаар энэ хөдөлгөөний дүнд цэцэрлэг, сургууль, их дээд сургуулийн оюутан, сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлтийг давтамжтайгаар үздэг болох юм. Ингэснээр бид сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгож эрсдэлийг бууруулах боломжтой. Эцэст нь хэлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй 3 хөдөлгөөн нь эрүүл монголыг бий болгох, хоорондоо нягт уялдаатай хөдөлгөөнүүд юм. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн маань судалгаанд суурилсан нийгмийн эрүүл мэндийн бодлого бөгөөд эрүүл ирээдүйг бий болгох үндсэн зорилготой юм.



Монгол Улсын хүн амын дунд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчнөөс сэргийлж, тархалтыг бууруулснаар өвчлөл, нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг 50 хүртэлх хувиар бууруулах боломжтой юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн нь цаг үеэ олсон, нэн чухал арга хэмжээ болж байна. Эрүүл Монгол иргэний төлөө бид хамтдаа хичээн ажиллах болно.



ХЗДХ-ийн дэд сайд Б.Солонго



ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин
төлөөлөгч Сокорро Эскаланте:

“Архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь Нийгмийн эрүүл мэндийн хувьд томоохон асуудал бөгөөд дэлхий даяар үүнээс шалтгаалан гурван сая хүн нас барж, олон сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болж, эрүүл мэндийн доройтолд орж байна. Дэлхий нийт өвчлөлийн 5.1 хувь нь архинаас шууд хамааралтай гэсэн судалгаа бий. Түүнчлэн Монгол Улсад 270 хүн тутамд архи, согтууруулах ундаа борлуулах нэг цэг ногдож байгаа нь дэлхийд маш дээгүүрт орох үзүүлэлт. Тиймээс шинээр гарсан хууль тогтоомж, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрөөр дамжуулан энэ тоон үзүүлэлтийг бууруулна гэдэгт итгэлтэй байна.



Татварын Ерөнхий газрын Татвар
хураалтын удирдлага, арга зүйн
газрын дарга О.Мягмаржав

Өнгөрөгч онд батлагдсан “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай” хуулийг өөрчлөхтэй холбоотойгоор “Онцгой албан татварын тухай хууль” (ОАТТХ) болон “Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хүрээнд архи, согтууруулах ундаанд ногдох онцгой албан татварын хэмжээнд өөрчлөлт орсон. Тодруулбал, өмнө нь 25 градусаас бага, их гэж 2 хувааж авч үздэг байсан бол одоогийн нэмэлт өөрчлөлтөөр градуст татвар ногдуулах эрхзүйн орчин бүрдээд байна. Бас нэг өөр зохицуулалт нь ОАТТХ нь өсөн нэмэгдэх байдлаар буюу 2023-2025 онд, 2025-2027 онд өөр хувь, хэмжээгээр ногдохоор зохицуулалт хийгдсэн байгаа юм.



Хууль зүй, дотоод хэргийн
яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга
Э.Энххуяа


Хууль зүй, дотоод хэргийн сайд гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийг биеүүлж ажилладаг. Энэ хүрээнд Ерөнхийлөгчийн зарлиг болон зарлигийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох хууль эрхзүйн өөрчлөлтийн биелэлтийг хангах чиглэлд “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай” хуулийн дагуу “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан”-ын журмыг батлаж, үүний дагуу сайдын тушаалаар бүрэлдэхүүнийг батлаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Мөн энэ дагуу архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ автомашин жолоодож буй хувь, хэмжээ өндөр байгаа асуудалд хуулийн зохицуулалтыг чангатгах чиглэлд мөн ажиллаж байна.



Наркологийн эмнэлгийн дарга
Д.Ганбат:

Манай байгууллагад жилдээ 2500-3000 хүн эмчилгээ хийлгэдэг. Хэлэлцүүлгээр эмчилгээний чанар, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зэрэг олон асуудал яригдаж байна. Бид өнгөрсөн жил Цагдаагийн ерөнхий газартай хамтран “Итгэл” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Энэ жил 900 иргэнийг хамруулан зохион байгуулахаар ажиллаж байна. Архи согтууруулах ундаатай холбоотой асуудалд маш олон байгууллага хамтарсан бодлого боловсруулж байж үр дүнд хүрдэг. Түүнчлэн манай улсад мансуурлын мэргэшсэн мэргэжилтэн байхгүй” хэмээсэн юм.

Энэ удаагийн хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд “Согтууруулах ундааны эрүүл мэнд, нийгмийн хор хөнөөлийг бууруулах чиглэлд Эрүүл мэндийг дэмжих сангаас сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа”, Татварын ерөнхий газрын татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга Р.Мягмаржав “Согтууруулах ундаанд ногдуулах орлогын албан татвар, борлуулалт”, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Т.Оростогоо “Архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчил /харьцуулсан судалгаа”, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн ерөнхий захирал В.Баярмаа “Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, донтох эмгэгийн үеийн тусламж үйлчилгээ”, Гаалийн ерөнхий газрын хяналт бүрдүүлэлтийн газрын гаалийн улсын байцаагч Л.Амартүвшин “Импорт, экспортын согтууруулах ундааны биет хэмжээ, өөрчлөлтийн төлөв”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Исгэлтийн үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Оюунгэрэл “Монгол Улсын исгэлтийн салбарын өнөөгийн байдал, үйлдвэрлэл” илтгэлийг тавьж Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга О.Чимэдсүрэн цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар мэдээлэл хийлээ.





ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг



Согтууруулах ундааны шалтгаант эмгэг ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт хэлэлцүүлэг боллоо



Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг, дагалдах хуулиудад орсон өөрчлөлтийн хэрэгжилт, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэв



Шинэ жилийн баярыг угтан худалдаа, үйлчилгээний салбарын төлөөлөлтэй уулзаж, архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг нийтэд сурталчлах чиглэлд санал солилцов



“Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах нь” салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулав 20231009



Хан-Уул дүүргийн удирдлагын багтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав 20231024



Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Та татгалз” арга хэмжээг эхлүүлэв 20230918



Нөлөөллийн ажлууд



Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ЦЕГ-тай хамтран “Намайг алгас” ухуулга, арга хэмжээг зохион байгуулав. 2022.11.11-2022.12.02



“Архигүй Цагаан сар” арга хэмжээг зохион байгуулж “Цагаан сарын баярын ширээний гарын авлага” гаргах мэдээлэл сурталчилгааны ажлыг сар шинийн баярыг угтан зохион байгууллаа



ЭРЧҮҮД ЭМЭГТЭЙЧҮҮД 9,5 ЖИЛЭЭР БАГА НАСЛАЖ БАЙНА 20230310

Цэргийн баяраар эрчүүдийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээ нэмэгддэг ба үүнийг дагаад гэмт хэрэг, осол гэмтлийн тоо өсдөг байна. Урьдчилан сэргийлэх зорилгоор энэ жилийн “Монгол цэргийн өдөр”-ийг угтан Монгол эрчүүдийн эрүүл мэндийн асуудлыг нийгмийн анхаарлын төвд оруулж, шийдвэр гаргах түвшинд энэ асуудалд онцгой анхаарах шаардлагатай байгааг Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, АУ-ны доктор Т.Мөнхсайхан мэдээллээ.



Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд архи, согтууруулах ундааны сөрөг нөлөөллийг таниулах зорилгоор Парламентын мэтгэлцээний тэмцээнийг 6 их, дээд сургуулийн оюутнуудын дунд амжилттай зохион байгууллаа. 20231002



Шинэ жилийг угтан аж, ахуй нэгж, албан байгууллагуудыг тэмдэглэлт баярын өдрүүдэд архи, согтууруулах ундааны хэрэглээгээ зохистой хэрэглэхийг уриалах зорилго бүхий “Архигүй шинэ жил – Та татгалз” арга хэмжээг зохион байгуулав. 20231201 – 20231231

Г.АРСЛАНХУЯГ:

Цагдаагийн Ерөнхий газрын
Урьдчилан сэргийлэх газрын
дарга, цагдаагийн хурандаа

**НИЙТЭЭР
ТЭМДЭГЛЭХ БАЯР,
ЁСЛОЛЫН ҮЕЭРХ
ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА 30
ОРЧИМ ХУВИАР
НЭМЭГДДЭГ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготойгоор Цагдаагийн байгууллага, төр, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Намайг алгас”, “Зөвийг зөвлөө”, “Та татгалз”, “Архигүй шинэ жил”

Эдгээр нөлөөллийн ажлуудын хүрээнд иргэд, олон нийтийн архины талаарх буруу ташаа ойлголтыг залруулах, архи, согтууруулах ундааны нөлөөллийг таниулах олон талт мэдээлэл сурталчилгааны ажлуудыг өргөн хүрээнд зохион байгуулсан нь үр дүнгээ өгч, иргэдийн зүгээс ч энэхүү арга хэмжээнүүдийг дэмжин цахим орчинд найз, нөхөд хамт олноо уриалах байдлаар оролцож байна. Жишээлбэл, “Намайг алгас” арга хэмжээний хүрээнд архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт, хэрэг зөрчил, дуудлага, мэдээлэл 1000 нэгжээр буурсан. Энэ нь цагдаагийн байгууллагад ирж буй дуудлага 1000 ширхгээр буурсан гэж ойлгож болно. Үүний ард олон олон гэмт, хэрэг, хүчирхийлэл гээд гарч болзошгүй аюулууд бий.

Эдгээр соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд иргэд, олон нийтийн дунд архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээ, дадлыг бий болгох, хорт зуршлаас ангид шинэ үеийн залуусыг бий болгохоор Цагдаагийн байгууллага, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд манлайлан оролцож байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ Т.МӨНХСАЙХАН :

Ерөнхийлөгч зарлиг гаргаж, хэрэгжилтийн үр дүнд эхний 8 сарын байдлаар согтууруулах ундааны хэрэглээ 2,2 сая литрээр буюу 12,5 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан. Бид нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг баяр, ёслолын үеэрх архи, согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглээг иргэд, олон нийт, аж ахуй нэгжийн хүрээнд багасгаж, зохистой хэрэглээ, соёлтой хэрэглээг бий болгоход та бүхнийг уриалж байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ Б.ДАВААДАЛАЙ:

Монгол Улсын Төрийн тэргүүн “Эрүүл Монгол хүн” хэмээх томоохон хөдөлгөөнийг эхлүүлж, энэ хүрээнд эхний ээлжинд согтууруулах ундааны эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг дахь нөлөөллийг бууруулахаар онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Үндэстнээрээ бид хамтарч архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг бий болгож, залуу, хойч үедээ зөв, соёлтой хэрэглээний дадлыг хэвшүүлэхэд та бүхнийг уриалж байна.



МҮХАУТ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ЭНХТҮВШИН:

Би архи хэрэглээгүй 15 жил болж байна. Анх хэрэглэхээ болих үед хүмүүс их шахдаг байлаа. Сүүлийн үед архиар шахдаг явдал эрс багассан байна. Архи, согтууруулах ундааны нөлөөллийн ажлуудыг ААН, иргэд хүлээж аваад өөртөө, амьдралдаа өөрчлөлт хийх хүмүүс их бий гэж харж байна. Нийтийн эрх ашгийн төлөө танхимын зүгээс архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд хамтран ажиллахад бэлэн гэдгээ хэлмээр байна.



ФИЛОСОФИЧ С.МОЛОР-ЭРДЭНЭ:

Эмэгтэйчүүдийн сүргийн архидалт нь эрчүүдээ бараг давах гээд байна. Тэгэхээр бид сүрэг, сүргээрээ архиддаг, сүргийн архидалтаас татгалзах хэрэгтэй. Монголчууд баярыг буруу тэмдэглэдэг. Шинэ жилийн баяр бол гэр бүлээрээ хамт хооллодог сайхан баяр. Гэтэл манайхан албан газрын, найз нөхдийн, ангийн гэх мэт нэрийдлээр зүгээр л мөнгө үрж, архиддаг.



ЦЕГ-ЫН “ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” ХЭЛТСИЙН ДАРГА О.ОДОНБААТАР:

Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт энгийн өдрүүдэд 1500-1700 орчим дуудлага ирдэг бол баяр ёслолын үед 30 хувиар нэмэгдэж 2000 орчим дуудлага ирдэг. Үүний шалтгаан нөхцөлийг авч үзвэл архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэд гэмт, хэрэг зөрчилд өртөх, гэмт хэргийн холбогдогч болох нь түгээмэл байдаг. Аливаа тэмдэглэлт баяр, ёслолыг архигүйгээр тэмдэглэх, хэрэглэсэн тохиолдолд зохистой, хэтрүүлэн хэрэглэхгүй байхыг уриалж байна



**ТАО
ТАТГАЛЗ!**

**АРХИГҮЙ
ШИНЭ ЖИЛ!**



**ДЭМБ-ЫН МОНГОЛ УЛС ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ
ДР СОКОРРО ЭСКАЛАНТЕ:**

"Архи, согтууруулах ундааг ямар ч хэмжээгээр хэрэглэсэн эрүүл мэнд,
нийгмийн харилцаанд эрсдэл учруулдаг"

ГССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ:

"Гэмтлийн эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдийн 30-40% архины шалтгаант осол
гэмтлийн тохиолдол байна. Нийтээр тэмдэглэдэг баярын үеүдээр архи,
согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхгүй байхыг уриалж байна"



"ГОЁЛ-2024" НААДМЫН ТОП МОДЕЛЬ А. САЙХАНТАМИР:

"Архи, согтууруулах ундааны зүйлс хүний амьдралд сайн зүйл авч ирдэггүй.
Аливаа баярыг тэмдэглэхдээ утга учиртай тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс
архигүй баяр, ёслолоо тэмдэглэж хэвшихийг уриалж байна "



Б.ГАНТУЛГА "СЕО" КЛУБИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ:

Албан байгууллагын соёл нь ажиллагсдаа өөрийн үзэл бодол, шинэ санал
санаачлага, шүүмжлэлээ илэрхийлэх нээлттэй орчныг бий болгох хэрэгтэй.
Ажилчдаа хамруулсан арга хэмжээнд согтууруулах ундаа хэрэглэхгүй, архинд
ямар нэг төсөв, зардал гаргахгүй байхаар төсөвлөж хэвшихийг уриалж байна.



ХӨТЛӨГЧ Э.БИЛЭГНОМ:

"Баяр гэдэг бол гэр бүлээрээ хамтдаа байх, цагаа хамтдаа зугаатай өнгөрүүлэх,
бие биедээ илүү хайр халамж гаргах ийм л агуулгатай, зорилготой байх ёстой
зүйл"

Б.МӨНХЗУЛ "ЖҮР ҮР" ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

Аж ахуй нэгж, албан байгууллагуудыг тэмдэглэлт баяр, ёслолынхоо үеэр архи,
согтууруулах хэрэглээг багасгахыг уриалж байна.





ТАМХИДАЛТЫН ЭРҮҮЛ МЭНД БА ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ

Эрүүл мэндийн гол эрсдэл болж буй тамхидалтыг бууруулахын тулд бид “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд бодлогын суурь судалгаа хийж, түүнд тулгуурлан хуулийн өөрчлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

Монгол улсад жил бүр тамхины нөлөөнөөс 4300 орчим амь насаа алдаж, үүний 12 хувь нь дам тамхидалтаас үүдэж байна. Тамхидалтын улмаас 801 тэрбум төгрөгийн эдийн засгийн хохирол учирч байгаа нь ДНБ-ийн 2.1 хувьтай тэнцэж байгаа бөгөөд (2020), энэ нь тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгийг эмчлэхэд шууд зардал – 87 тэрбум, тамхинаас үүдэлтэй нас баралт - 496 тэрбум, хөдөлмөрийн чадвар алдалт - ажил таслах, ажлын бүтээмж буурсан – 219 тэрбум төгрөгийн эдийн засгийн хохирол учирч байна. (ДЭМБ тооцоолол) Эдийн засгийн нийт алдагдлын 27 хувийг тамхинаас үүдэлтэй алдагдал эзэлж байна.

Электрон тамхины хувьд Монгол Улс одоог хүртэл хуулийн зохицуулалтгүйн дээр тамхины олдоц их, үнэ маш бага байна. Иймээс тамхидалтын тархалт, түүний эрүүл мэнд, эдийн засгийн нөлөөг бууруулахын тулд “Тамхины хяналтын тухай” хуулийг яаралтай өөрчлөх, Татварт өөрчлөлт оруулах зэрэг бодлогын цогц өөрчлөлт хийхээр бид ажиллаж байна.

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ Е-ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮДЭЛТЭЙ 5,10 ЖИЛИЙН ДАРАА ХАВДРААР ӨВЧЛӨГСДИЙН ҮЕ БИЙ БОЛНО

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулатороор жилдээ 17 мянга гаруй үйлчлүүлэгч ирж үзүүлдэг. Үүний 50 хувиас дээш хувьд нь тамхитай холбоотой өвчлөлөөр ирж байна. Сүүлийн жилүүдэд электрон тамхитай холбоотойгоор уушги, амьсгалын замын өвчлөл, хавдар зэрэг өвчлөлүүд эрс нэмэгдэж байна. Дэлхийн олон улсад электрон тамхийг судлаад багагүй хугацаа өнгөрлөө. Хийгдсэн судалгаануудад электрон тамхи нь уушгийг гэмтээдэг болох нь тогтоогдсон. Электрон тамхи хэрэглэгчид өсвөр насныхан давамгайлж байна. Энэ нь аюулын харанга дэлдэж байна. Энэ нь 5,10 жилийн дараа гэхэд хавдраар өвчлөгчдийн үе гарч ирэхээр харагдаж байна. Иймээс яаралтай ирээдүй, өсвөр үеэ хамгаалах бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Тамхинаас гарахаар таргалаад байдаг, ханиалгаад байдаг гэх зэрэг мэдээллүүд нь буруу ташаа мэдээлэл юм. Тамхи татдаг хүн, татдаггүй хүнээс 25 дахин илүү уушгины хорт хавдраар өвчлөх эрсдэлтэй. Тамхины хэрэглээгээ бодлогоор хязгаарлахгүй бол өсвөр насныхны эрүүл мэнд, гамшгийн хэмжээнд хүрч, аюулын харанга дэлдэхээр хэмжээнд байна. Саяхан гэхэд л манай эмнэлэгт 28 настай залуу уушгины хавдраар нас барлаа. Шалтгаан нь мөн л тамхи. Энэ бол ГАМШИГ шүү дээ.



УНТЭ-ийн Уушги, харшил судлалын төвийн дарга, тэргүүлэх зэргийн эмч - Б.Одончимэг

ТАМХИНД 7000 ГАРУЙ ХИМИЙН ЭЛЕМЕНТ БАЙДГААС 76 НЬ ХАВДАР ҮҮСГЭГЧ

Уушгины хавдраар оношлогдож буй тохиолдол жил бүр өсөн нэмэгдэж байна. Жилдээ 400 тохиолдолд бүртгэгддэг байсан бол одоо 500 даваад бүртгэгдэж байна. Тамхи нь 7000 гаруй химийн элементээс бүрддэг ба үүний 200 гаруй нь хүний эрүүл мэндэд хөнөөлтэй, үүнээс 76 элемент нь хавдар үүсгэгч хүнд металлууд байдаг. Хавдрын тоо өсөөд байна гэж ярьдагч шалтгаан нь тамхи, дам тамхидалтын нөлөө шүү дээ. Бид ямар агаараар амьсгалж байна, дээр нь тамхиар өөрсдийгөө хордуулж байгаа нь үнэхээр аюултай.



Хавдар судлалын үндэсний төвийн дүрс, оношилгооны тасгийн эрхлэгч Э.Хишигдорж:



ЯНЖУУР БОЛОН ЭЛЕКТРОН ТАМХИ НЬ УУШГИНЫ АРХАГ ӨВЧЛӨЛҮҮДИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА

Электрон тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар манай улсад судалгаа бага байна. Хэвтэн эмчлүүлж байгаа тохиолдлуудыг авч үзэхэд шалтгаан нь тодорхойгүй уушгины эмгэгүүд ихээр илэрч байна. Янжуур болон электрон тамхи нь уушгины архаг өвчлөлүүдийг нэмэгдүүлж байна. Монгол Улсын хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаант өвчлөлд амьсгалын замын өвчлөлүүд багтаж байгаа. Ковид19-оос хойш хүн амын дунд унтаад сэрсэнгүй гэх зэргээр зүрх судасны олон асуудлууд, гэнэтийн үхлийн тоо нэмэгдсэн. Энэ нь тамхи, электрон тамхины нөлөө байхыг үгүйсгэх аргагүй.



УГТЭ-ийн ерөнхий захирал, АУ-ны доктор, Уушгины эмч З.Төмөр-Очир:



Е-ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙНЭ

Олон улсад электрон тамхины нөлөөллийг бууруулах чиглэлд янз бүрийн зохицуулалт хийж буйг судлаж үзэхэд импортоор орж ирэхийг хориглох нь үр дүнд хүрсэн, сайн туршлагауудыг харуулж байна. Дэлхийн 50-иад улсад электрон тамхины худалдааг бүр мөсөн хориглож, хүн амаа хамгаалж байна. ДЭМБ-аас тамхины хэрэглээг хязгаарлах, хөнөөлийг бууруулах чиглэлд тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулах, татвараар зохицуулах, татварын орлогоос олсон орлогоо тамхины хөнөөлийг бууруулах чиглэлд зарцуулахыг зөвлөж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд бодлогын суурь судалгаа хийж, түүнд тулгуурлан хуулийн өөрчлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, АУ-ны доктор Т.Мөнхсайхан:



ТАМХИНЫ ЭРҮҮЛ МЭНД, ЭДИЙН ЗАСГИЙН ХОР ХӨНӨӨЛ:

ТАМХИДАЛТЫГ БУУРУУЛАХ MPOWER БОДЛОГО:

- Тамхины тахлын эсрэг тэмцэхийн тулд дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын гишүүн орнууд 2003 онд Тамхины хяналтын тухай суурь конвенцийг баталсан. Одоогоор 182 орон энэхүү гэрээнд нэгдээд байна.
- Монгол Улсын хувьд 2003 онд тамхины хяналтын суурь конвенцид нэгдэж, 2005 онд Тамхины хяналтын тухай хууль батлаж, 2012 онд шинэчлэн найруулсан байдаг.
- ДЭМБ-ын MPOWER арга хэмжээ нь Тамхины хяналтын суурь конвенцэд нийцэж байгаа бөгөөд энэ бодлогын чухал бүрэлдэхүүн нь тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах Онцгой албан татварыг нэмэгдүүлэх явдал юм.
- Монгол улсад тамхины үнэ маш хямд, тухайлбал Австрали улстай харьцуулахад 24 дахин бага байна. Тамхины үнэ 3400 төгрөг, үүнд ногдуулах онцгой албан татвар нь 24.5% байгаа нь (ДЭМБ-ын санал болгож буй хувь - 70%) 2.8 дахин бага байна. Иймээс тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлж ДЭМБ-ын санал болгож буй хувьд ойртуулах нь тамхидалттай тэмцэх бодлого болох юм.



World Health Organization

Fig. 3. The state of selected tobacco control policies in the world, 2022





Fig. 1. At least one MPOWER measure at highest level of achievement (2007-2022)



M

Monitoring tobacco use

P

Protecting the public with smoke-free laws

O

Offering help to quit smoking

W

Warning about the dangers of tobacco through pack labels and public awareness

E

Enforcing advertising bans

R

Raising taxes on tobacco.

ТА ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ТАЛААР ЮУ МЭДЭХ ВЭ?

Электрон тамхийг 2003 онд БНХАУ-ын эм зүйч Хон Лик анх зохион бүтээсэн бөгөөд батарейгаар ажилдаг электрон төхөөрөмж юм. Энэ нь батарейгаас гадна нь никотин эсвэл никотины бус шингэний уусмал агуулсан атомжуулагч, хайрцагнаас бүрдэнэ. Төхөөрөмжийг ажиллуулах үед зай нь хайрцагны шингэнийг халааж, атомжуулагч нь шингэнийг ууршуулж, хэрэглэгчийн амьсгалах манан хэлбэрээр ялгаруулдаг. Тиймээс цахим тамхины хэрэглээг вапинг гэж тодорхойлдог.



Эрүүл мэндийн нөлөө:

Электрон тамхины аэрозолд агуулагдах аюултай болон хортой бодис:

- Никотин
- Уушгинд гүнзгий амьсгалах боломжтой хэт нарийн ширхэгтэй тоосонцор
- Уушгины ноцтой өвчинтэй холбоотой химийн бодис болох диацетил зэрэг амт оруулагч
- Дэгдэмхий органик нэгдлүүд
- Хорт хавдар үүсгэдэг химийн бодисууд
- Никель, цагаан тугалга, хар тугалга зэрэг хүнд металлууд

Урьдчилсан судалгаагаар электрон тамхи нь амны хөндийн халдварын эрсдэлийг нэмэгдүүлж, зүрхний титэм судасны өвчин, зүрхний шигдээс, цус харвалт үүсгэхээс гадна залуу хүмүүс болон никотин их хэмжээгээр амьсгалдаг хүмүүст таталт өгөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

2019 онд тамхи татахтай холбоотой уушгины өвчлөл улс орнуудад эрс нэмэгдсэн нь электрон тамхи болон холбогдох төхөөрөмжүүдийн аюулгүй байдлын асуудал нь олон улсад санаа зовоосон асуултыг бий болгов. Электрон тамхины хэрэглээ нь хорт металаар амьсгалснаас үүдэлтэй уушгины ховор өвчин болох хатуу металлын пневмокониозтой холбоотой болохыг 2019 онд нийтэлсэн судалгаа харуулжээ.





ШИНЖЛЭХ УХААНЫ НОТӨЛГӨӨ:

Е-тамхины хэрэглээ өсвөр насныхны дунд асар хурдтай эрс нэмэгдэж байна. Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвийн (CDC) судалгаагаар 2022 онд ахлах сургуулийн сурагчдын 14.1% нь электрон тамхи хэрэглэж байна гэж мэдээлсэн байна. Энэ нь 2017 онтой харьцуулахад ахлах ангийн сурагчдын 11.7% нь электрон тамхи хэрэглэж байгаа гэж мэдэгдсэн байна. Ахлах ангийн сурагчдын дунд явуулсан өөр нэг судалгаагаар 40 гаруй хувь нь электрон тамхи хэрэглэж үзсэн байна. CDC-ийн 2020 оны судалгаагаар 18 ба түүнээс дээш насны 9 сая гаруй хүн электрон тамхи хэрэглэдэг гэсэн дүн мэдээ гарчээ.



Попкорн уушиг болон тамхи татах. “Pop-corn lung,” “Попкорн уушиг” буюу бронхиолит obliterans (BO) нь уушигны үрэвсэл, амьсгал давчдах, ханиалгах, амьсгал давчдах зэрэгт хүргэдэг. Цаг хугацаа өнгөрөхөд уушгины альволд сорви үүсч, амьсгалын зам өтгөрч, нарийсдаг. Е- тамхины олон амтанд агуулагддаг диацетил хэмээх химийн бодис нь энэ эмгэгийн нэг шалтгаан болдог. Энэ нэр нь богино долгионы попкорн үйлдвэрийн ажилчдын дунд диацетилийн улмаас өвчилсөн тухай мэдээллүүдээс үүдэлтэй.



CDC-ийн мэдээлснээр:

Уушгины гэнэтийн болон хүнд хэлбэрийн эмгэг, тэр дундаа тамхи татахтай холбоотой нас баралт нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй холбоотой уушигны гэмтлийг EVALI гэж нэрлэдэг.

- 2020 оны 2-р сар хүртэл EVALI-ийн улмаас 2800 гаруй электрон тамхи хэрэглэгч эмнэлэгт хэвтэх шаардлагатай болсон; Эдгээр хүмүүсийн 68 нь нас баржээ. Ихэнх тохиолдол өсвөр насныхан болон залуучуудын дунд үүссэн байжээ.
- Ихэвчлэн амьсгал давчдах ба/эсвэл цээжээр өвдөх зэрэг шинж тэмдгүүд аажмаар эхэлдэг бөгөөд амьсгал давчдах нь хүндэрч эмнэлэгт хэвтдэг байна.
- Мэргэжилтнүүд EVALI-ийн шалтгаан нь зарим тетрагидроканнабинол (THC) агуулсан электрон тамхинд E витамин (витамин E ацетат гэж нэрлэгддэг) хэлбэрээр бохирдсон гэж таамаглаж байна. Бусад бохирдуулагчид болон бусад хүчин зүйлүүд (уушигны өмнөх өвчин гэх мэт) мөн үүрэг гүйцэтгэдэг.



Е- ТАМХИНЫ ХОРИГ:

- Дэлхийн 47 орон е - тамхийг хориглоод байна.
- Франц улс 2023 оны 9 сарын 3-нд хориглохоор төлөвлөж буйгаа зарласан.
- Англи улсын орон нутгийн зөвлөлүүдийн мэдээлснээр е-тамхины хаягдал асуудал үүсгэж, гал түймрийн аюул учруулж, өсвөр үе, хүүхдүүд хэтэрхий их татаж байгаатай холбоотойгоор 2024 оноос хориглохоор төлөвлөж байна. (долоо хоног бүр 1.3 сая вап хаягддаг). Их Британид е-тамхийг хориглох дуу хоолой улам бүр нэмэгдэж Хамгийн сүүлд Уэльсийн засгийн газар Их Британийн засгийн газраас арга хэмжээ авахыг уриалав.


Тамхи худалдаалахыг хориглосон улс, хотууд:

- Шинэ Зеланд – 2009 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд тамхи худалдаалахгүй- smoke-free” by 2025
- АНУ-ын Калифорни муж 2007 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд тамхи худалдаалахгүй
- АНУ-ын Массачуссет муж 2000 оны 1 сарын 1с хойш төрсөн хүүхдэд
- Австрали – 2000 оноос хойш төрсөн хүүхдэд

ФРАНЦ УЛСЫН ЖИШЭЭ

- ПАРИС, 9-р сарын 3 (Ройтерс) - Франц улс нэг удаагийн электрон тамхийг хориглохоор төлөвлөж байна гэж Францын Ерөнхий сайд Элизабет Борне Ням гарагт RTL радио станцад мэдэгдэв. “Энэ бол нийгмийн эрүүл мэндийн чухал асуудал” гэж Борне хэлээд засгийн газар тамхины хэрэглээтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд Францад жилд 75,000 хүн нас бардаг гэж мэдэгдэв.
- Хүүхдийн амттанг санагдуулам мөстэй чихэр, зефир, бохь зэрэг амттай, е-тамхины үнэ 8 еврогийн (6.85 фунт)-12 еврогийн үнэтэй тамхиныуд өсвөр насныхныг онилж байгаад санаа зовж байна.

- Францад тамхины лангуун дээр зарагдаж байгаа электрон тамхины үнэ ойролцоогоор 9 евро буюу 20 ширхэг тамхинаас ч бага байна. Нэг электрон тамхи нь ойролцоогоор 600 ширхэг янжууртай тэнцдэг гэв.
- Францын Үндэсний Анагаах Ухааны Академи тэднийг “Ялангуяа хүүхэд, өсвөр насныханд зориулсан зальтай урхи” гэж тодорхойлов.
- Тамхины эсрэг холбоо (ACT)-ийн мэдээлснээр 13-16 насны хүүхдүүдийн 13 хувь нь ядаж нэг удаа “сорох” оролдлого хийсэн бөгөөд 11-12 настайгаасаа анх сорж эхэлдэг гэжээ.
- “Тамхины үйлдвэр хүүхдүүдийг онилох гэж ийм бүтээгдэхүүн гаргасан нь аймшигтай. Энэ нь тахал болжээ” гэж ACT-ийн ерөнхийлөгч Лоик Жоссеран хэлэв.
- Францын эмч нар, байгаль орчны мэргэжилтнүүд энэ оны эхээр Le Monde сонинд “Энэ бол байгаль орчны тахал” гэж бичжээ. Тэдний судалгаагаар нэг удаагийн электрон тамхи бүр хуванцраар хийгдсэн бөгөөд 0.15 грамм лити агуулсан салдаггүй зайтай бөгөөд мөн никотины давс, хүнд металлын ул мөр агуулсан байна.





О.ЧИМЭДСҮРЭН

МОНГОЛЧУУДЫН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГ БОДЛОГООР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ

44

Тамхины хэрэглээ улам бүр залуужиж, хараа хяналтаас гараад буй. Тэр дундаа e-тамхины хэрэглээг хязгаарлах тал дээр манай улс ямар бодлого баримталж байгаа талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга, АУ-ны доктор, профессор О.Чимэдсүрэнгээс тодрууллаа.



Монгол Улсын хувьд тамхидалт ямар хэмжээнд байгаа талаар ярилцлагаа эхлүүлье.

Монгол Улсын хувьд эрэгтэйчүүдийн 45 хувь, эмэгтэйчүүдийн 5 орчим хувь нь тамхи татдаг. Тамхи татах нас улам залуужиж байгаа бөгөөд бид 2022 онд 6000 орчим оюутнуудыг хамруулан хийсэн судалгаагаар 14 хувь нь утаат, 10.9 хувь нь электрон тамхи татаж байна. Тамхидалт ихсэж байгааг харуулах өөр нэг баримт бол импортоор оруулж, борлуулж буй тамхины хэмжээ юм. 1995 оныг 2020 онтой харьцуулахад 3.8 тэрбум ширхэг янжуурыг импортлосон нь 38 дахин нэмэгдсэн байна. 2022 онд 3.5 тэрбум ширхэг янжуур тамхи, 90.3 тонн электрон тамхийг Монгол Улс импортоор оруулж ирсэн байна.

2023 оны эхний 8 сарын байдлаар 2.2 тэрбум ширхэг, 71.8 тонн электрон тамхи импортоор оруулсан байна. Жилд нэг хүнд 1983 янжуур ноогддог байгаа нь дэлхийд тэргүүлж 17р байрд орж байна.

Дэлхийн хэмжээнд 1.3 тэрбум хүн тамхи татдагийн 80 орчим хувь нь бага, дунд орлоготой орнуудад байгаа бөгөөд тамхи татагчдын дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Дэлхийн бусад улс оронтой харьцуулж харвал манай улсын хувьд эрчүүд 8.3 хувиар (дэлхийн дундаж 36.7- эрчүүд) илүү тамхи татаж байна.

Залуучууд электрон тамхи татах нь ихсэж байна. Электрон тамхи утаат тамхинаас хор хөнөөл бага гэсэн ойлголтын талаар та тайлбарлаж өгнө үү?

Электрон тамхийг 2003 онд БНХАУ-ын эм зүйч Хон Лик анх зохион бүтээсэн. Энэ нь батерейгаар ажилдаг электрон төхөөрөмж бөгөөд никотин (ENDS) болон никотины бус (ENNDS) шингэний уусмал агуулсан атомжуулагч, хайрцагнаас бүрддэг. Төхөөрөмжийг ажиллуулах үед зай нь хайрцагны шингэнийг халааж, атомжуулагч нь шингэнийг ууршуулж, хэрэглэгчийн амьсгалах манан хэлбэрээр ялгаруулдаг. Тиймээс электрон тамхийг vire гэж ч нэрлэдэг. ENDS – буюу никотин дамжуулах системтэй электрон тамхи нь утаат тамхитай ижил, харин ENNDS нь никотингүй хэдий ч төрөл бүрийн амт, үнэр оруулагч химийн нэгдэл агуулж тэр нь маш өндөр температурт халж ууршдаг. Иймээс аль аль нь эрүүл мэндэд хор хөнөөлтэй. Электрон тамхины аэрозол буюу татах үед амьсгалаар дамжих утаа мананцарт аюултай болон хортой бодисууд олноор агуулагддаг. Жишээ нь никотин, уушгинд гүнзгий амьсгалах боломжтой хэт нарийн ширхэгтэй тоосонцор, уушгины ноцтой өвчинтэй холбоотой химийн бодис болох диацетил зэрэг амт оруулагч, дэгдэмхий органик нэгдлүүд, хорт хавдар үүсгэдэг химийн бодисууд, никель, цагаан тугалга, хар тугалга зэрэг хүнд металлууд байгаа нь олон судалгаагаар батлагдсан. Электрон тамхи хэрэглээнд ороод 20-д жил болж байгаа ч шинжлэх ухаан өндөр хөгжсөн энэ үед тамхидалттай холбоотой судалгаа зэрэгцэн хийгдэж олон нотолгоо бий болсон учраас электрон тамхи нь утаат тамхинаас ч дутахгүй эрүүл мэндэд хортой нөлөөтэй.

Тамхидалтаас шалтгаалсан өвчлөл, эндэгдэл хир байна вэ?

Тамхи нь хэрэглэгчдийнхээ тэн хагасыг нь амь насыг хөнөөж дэлхийн хэмжээнд жил бүр



“МОНГОЛ УЛСАД ЖИЛ БҮР ТАМХИНЫ НӨЛӨӨНӨӨС 4300 ОРЧИМ АМЬ НАСАА АЛДАЖ, ҮҮНИЙ 12 ХУВЬ НЬ ДАМ ТАМХИДАЛТААС ҮҮДЭЖ БАЙНА”

8 сая хүн нас бардаг. Тамхи татдаг хүн татдаггүйтэй харьцуулахад 10-12 жил богино насладаг, хүн амын 15%-50% дан тамхидалтад өртдөг. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн 3 - 5.3 хувийг тамхины шалтгаант эмгэгийн тусламжид зарцуулдаг.

Монгол улсад жил бүр тамхины нөлөөнөөс 4300 орчим амь насаа алдаж, үүний 12 хувь нь дам тамхидалтаас үүдэж байна. Тухайлбал уушгины хавдар, зүрх судас болон амьсгалын замын өвчнүүдийн дийлэнх нь буруу зан үйл ялангуяа тамхидалтаас үүдэлтэй байдаг. ДЭМБ-ын тооцооллоор Монгол улсад тамхидалтын улмаас 801 тэрбум төгрөгний эдийн засгийн хохирол учруулж байгаа нь ДНБ 2.1 хувьтай тэнцэж байна (2020). Энэ зардлыг задлаад үзвэл тамхинаас үүдэлтэй өвчний эмчлэх шууд зардалд 87 тэрбум, тамхинаас үүдэлтэй нас баралт -496 тэрбум, хөдөлмөрийн чадвар алдалт - ажил таслах, ажлын бүтээмж буурсан – 219 тэрбум төгрөгийн зардал гарч байна. Эдийн засгийн нийт алдагдалын 27 хувийг тамхинаас үүдэлтэй алдагдал эзэлж байна. Монгол улсад тамхины үнэ маш бага байдаг. Нэг хайрцаг янжуурыг 3800 төгрөгөөр авч өдөрт 1 хайрцаг татдаг бол сард 114000 төгрөг, жилд 1.2 сая төгрөгийг тамхинд зарцуулж байна. Электрон тамхи нь үнэ өндөр учраас үүнээс ч илүү төгрөг зарцуулахаар байна.

Тамхидалтыг бууруулахын тулд ямар ажил хийх шаардлагатай вэ?

Тамхидалтыг нэг төрлийн тахал гэж үздэг, яагаад гэхээр маш олон хүн тамхи татаж түүний шууд ба шууд бус нөлөөгөөр олон сая хүн эндэж байна. Тамхины тахлын эсрэг тэмцэхийн тулд ДЭМБ-ын гишүүн орнууд 2003 онд Тамхины хяналтын тухай ДЭМБ-ын суурь конвенцийг (ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц) баталсан. Одоогоор 182 орон энэхүү гэрээнд нэгдэж байна. ДЭМБ –аас MPOWER гэсэн санаачлагыг улс орнууд хэрэгжүүлэхийг уриалж, олон орнууд амжилттай хэрэгжүүлж байна. MPOWER арга хэмжээ нь тамхины хэрэглээ болон түүнээс урьдчилан сэргийлэлтийг хянах (M), хүмүүсийг тамхины утаанд өртөж хордохоос хамгаалах (P), тамхийг хаяхад нь туслах, санал болгох (O), тамхины хор хөнөөлийг анхааруулах (W),

тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны хоригийг хэрэгжүүлэх (E), тамхин бүтээгдэхүүний татварыг нэмэгдүүлэх (R) гэсэн 5 багц үйл ажлаас бүрддэг. Энэ бодлогын чухал бүрэлдэхүүн нь тамхи, тамхин бүтээгдэхүүнд ноогдуулах Онцгой албан татварыг нэмэгдүүлэх юм. Монгол улсын хувьд 2003 онд тамхины хяналтын суурь конвенцид нэгдэж, 2005 онд Тамхины хяналтын тухай хууль батлаж, 2012 онд шинэчлэн найруулсан байна. Монгол улсад тамхины үнэ маш хямд, тухайлбал Австрали улстай харьцуулахад 24 дахин бага байна. Тамхины үнэ 3400, үүнд ноогдуулах онцгой албан татвар нь 24.5% байгаа нь (ДЭМБ 70%) 2.8 дахин бага байна. Иймээс тамхи, тамхин бүтээгдэхүүнд ноогдуулах онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлж ДЭМБ санал болгож буй хувьд ойртуулах нь тамхидалттай тэмцэх бодлогын чухал шийдэл юм.

Электрон тамхины хэрэглээг хэрхэн зохицуулж байна вэ?

Монгол улсын хувьд Тамхины хяналтын тухай хуульд электрон тамхины зохицуулалт тусгагдаагүй, энэ бүтээгдэхүүн нь электрон бараа нэрээр импортоор орж ирдэг ба тамхин бүтээгдэхүүнд ноогдуулах Онцгой албан татварт ч хамрагдахгүй байгаа. 2022 онд 90.3 тонн электрон тамхи Монгол Улсад импортоор орж ирсэн байна. Энэ тамхины хэрэглээ тасралтгүй нэмэгдэж, дотоод орчинд ер нь хаа сайгүй татаж байгаа учраас дам тамхидалтад ч хүмүүс их өртөж байна. Иймээс хуулийн зохицуулалтыг нэн яаралтай хийх нь чухал. ДЭМБ –аас электрон тамхины зохицуулалтын талаар а) худалдаалахыг хориглох б) хэсэгчилэн хориглон зохицуулах гэсэн 2 хэлбэрийг санал болгодог. Өнөөдрийн байдлаар дэлхийн 47 орон е - тамхийг хориглосон, Их Британи, Франц зэрэг улсууд 2024 оноос электрон тамхийг хориглохоо зарлан уриалсан. Шинэ Зеланд – 2009 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд, АНУ-ын Калифорни муж 2007 оны 1 сараас хойш төрсөн хүүхдэд, АНУ-ын Массачуссет муж 2000 оны 1 сарын 1-нээс хойш төрсөн хүүхдэд, Австрали Улс 2000 оноос хойш төрсөн хүүхдэд тамхи худалдаалахгүй байх шийдвэр гарсан байна. Тиймээс бид олон улсын сайн туршлагыг судлаж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.





ЭРҮҮЛ МЭНД БА АРХИ, ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн хөгжил, шилжилтээс хамааралтай эерэг, сөрөг олон өөрчлөлт гарсан. Тухайлбал, сүүлийн 20 жилийн хугацаанд хүн амын тоо 2.4 саяас 3.3 сая буюу жилд дунджаар 1.7 хувиар өсжээ. Энэ хугацаанд хүн амын дундаж наслалт 70-д хүрч 7.6 жилээр уртассан боловч хүн амзүйн энэхүү өсөлт хүйсийн хувьд ялгаатай байгаагийн нэг нотолгоо нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ойролцоогоор 9 жилээр богино насалж байгаагаас харж болно. Хүн амын дундаж наслалтад гарсан ялгаатай байдлыг нэмэгдүүлж буй гол шалтгаан нь урьдчилан сэргийлэх боломжтой хорт хавдар, зүрх судасны өвчлөл, цус харвалт зэрэг халдварт бус өвчний (ХБӨ) дарамт юм.

Олон улсын өвчний дарамтын судалгаагаар Монголчуудын нас баралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлд 30 гаруй жилийн өмнө тамхины хэрэглээ 4-рт шалтгаан байсан бол 2020 он гэхэд тамхи 2-р шалтгаан, архи 4-р шалтгаан болж өөрчлөгдсөн байна.

Манай улс тамхины хяналтын тухай хуулийг анх 1993 он, Архидан согтуурахтай тэмцэх тухайн хуулийг 2001 онд баталсан. Түүнчлэн Тамхины хяналтын суурь конвенц (2003 оноос хойш), Тамхины хяналтын үндэсний хөтөлбөр (2013-2021), Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр (2003-2012) зэрэг чухал бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлсэн.

Гэвч хүн амын дундах архи, тамхины хэрэглээний тархалт дорвитой буурахгүй байгаа нь “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын шаталсан судалгаа” (2005, 2009, 2023, 2019), Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгаа (2009, 2013) харагдаж байна. 100 мянган хүн амд ноогдох архины шалтгаант нас баралт 2.5 дахин нэмэгдсэн бол тамхины шалтгаант нас баралтын тоонд өөрчлөлт гараагүй байна.



АРХИ, ТАМХИНЫ ОНЦГОЙ АЛБАН ТАТВАР

Олон улсын туршлага, зөвлөмжөөс харахад архи тамхины хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй хөтөлбөрт онцгой албан татварыг эрчимжүүлэх орж байна.

Манай улсын хувьд 2007 оноос эхлэн архи, тамхинд онцгой албан татвар ноогдууж, 4-5 жил дутамд онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлж ирсэн.


Жишээ нь ижиглэнгийн үнэд эзлэх тамхины онцгой татварын хэмжээг 2018 онд 10%, 2019-2021 онуудад дундажаар жилийн 5% өсөлттэй байхаар хуульчилсан байна. Энэхүү бодит өсөлтөөс шалтгаалан ижиглэнгийн үнэд эзлэх тамхины татварын хэмжээ 50% байгаа нь ДЭМБ-ын онгой татварын эзлэх хувь хамгийн багадаа 70% байх гэсэн зөвлөмжийг биелүүлэхэд хүндрэл учруулж байна.

Олон улсад тамхины үнийг 10 % нэмэгдүүлэхэд архиын тархалт залуучуудын дунд 5-15%, насанд хүрэгчдийн дунд 5-7% буурдаг болохыг тогтоосон байна.

2021 оны байдлаар хүн амын дунд хамгийн өргөн хэрэглэдэг 38% хатуулагтай 750мл хэмжээтэй цагаан архинд жижиглэнгийн үнэ 18 мянган төгрөг байсан бөгөөд үнийн 29 хувь нь онцгой албан татвар эзлэж байсан.

Жижиглэнгийн үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг 40, 50, 60 хувь хүртэл хэмжээнд хүргэхийн тулд суурь татварын хэмжээг 5220 төгрөгөөс 9500, 14355 болон 21820 төгрөг хүртэл тус тус нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн тооцоог хийсэн.

Түүнчлэн архинд ноогдуулах ОАТ-ын хэмжээг нэгж стандарт уулт эсвэл тухайн согтууруулах ундааны градус (хатуулаг) суурилан ноогдуулах хувилбаруудыг боловсруулсан.





Согтууруулах ундаа	Борлуулалтын үнэд эзлэх онцгой албан татварын хувь	Согтууруулах ундааны онгой татварын хувилбарууд			Хүлээгдэж буй үнийн өөрчлөлт	Хүлээгдэж буй архины хэрэглээний бууралтын хувь
		Нэгж стандарт уултанд ноогдор үнэ	Нэгж хатуулагт ноогдох татвар ₮	Онгой албан татвар ₮		
Шар айраг (450 мл, Alc 5.5%)	Суурь он 6.6%	960	29	158	2,400	
	20%	1214	110	606	3,034	-6%
	30%	1402	192	1055	3,504	-9%
	40%	1650	301	1654	4,125	-13%
Цагаан архи (750 мл, Alc 38%)	Суурь оны 29%	632	137	5,220	18,000	
	40%	832	250	9,500	23,710	-11%
	50%	1,008	378	14,355	28,726	-18%
	60%	1,276	574	21,820	36,353	-27%

Хүснэгт 1. Архины татварын бодлогоос гарах хүлээгдэж буй үр дүн, хэрэглээний бууралт

Үзүүлэлт	Төрөл	Биет нэгж	Суурь үзүүлэлт 2022он	Зах зээлийн үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг өөрчлөх хувилбарууд			
				50%	60%	70%	80%
Өргөн хэрэглэж буй тамхины зах зээлийн үнэ	Янжуур (Дотоод)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	2,500	3,336	4,164	5,593	8,436
	Янжуур (Гадаад)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	4,000	5,170	7,929	10,688	16,122
	Электрон тамхи	1 мл шингэн	8,500	17,000	21,000	28,500	41,500
Тамхинд ноогдуулсан ОАТ-ын хэмжээ	Янжуур (Дотоод)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	836	1,672	2,500	3,929	6,772
	Янжуур (Гадаад)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	836	2,006	4,765	7,521	12,958
	Электрон тамхи	1 мл шингэн	--	8,500	12,500	20,000	33,000
Үнэд эзлэх ОАТ %	Янжуур (Дотоод)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	0,33	0,50	0,60	0,70	0,80
	Янжуур (Гадаад)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	0,21	0,50	0,60	0,70	0,80
	Электрон тамхи	1 мл шингэн	-	0,50	0,60	0,70	0,80
Татвайн өмнөх үнэ	Янжуур (Дотоод)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	1,664	1,664	1,664	1,664	1,664
	Янжуур (Гадаад)	1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур	3,164	3,164	3,164	3,164	3,164
	Электрон тамхи	1 мл шингэн	8,500	8,500	8,500	8,500	8,500

Хүснэгт 2. Тамхинд эзлэх ОАТ-ын хэмжээг 50%, 60%, 70% болон 80% хүртэл нэмэгдүүлэх тооцоолол

ЭРЛЭГТ “ЗАМЧЛАХ” ЭЛЕКТРОН ТАМХИАР ОХИД, ЗАЛУУС “ГАНГАРЧ” БАЙНА



О.БАТ-УНДРАХ
Өнөөдөр сонины тоймч,
Эрүүл мэндийн сэтгүүлч

Утаат тамхинаас татгалзаж, электроныг сонгосон хүмүүс хорт зуршлаа бүрмөсөн хаяж чаддаг болов уу? Үүнийг асуухын учир нь утаат тамхи он удаан жил хэрэглээд электроныг сонгосон хүмүүсийн олонх нь эл хоёрын аль алиныг нь хаяж чадахгүй, зэрэг донтон эрүүл мэндээ ноцтойгоор хордуулах болсон жишээ олширч. Хослон хэрэглэгчид олон нийтийн газар буюу утаат тамхи хориглосон орчинд электроныг уугуулчхаад, бусад үед нь нөгөөхөө өөрийн мэдэлгүй зуучихсан явдаг аж. Тэгвэл эл хоёр хорыг зэрэгцүүлэн хэрэглэх нь уушгийг түргэн гэмтээж, богино хугацаанд хавдарт, цаашлаад үхэлд ч хүргэх эрсдэлтэйг олон улсад хэдийн судалж, тогтоочихоод буй билээ. Иймд насанд хүрэгчид утаат тамхинаас гарахаар шийдсэн л бол аль болох электроноос татгалзах, орлуулж хэрэглэсэн тохиолдолд богино хугацаанд хаях шаардлагатайг мэргэжлийн эмч нар зөвлөж байна.

Электрон тамхины үүнээс ч муу жишиг, буруу хэвшил эдүгээ өсвөр насныханд илүүтэй тогтож буйг тоохгүй өнгөрч болохгүй. Бидний ирээдүй болсон хүүхэд, багачууд өнөөдөр электрон тамхины хор хөнөөлийг огтхон ч мэдэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл, хүнсний дэлгүүрүүдийн лангуун дээр чихэр шиг л зарагдаж буй электрон тамхины, энэ тогтолцооны золиос нь тэд болсоор буй гэсэн үг юм.

Электрон тамхи хэрэглэгч өсвөр үеийнхний нас ч улам залуужиж, хүйсийн ялгаа ч ажиглагдахаа больсныг ерөнхий боловсролын сургуулийн багш нар ноцтой анхааруулж, сэрэмжлүүлсээр удлаа. Харамсалтай нь, үүнийг зохицуулах хууль, эрх зүйн орчин манайд одоогоор алга. Хөөрхий хэдэн багш нар нь л олон нийтэд, эцэг, эхчүүдэд хандаж, электрон тамхины хэрэглээг хянаж, хязгаарлахыг цахим орчинд уриалсаар...

Утаат тамхинаас гаргадаг гэх эл бүтээгдэхүүний хор уршгийг мэргэжлийн байгууллагууд олон нийтэд төдийлөн сурталчилж, хүргэхгүй байна. Тиймээс энэ талаарх мэдээлэлгүй иргэд, ялангуяа өсвөр насныхан электрон тамхийг “гангараа” мэтээр ойлгоод байна шүү дээ. Монголд өмнө нь тус барааг цахимаар захиалан, арилждаг

байхад өнөөдрийнх шиг хэрэглээ нь ингэтлээ хавтгайраагүй байсныг учир мэдэх хүмүүс хэлсээр буй.

Электрон тамхины хор хөнөөлийг сурталчлах ёстой мэргэжлийнхэн нь энэ мэт ажлаа хийхгүй болохоор борлуулагчид нь гаарч, эл бүтээгдэхүүнийг хоргүй, никотингүй, утаат янжуураас гаргах шалгарсан арга хэмээн олны “тархийг угаасаар” буй. Электрон тамхи дам тамхидалтыг бууруулдаг ч найрлагад нь никотин (донтуулах), карсиноген (хавдар үүсгэгч), бензол (хорт хавдар тусах эрсдэлийг нэмэгдүүлдэг), акролеин (хогийн ургамал устгахад ашигладаг бөгөөд уушги гэмтээх аюултай), диацетил (уушгины өвчин үүсгэх эрсдэлтэй) зэрэг хорт бодис ордгийг хэлээд, анхааруулаад өгчих эмч, судлаач ч цөөн аж. Мөн донтуулагч бодис нь өөр төрлийн хорт зуршилд өдөөгдөх үндэс болох аюултай гэнэ. Энгийнээр хэлэхэд, хогийн ургамал устгахад ашигладаг хорт бодис агуулсан электрон тамхийг хүүхэд, залуус баруун, солгойгүй хэрэглэж, түүгээр “гангарч” байна гэдэг дэндүү эмгэнэлтэй.

Дээр хэлсэнчлэн, хүмүүс утаат тамхинаас татгалзаж, цаашлаад бүрмөсөн орхих зорилгоор электроныг хэрэглэдэг ч хорт зуршлаа хаясан хүн тун цөөн байдгийг америкчууд хэдийн судалж тогтоожээ. Гэтэл манайд эрэлт нь улам нэмэгдсээр, тэр хэрээр импортлогчид ч олширч, улмаар хуурамч, орц, найрлага нь тодорхойгүй бүтээгдэхүүнүүд хяналтгүй зарагдах болсныг мэргэжилтнүүд анхааруулж буй. Улсын хилээр хэдэн арван тонноор нь импортлож буй нь ч үүнийг гэрчлэх буй за. Электрон тамхинд янжуур шиг онцгой албан татвар ногдуулдаггүйгээс гадна хилээр нэвтрүүлэхдээ импортлогчид цахилгаан хэрэгсэл, төхөөрөмж зэрэг нэрээр оруулдаг нь их хэмжээгээр, хяналтгүй зарах шалтгаан болсоор байна.

Аюул дагуулсан энэ хорт бүтээгдэхүүнээс хүүхэд, залуусаа хамгаалахын тулд Тамхины хяналтын тухай хуульд холбогдох мэргэжлийнхэн нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулж буй юм билээ, уг нь. Электрон тамхинд онцгой албан татвар ногдуулан, импортыг хянаж, хэрэглээг нь хязгаарлахад чухал ач холбогдолтой эл төслийг нийтээр дуу нэгтэй дэмжиж, бодит ажил болгоосой гэж олон ч хүн хүсэж байна даа.



СУДАЛГААНЫ АЖЛУУД БА ҮР НӨЛӨӨ ЗУРГААН НАСТНУУДЫН ДУНДАХ ЗҮРХНИЙ ЭМГЭГ ИЛРҮҮЛЭХ СУДАЛГАА

Манай улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл, зүрх судас, хавдар, амьсгалын тогтолцооны өвчин хамгийн өндөр хувийг эзэлж байна. 2021 оны байдлаар нас барсан 3 хүн тутмын нэг нь зүрх, судасны тогтолцооны өвчнөөр нас барж байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаар жилд 5.7 мянган хүн бүртгэгдэж, нийт нас баралтын 33.7 хувийг эзэлж буй тоо баримт бий. Тэгвэл энэ асуудлыг эрт үед нь оношилж, шаардлагатай арга хэмжээг авахаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрүүл зүрх” судалгааны ажлыг эхлүүлж орон нутагт Увс, Архангай амьгуудад, нийслэлд Хан-Уул дүүрэгт жишиг байдлаар зургаан настай хүүхдүүдийн дунд зүрхний эмгэг илрүүлэх үзлэг, оношилгоо судалгааг 2022,2023 онд хийж хэрэгжүүлээ.



УВС, АРХАНГАЙ АЙМАГ

Зүрхний эмгэгийн илрүүлэх “Эрүүл зүрх” үйл ажиллагааг 2022 онд Увс, Архангай аймгуудад хэрэгжүүлж, 2800 орчим зургаан настай хүүхдүүдийг үзлэгт хамруулсан. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 170 хүүхдэд зүрхний цахилгаан бичлэгээр өөрчлөлт илэрч, үүнээс 12 хүүхэд зүрхний мэс засал хийх шаардлагатай нь оношлогдсон байна. Эдгээр хүүхдүүд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт тусламж үйлчилгээгээ авч, бүрэн эдгэрсэн.

ЯПОН УЛС

Зүрхний эмгэгийн илрүүлгийг Япон улсад мөрдөж буй зааврыг удирдамжийн дагуу хийж байгаа бөгөөд тус улсад 2012 онд хийгдсэн зүрхний илрүүлгийн судалгаагаар нийт хүүхдийн 3.3%-д зүрхний эмгэг илэрч, 0.99%-д эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байв. Харин манай улсын хувьд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг зүрх судасны өвчлөл, нас баралтыг бууруулахад сургуульд суурилсан эрүүл мэндийн илрүүлгийг бага ангиас эхлэн зохион байгуулж, хүн амыг эрүүлжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх нь зайлшгүй шаардлагатай байгаа талаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хариуцан ажиллаж буй АУ-ны доктор Т.Мөнхсайхан эмч хэлсэн юм.


ХАН-УУЛ ДҮҮРЭГ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-уул дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран сурагчдын эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээнд Хан-Уул дүүргийн Төрийн өмчийн Ерөнхий боловсролын 23 сургуулийн 4635 сурагчдын 78,6 хувийг буюу 3644 зургаан настай хүүхдийг зүрхний эмгэгийн илрүүлэгт хамрууллаа.



ДҮГНЭЛТ:

- ХУД-ийн ЕБ-ын 21 сургуулийн үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн бие, бялдрын үнэлгээг Америкийн нэгдсэн улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (Center for Disease Control and Prevention)-өөс гаргасан зааврын дагуу өсөлтийн муруйгаар эрэгтэй, эмэгтэй хүйсэд ялгаатай байдлаар биеийн жингийн индексээр перцентелиэр үнэлсэн ба нийт үзлэгт хамрагдсан 3644 хүүхдийн 66.8% (n=2436) нь хэвийн, 15.4% (n=563) нь илүүдэл жинтэй, 12.4% (n=452) нь таргалалттай, 5.3% (n=193) нь жингийн алдагдалтай, хүүхэд эзэлж байна. Таргалалт, жингийн илүүдэлтэй хүүхдүүд нийт хүүхдүүдийн 27.8% (n=1015) буюу тархалт өндөр байна.





Ц.ТӨМӨР-ОЧИР

ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧЛӨЛ 3-4 ДАХИН НЭМЭГДЭХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА

Манай улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл, зүрх судас, хавдар, амьсгалын тогтолцооны өвчин хамгийн өндөр хувийг эзэлж байна. 2021 оны байдлаар нас барсан 3 хүн тутмын нэг нь зүрх, судасны тогтолцооны өвчнөөр нас барж байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаар жилд 5.7 мянган хүн бүртгэгдэж, нийт нас баралтын 33.7 хувийг эзэлж байна. Үүний шалтгаан нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга замын талаар Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ)-ийн захирал Ц.Төмөр-Очиртой ярилцлаа.

52
ЯРИЛЦЛАГА



УГТЭ нь Зүрх судасны лавлагаа төв эмнэлгийн үүргийг үндэсний хэмжээнд гүйцэтгэдэг. Өнөөдрийн байдлаар та бүхний ажлын нөхцөл байдал, ачаалал ямар байна вэ?

Бид зүрх судасны чиглэлээр маш өндөр ачаалалтай ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын тушаалаар УГТЭ нь зүрх судасны лавлагаа, төв эмнэлгийн үүргийг үндэсний хэмжээнд гүйцэтгэдэг.

Хэдийгээр бусад эмнэлгүүдэд зүрх судасны чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлж байгаа хэдий ч манай эмнэлгийн ачаалал жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Дэлхий хүн амын өвчлөл эндэгдлийн тэргүүлэх шалтгаан зүрх судасны өвчлөл болоод байгаа ба олон улсын судалгаа, тоо баримтаас үзвэл 2030 он гэхэд зүрх судасны өвчлөл, түүнээс шалтгаалсан нас баралт 3-4 дахин нэмэгдэх тооцоолол бий. Манай улсад ч мөн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан нь зүрх судасны өвчин. Хөгжиж байгаа болон өндөр хөгжилтэй бүх улс оронд Зүрх судасны үндэсний төвийг ажиллуулж, энэ чиглэлд анхаарч ажиллаж байна.

Зүрх судасны үндэсний төвийг барьж, байгуулах асуудал олон жил яригдсан. Танай эмнэлгийг түшиглэж байгуулагдах энэ ажил хэрэгжих эхлэл тавигдсан гэж ойлгоод байгаа. Энэ талаар та мэдээлэл өгөхгүй юу?

Тийм ээ, Зүрх судасны үндэсний төвийг байгуулах асуудал цоо шинэ зүйл огт биш юм. Сүүлийн 20 гаруй жил тусгайлсан зүрх судасны үндэсний төвийн барилга, байгууламж байхгүй ч гэсэн “Зүрх судасны төв”-ийг УГТЭ-т суурилан байгуулж, үйл ажиллагаа явуулж ирсэн. Манай улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болдог зүрх судасны өвчлөлийг бууруулахад Монгол Улсын Ерөнхийлөгч анхаарал хандуулснаар төр, засгийн хэмжээнд бодлогоор дэмжин өнгөрсөн оны 11 дүгээр сард Япон улсын “Токушюүкай медикал групп”-тэй Ерөнхийлөгчийн Тамгын газар зүрх судасны үндэсний төвийг байгуулах санамж бичиг үйлдсэн нь томоохон ахиц болж чадлаа. Энэ хүрээнд Монгол Улсад “Зүрх судасны үндэсний төв”-ийг УГТЭ-ийг түшиглэн барьж байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, түүнчлэн монгол эмч, мэргэжилтнүүдийг Япон улсын өндөр хөгжилтэй эмнэлгүүдэд мэргэшүүлэх, дадлагажуулах, сургах ажлууд тусгагдсан. Зүрх судасны чиглэлээр Монголд эмчлэх боломжгүй өвчнийг эмчилдэг болох тал дээр Япон улсын өндөр түвшний зочин, профессоруудтай хамтарч ажиллах, зайлшгүй гадагш явж эмчлүүлэх шаардлагатай иргэдийг Япон улсад эмчлүүлэх тал дээр тусалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэлүүд мөн тусгагдсан. Эдгээр ажлын гүйцэтгэлд Монгол, Японы талууд эрчимтэй ажиллаж байгаа.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зурагдсан дээрх санамж бичигт тусгагдсаны дагуу манай улсаас 10 эмч, мэргэжилтэнтэй баг, бүрэлдэхүүн саяхан Япон улсын “Токушюүкай медикал групп”-ийн зүрх судасны чиглэлийн шилдэг 10 эмнэлэгт туршлага судлах, санал солилцох уулзалтыг хийгээд ирсэн.

Олон улстай харьцуулахад манай улсын эмч нарын мэргэжлийн ур чадвар ямар түвшинд үнэлэгддэг вэ?

Өнөөдөр өндөр хөгжилтэй орнууд тухайлбал Англи, Америкийн зүрх судасны оношилгоо, эмчилгээнд шинээр гарсан стандарт, удирдамжийг манай эмнэлэгт хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс дэлхий нийтийн авч хэрэгжүүлж буй удирдамж заавраас хоцроогүй гэж хэлж болно.

Зүрх судасны өвчин үүсгэх суурь шалтгаан болон урьдчилан сэргийлэх талаар та мэдээлэл өгөхгүй юу?

Энэ өвчний суурь шалтгаан болох тамхидалт манай улсад маш өндөр хувьтай, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, таргалалт, хөдөлгөөний хомсдол, архидалт зэрэг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдсээр байна. Үүнээс үүдэлтэй цусны даралт ихсэх асуудал үүсдэг. Бидний саяхан хийсэн судалгаагаар хүн амын талаас илүү хувь нь цусны даралт ихсэх асуудалтай гэдгээ мэдэхгүй байх жишээтэй. Цусны даралт ихсэх өвчнөөс шалтгаалан тархины цус харвалт, зүрхний шигдээс гэх мэт асуудлууд үүсэж цаг бусаар нас барах нь их байна.

Харин үүнээс урьдчилан сэргийлэхэд иргэний эрүүл мэндийн хариуцлага л хамгийн чухал юм. Манайд энэ асуудал бүрэн хэвшээгүй, өвдсөн хойноо эрүүл мэндийн салбар, эмч, эмнэлэг буруутай мэт, эмчлэх ёстой, үүрэгтэй, иргэний эрүүл мэндийг бүрэн хариуцах ёстой гэсэн хандлага түгээмэл байна. Хувь хүнээс шууд 100 хувь хамаарах зүйл гэдгийг ойлгуулахад хэвлэл мэдээллийн үүрэг мөн чухал байна.



С.ЭНХЦОЛМОН: ЗҮРХНИЙ ОЛДМОЛ ГАЖИГ НЬ ИХЭВЧЛЭН АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ АХУЙ ХАНГАЛТГҮЙН УЛМААС ҮҮСДЭГ

Хүүхдийн зүрхний төрөлхийн гажиг нь зүрхний таславчийн маш жижиг цоорхой, хавсарсан хүнд хэмжээний гажгууд зэрэг бүх хэлбэрээр дан ганц зүрхний өөрчлөлт эсвэл бусад эрхтний гаж хөгжил, удамшлын хам шинжүүдтэй хавсарч тохиолдоно.

Харин зүрхний олдмол гажиг нь ихэвчлэн амны хөндийн эрүүл ахуй хангалтгүй буюу шүд цоорхой, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл, ханиад хатгалгааны хүндрэл байдлаар үүсдэг.

Зүрхний эмгэгийг хүүхэд насанд эрт оношлуулж эмчилж, чадаагүйгээс хөдөлмөрийн насанд зүрхний үйл ажиллагааны дутагдалд орох, тархинд цус харвах, гэнэт нас барах гэх мэт олон хүндрэлүүд үүсэх эрсдэлтэй.

- 6 нас хүртэлх хүүхдийн шүдийг өдөрт 2-оос доошгүй удаа угааж өгч, цаашид өөрөө бие дааж угаах дадалд сургах
- Хүүхдийн хооллодог аяга халбага тавгыг тусад нь хэрэглүүлэх, хүүхдэдээ амнаасаа хоолыг дамжуулж өгөхгүй байх. Ингэснээр гүйлсэн булчирхайн архаг үрэвслээс сэргийлэх боломжтой.
- Хэрэв хүүхдэд нь уйлах, гүйх гэх уушгинд ачаалал өгөх үед амьсгаадах, цонхийх, бөөлжих, хөхрөх гэх мэт шинж илэрч байвал эмчид хандаж, үзлэг оношилгоо, зүрхний цахилгаан бичлэг, зүрхний хэт авиан оношилгоо, цээжний рентген зураг, компьютер томографи, судсан доторх оношилгоо, шинжилгээг хийлгэж оношлуулах.

ДАДАЛД

• СУРГАХ НЬ: •




ЭМЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

С.Энхцолмон Хүүхдийн эмч



Хүүхдийн нас бага байх тусам дархлалын систем бүрэн гүйцэд хөгжөөгүй байдаг тул улирлын чанартай ханиад томуу, гэдэсний халдварт өртөмхий байдаг. Хэрэв хүүхэд жингийн өөрчлөлтэй буюу тураалтай, таргалалттай, цус багадалт, сульдаа, харшилтай гэх мэт суурь өвчлөлтэй бол бусад хүүхдүүдтэй харьцуулахад өвчлөлд илүү өртөмхий, хүндрэх хандлагатай байна. Хэдий хүүхэд насанд хүрэгчидтэй харьцуулахад илүү өвчлөмтгий байдаг ч ханиад томуунаас сэргийлэх, хүндрүүлэхгүй байх боломжтой.



Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх дадлууд:

- Ямар ч дадал зуршлыг хүүхдэд хэвшүүлэхийн тулд эцэг эхчүүд өөрсдөө үлгэр дуурайл үзүүлж, өөрсдөдөө тухайн дадлыг суулгах хэрэгтэй.
- Гаднаас орж ирсэн, аливаа бохир зүйлд хүрсэн тохиолдолд гараа савандаж угааж хэвших
- Хүүхдийнхээ ам хамрын ойролцоо үнсдэггүй байх, нялх хүүхэдтэй бол гаднаас орж ирээд ам зайлах уусмалаар амаа зайлж хэвших
- Хүүхдийн малгай ороолтыг 7 хоног бүр угаадаг байх
- Хүүхдийг хэт их бэгнэж, халууцуулалгүй хувцаслалтыг тохируулах
- Хэрэв таны хүүхэд цэцэрлэгийн насны хүүхэд бол цэцэрлэгт явахын өмнө ба цэцэрлэгээс ирэнгүүт хоолой зайлах уусмалаар амыг зайлуулж сургах
- Улирлын томуугаас сэргийлэх дархлаажуулалтыг ерхийн гишүүн бүр жил бүр хийлгэж, ханиад томууны хүндрэлээс сэргийлэх (Жич: Томуугийн дархлаажуулалт нь томуу тусах давтамжийг багасгахаас гадна томуугийн хүндрэлээс сэргийлэх ач холбогдолтой)
- Хүүхдэд ханиадны шинж тэмдэг илэрч эхэлсэн бусдад халдвартай эхний өдрүүдэд аль болох хүүхдийг гэрт нь асрах, шингэн хангалттай уулгаж, шим тэжээлтэй хоол өгөх, аль болох амраах хэрэгтэй.
- Ханиад томууны үед хүүхдийн дархлалын хамгаалах тогтолцоо ханиад томууны эсрэг тэмцэж, халуурч эхлэх үед эцэг эхчүүд ХҮҮХДИЙН ХАЛУУНЫГ сайтар хэмжиж, 38.0 градусаас ихгүй үед халуун бууруулах эмийг аль болох хэрэглэлгүй, хувцасыг нимгэлэх, шингэн бага багаар уулгах, толгой хэсэгт чийгтэй алчуур тавих гэх мэт аргыг хэрэглэж халууныг буулгаж чадвал таны хүүхдийн ханиадны эдгэрэлтийн хугацаа 2 дахин богиносгох боломжтой. Эцэг эхчүүд дөнгөж ажиллаж эхэлсэн бие мах бодын дархлалын тогтолцооны хариу урвалыг эхнээс нь гажуудуулснаас цаашид хүүхдийг насан туршид нь өвчлөлтгүй болгох эрсдлийг өөрсдөө бий болгодог. Иймд хэрэв та эцэг эх болсон л бол **ГЭРТЭЭ ХАЛУУНЫ ШИЛТЭЙ БОЛОХ** хэрэгтэй.
- Хүүхдийг эрт унтуулах: Хүүхдийн нойр хангалттай, 22 цагаас өмнө унтснаар дархлаа тогтолцоо хэвийн ажиллах, өсөлтийн даавар ялгарах боломжтой. Иймд хүүхэдтэйгаа хамт эрт унтаж сурах шаардлагатай.
- Чихэрлэг хүнс, ундаа, бэлэн бүтээгдэхүүн хэрэглэх нь хүүхдийн амны хөндийг өвчлүүлэх, ходоод гэдэсний замыг хямраах, харшил төрүүлэх, хоолны дуршил бууруулах хор нөлөөтэй тул аль болох бага хэрэглүүлж, эцэг эх нь өөрсдөө мөн татгалзах хэрэгтэй.



Н.БАЯРМАА

БҮХ ХҮҮХДИЙГ ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН ИЛРҮҮЛЭГТ ХАМРУУЛМААР БАЙНА

Хүүхдийн зүрхний гажиг нярай хүүхдэд хамгийн элбэг тохиолдох хөгжлийн гажиг юм. ДЭМБ-ын шинжээчдийн хийсэн судалгаанаас харвал, долоо хоног хүртэлх нярай хүүхдийн дунд зүрхний төрөлхийн эмгэг нэгдүгээрт эрэмбэлэгджээ. Манай улсад 2011 онд 70 328 эх амаржсанаас 405 нярай хүүхэд төрөлхийн хөгжлийн гажигтай байсан нь нийт төрөлтийн 0.6 хувийг эзэлжээ. Үүнээс зүрхний төрөлхийн гажиг хамгийн их буюу нийт оношлогдсон тохиолдлын 29 хувьтай тэнцсэн байна.

Түүнчлэн Т.Болормаа нарын судлаачид 2012-2013 онд нярайн амьдралын эхний 6-48 цагийн дотор зүрхний хэт авианы шинжилгээнд тулгуурлан хийсэн тандалт судалгаагаар зүрхний төрөлхийн гажиг нийт амьд төрсөн нярайн 2.42 хувьд нь оношлогдсон байна. Эдгээрийн 10 хувийг зүрхний төрөлхийн хавсарсан хүнд гажиг эзэлжээ. Манай улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болох зүрх судасны өвчлөлийг эрт үед нь илрүүлж эмчлэх талаар Улсын гуравдугаар төв эмнэлгийн хүүхдийн зүрхний эмч Н.Баярмаатай ярилцаж, тодрууллаа.

Манай улсад хүүхдийн зүрхний эмгэг, гажгийн чиглэлээр хийгдсэн сүүлийн үеийн судалгаа, тоо баримт бий юу?

2014 онд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-өөс 10 мянган нярайд хийсэн зүрхний гажгийн судалгаанаас үзэхэд дэлхийн үзүүлэлтээс өндөр буюу 2.72 хувьтай гарч байсан. Энэ нь магадгүй ЭХЭМҮТ-д улсын хэмжээнд хамгийн хүнд төрөлт хүлээн авдагтай холбоотойгоор гарсан үзүүлэлт байж болох юм. Мэргэшсэн буюу нярайн зүрхний гажгийг оношлох чадвартай эхо хардаг эмч, мэргэжилтэн манай улсад гарын 10 хуруунд багтахаар цөөхөн байна. Эдгээрээс ихэнх нь ЭХЭМҮТ-д ажилладаг ба цөөн тооны эмч хувийн эмнэлэгт ажиллаж байна. Орон нутагт ажиллах энэ чиглэлийн эмч, мэргэжилтнүүд маш ховор байгаагаас үүдэн энэ чиглэлийн нарийвчилсан судалгааг улсын хэмжээнд хийхэд хүндрэлтэй л дээ. Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Зүрхний цахилгаан бичлэг (ЗЦБ)-т суурилсан зүрхний гажиг илрүүлэлтийн судалгааг өнгөрсөн онд хоёр аймагт хэрэгжүүлж,



”

**“СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЗУРГААН
НАСТНУУДЫН 10 ХУВЬ НЬ ЗҮРХНИЙ ЭМГЭГЭЭР
ОНОШИЛОГДОЖ БАЙНА”**

зургаан настай хүүхдүүдийг хамруулан үр дүнг үнэлсэн.

Судалгааны дүнгээс хуваалцвал?

- Увс, Архангай аймагт нийтдээ 2700 гаруй хүүхдийг хамруулж, ЗЦБ хийснээс 200 орчим хүүхдэд өөрчлөлт илэрч, үүнээс 12 хүүхдийг яаралтай байдлаар мэс засалд оруулан, үүсэж болох эрсдэлээс хамгаалж чадсан. Одоо эдгээр хүүхдүүд бүрэн эдгэрсэн, эрүүл болсон. Бид зүрхний эмгэгийн илрүүлгийг Япон улсад мөрдөж буй заавар, удирдамжийн дагуу хийсэн бөгөөд тус улсад 2012 онд хийгдсэн зүрхний илрүүлгийн судалгаагаар нийт хүүхдийн 3.3%-д зүрхний эмгэг илэрч, 0.99%-д эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байв. Мөн хүүхдийг зургаан настайд нь сургуульд ороход нь ЗЦБ-ийн илрүүлэгт хамруулж, эрүүл иргэнийг бэлтгэдэг байна. Сургуулиа төгсөх хүртэл 4 удаагийн ЗЦБ хийж тогтмол хянадаг байх жишээтэй. Харин манай улсын хувьд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг зүрх судасны өвчлөл, нас баралтыг бууруулахад сургуульд суурилсан эрүүл мэндийн илрүүлгийг бага ангиас эхлэн зохион байгуулж, хүн амыг эрүүлжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж хүүхдийн зүрхний эмчийн хувьд харж байна. Мөн үүнийг орон даяар хийх бүрэн боломжтой, хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнтэй илрүүлгийг хийх арга юм.



Таны хэлж буй Зүрхний цахилгаан бичлэгийг улс даяар хэрхэн зохион байгуулах вэ, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хувьд боломжтой гэж та харж байна уу?

ЗЦБ-ийг сум, өрхийн эмнэлгийг түшиглэн хийх боломжтой ба эмч, сувилагч хэн ч бай үүнийг хийх бүрэн боломжтой. ЗЦБ-ийн аппарат маань тийм ч үнэтэй биш Ковидоос өмнө хамгийн сайн аппарат гэхэд 3 сая орчим төгрөгийн үнэтэй байсан бөгөөд аймаг, сумын эмнэлэг бүрт бий. Хэрэглэгдэх цаас маань нэг ороомог нь 100 хүүхдэд ашиглагддаг ба нэгжийн үнэ нь 3000-5000 төгрөгийн үнэтэй. Нэг суманд 100 хүүхэд байхгүй шүү дээ. Тэгэхээр 2,3 сумын хүүхдүүдийг үзчих боломжтой юм. Жишээлбэл, сумын эмнэлэгт ЗЦБ-ийг хийгээд аймаг, улс руу нарийн мэргэжлийн эмч нар руу илгээж, уншуулаад түүнээсээ өөрчлөлттэй хүүхдүүдээ ялгаж, шаардлагатай хүүхдүүдийг нарийвчилсан оношилгоонд оруулж, дараа дараагийн арга хэмжээг авах замаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой гэж харж байна.

Таны хэлж буйгаар Монгол Улсын хэмжээн дэх 80 мянга орчим зургаан настай хүүхдийг ЗЦБ-т хамруулах бүрэн боломжтой юм байна. Гэтэл үүнийг яагаад хийж хэрэгжүүлэхгүй байгаа юм бол?

Одоо л хийж эхлээд байна. Сургуульд суурилсан байдлаар буюу нэгдүгээр ангид орох хүүхдүүдийг нэгдсэн журмаар ЗЦБ-ийн илрүүлэгт хамруулбал улсын хэмжээнд үр дүнтэй ажил болно гэж харж байна.

Эмч ээ, хүүхдийн зүрхний эмгэг, гажгийг гаднаас нь хараад мэдэх боломжтой юу?

Монгол улсад хүүхдийн нас баралтад хүүхдийн төрөлхийн зүрхний гажууд илүүтэй байр суурийг эзэлдэг. Нярайн зүрхний гаж хөгжлийг аль болох эрт үед нь илрүүлж, эмчлэх юм бол үр дүнтэй байдаг ч хожуу оношлогдох нь их байна. Ээж аав, асран хамгаалагч нарын хувьд хүүхдээ гаднаас хараад анзаарах зүйл бол их амьсгаадах, хөлрөх, хөхөө хөхөж байхдаа амрах, жингээ нэмэхгүй байх зэрэг шинж тэмдгүүдийг ажиглаж болно. Үүнээс жингээ нэмэхгүй байх нь түгээмэл тохиолддог ба энэ тохиолдолд та хүүхдийн зүрхний эмчид яаралтай хандах хэрэгтэй. УГТЭ-ийн Хүүхдийн амбулаторид хот, хөдөө орон нутаг гэж ялгалгүй, ажлын өдрүүдэд ажлын цагаар үзүүлж болно гэдгийг хэлмээр байна.

Ярилцсанд баярлалаа.

Т.НЯМ-ОЧИР

СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООНЫ СУУРЬ ТАВИГДЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улс орон даяар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан алба болон тус хөдөлгөөнийг хариуцан ажиллаж буй Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайханаар ахлуулсан ажлын хэсэгтэй Боловсрол Шинжлэх ухааны сайд А.Энх-Амгалан болон холбогдох албаныхан сургуульд суурилсан эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бий болгох асуудлаар хамтарч ажиллаж байна.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 28.10-д ЕБС-ийн сурагчдын эрүүл мэндийн хяналт, тандалтын




БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР

тогтолцоог нэвтрүүлэх чухал заалт тусгагдлаа. Өөрөөр хэлбэл энэ хуулийг баталснаар, бидний урьдчилсан төлөвлөгөөгөөр сурагчдыг 6,9,12,15 насанд нь эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг сургуульд суурилан зохион байгуулах юм.

Өөрөөр хэлбэл бид ирээдүй болсон залуусынхаа эрүүл мэндийг өвдөхөөс нь урьдчилан сэргийлэх чиглэлд илүүтэй анхаарч ажиллана. Сурагчдад сурлагын дүн тавьдагтай адилаар эрүүл мэндийг нь тогтмол хянаж, урьдчилан сэргийлнэ.

МОНГОЛ УЛСАД ЗҮРХ, СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛНА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Япон улсын “Токүшюүкай медикал групп”-ийн дэмжлэгтэйгээр Монгол улсад Зүрх, судасны төв байгуулахаар талууд 2022 оны 12 сард хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж үйл ажиллагаа эхлээд байна.

Энэ тухай Санамж бичигт талуудыг төлөөлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, Япон Улсын “Токүшюүкай медикал групп”-ийн Ерөнхийлөгч Хигашиүэ Шиничи нар гарын үсэг зурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд дээрх санамж бичгийн хүрээнд талууд:

- Улсын Гуравдугаар төв эмнэлгийг түшиглэн Зүрх, судасны төв байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах;
- Монгол Улсад оношилж чаддаггүй эмгэгүүдийг зөв оношилж, эмчилгээ хийх чиглэлээр монгол эмч нарт мэргэжил эзэмшүүлэх, боловсон хүчин бэлтгэх;
- Монгол Улсад эмчлүүлэх боломжгүй зарим өвчнийг Япон Улсад оношлуулах, эмнэл зүйн тусламж авах, Япон Улсын нарийн мэргэжлийн эмч нар сургалт хийх зэргээр хамтран ажиллана.

Шаардагдах зургаа хүртэл тэрбум иений санхүүжилтийг Япон Улсын “Токүшюүкай медикал групп” бүрэн хариуцах юм.

ЗҮРХ, СУДАСНЫ ТӨВ БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД 10 ЭМЧ ЯПОН УЛСАД АЖИЛЛАЛАА



Япон улсын “Токүшюүкай медикал групп”-тэй Монгол улсад Зүрх, судасны төв байгуулах ажлын хүрээнд эмч мэргэжилтэнг сургах, чадавхжуулах зэрэг олон талд ажлууд хэрэгжих юм. Энэ хүрээнд манай улсаас эхний 10 хүний бүрэлдэхүүнтэй эмч нарын баг “Токүшюүкай медикал групп”-д туршлага судлах зорилгоор 2023 оны 1 сарын 22 -29-ий өдрүүдэд ажиллаад ирлээ. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг хариуцан ажиллаж буй Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, АУ-ны доктор Т.Мөнхсайхан ажлын айлчлал хийх багтай уулзаж хамтран ажиллах чиглэлийн талаар нарийвчилсан удирдамж өгч ажиллалаа.



Зүрх, судасны үндэсний төв байгуулах ажлын хүрээнд Япон улсын Эрүүл мэндийн сайд, Ноён Кацүнобу Катотай уулзаж, санал солилцлоо 20230214-19



Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн зургаан настай хүүхдүүдийг зүрхний эмгэг илрүүлэгт хамрууллаа 20230317



“Эрүүл зүрх” төслийн багийн уулзалт



М.УНДРАМ

ЧИХЭРЛЭГ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ ТАРГАЛАЛТ БА ЗАРИМ АРХАГ ӨВЧИН ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛӨХ НЬ



Манай улсын хүн амын чихэрлэг ундааны хэрэглээ ямар түвшинд байгаа талаар та мэдээлэл өгөхгүй юу?

Бид 2017 онд чихэрлэг ундааны зах зээлийн ба онцгой татварын тооцооллын судалгаа, 2018-2019 онд хүүхэд, өсвөр үеийнхний илүүдэл жин, таргалалтад үзүүлэх чихэрлэг ундааны нөлөөллийн судалгаа, 2022 онд Монгол Улсын хүн амын чихэрлэг ундааны хэрэглээний судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн. Манай улсын хувьд, нэг хүнд өдөрт 367 мл, сард 11.1 л чихэрлэг ундаа ногдож байгаа нь зөвхөн түүнээс авч буй чихрийн хэмжээ нь ДЭМБ-ийн зөвлөмж хэмжээнээс даруй 3 дахин их байна.

ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ гэдгийг та тодруулахгүй юу?

Хүний наснаас хамааран хоногт авах илчлэг өөр өөр бөгөөд хоногийн нийт илчлэгийн 5 хувиас бага хэмжээг чихэрнээс авахыг ДЭМБ-аас зөвлөдөг. Хүүхдийн хоногт хэрэглэх чихрийн зохист хэмжээ нь 4-өөс доош насанд чихэр хэрэглэхгүй, 4-6 насанд 15гр, 7-10 настайд 20гр, 11-ээс дээш насанд 25гр чихэрлэг

бүтээгдэхүүн хэрэглэх нь зохистой гэж зөвлөдөг. Гэтэл нэг уут хүүхдийн бэлгэнд дундажаар 400гр сахар агуулагдаж байгаа нь хүүхдийн 20 өдрийн хэрэглээтэй тэнцдэг.

Чихэрлэг ундаа, бүтээгдэхүүнийг хэтрүүлэн хэрэглэх нь хүний биед ямар нөлөө үзүүлдэг вэ? Эмч ээ

2018-2019 онд бидний хийсэн судалгааны үр дүнгээр хүүхэд, өсвөр насныхны чихэрлэг ундааны хэрэглээ тэдний илүүдэл жин, таргалалтад нөлөөлөх бие даасан хүчин зүйл мөн болох нь тодорхойлогдсон. Судалгааны үр дүнгээс хэдэн жишээг дурдая.

Чихэрлэг ундааны хэрэглээ өдөрт нэг порцоор нэмэгдэхэд таны эрүүл мэндэд:

2-р хэлбэрийн чихрийн шижингээр өвчлөх эрсдэлийг 18 хувиар, зүрх судасны өвчлөлийн эрсдэл 8 хувиар, архины бус шалтгаант элэгний өөхлөлт үүсэх эрсдэл 39 хувиар, тулай үүсэх эрсдэл 4 хувиар нэмэгддэг. Мөн хөхний болон түрүү булчирхайн хорт хавдрын хооронд эерэг хамаарал үүсгэж, хөхний хорт хавдар үүсэхэд илүү хүчтэйгээр нөлөөлдөг ба өөх тосны солилцооны хямрал, зүрх судас, бодисын солилцооны хам шинжийг үүсгэснээр зарим төрлийн хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн судалгаагаар бүдүүн гэдэсний болон нойр булчирхайн хорт хавдар үүсэхэд нөлөөлж байж болзошгүй гэсэн дүгнэлт гарсан.

Харин чихэрлэг ундаанаас шалтгаалсан нас баралтыг авч үзвэл:

өдөрт хоёр ба түүнээс дээш удаа ЧУ уух нь зүрх судасны өвчнөөр нас барах эрсдэлийг 31 хувиар нэмэгдүүлдэг ба өдөрт нэг порцоор нэмэгдэхэд зүрх судасны өвчнөөр нас барах эрсдэл 8 хувиар ихсэж байгааг тогтоожээ.

Түүнчлэн Мексикт 2020 онд хийсэн судалгаагаар насанд хүрэгчдийн нас баралтын 6.9 хувь, АНУ-д зүрх судас, бодисын солилцооны хам шинжтэй холбоотой нас баралтын нийт тохиолдлын 7.4 хувь ЧУ-ны хэрэглээтэй холбоотой болохыг тодорхойлсон байдаг.

Чихэрлэг ундаа, чихэрлэг бүтээгдэхүүнээс үүсэх элдэв өвчлөл, таргалалт, чихрийн шижин зэрэгтэй гадны улс орнууд хэрхэн тэмцэж буй талаар уншигчиддаа хүргэвэл?

ДЭМБ, АНУ, Канадын хоол тэжээлийн удирдамжид бүх төрлийн нэмэлт чихрээс авах илчлэгийг хоногийн нийт илчлэгийн хэрэглээний 10 хувиас хэтрүүлэхгүй байхыг зөвлөмж болгож байна.

Өдгөө дэлхийн 54 улс болон АНУ-ын 7 мужид хэрэглээг бууруулж, халдварт бус өвчинтэй тэмцэх орлогыг бий болгох зорилгоор ЧУ-нд онцгой албан татвар ноогдуулаад байна.

Жишээлбэл, 2014 онд Мексик улс ЧУ-д 10 хувийн онцгой албан татвар ногдуулснаар хоёр жилийн дараа ЧУ-ны борлуулалт 7.6 хувиар буурч, татваргүй ундааны борлуулалт 2.1 хувиар өссөн байна. Загварчилсан судалгаанаас татварын үр нөлөөгөөр ойролцоогоор 200,000 хүнийг таргалалтаас урьдчилан сэргийлж, 2013-2022 оны хооронд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг 980 сая ам. доллароор хэмнэсэн гэж тооцоолсон байна.

Чили улс үндэсний хэмжээнд сургуулийн орчин дахь илчлэг, чихэр, давс, ханасан өөх тос ихтэй бүтээгдэхүүнийг хориглож, бүтээгдэхүүний нүүрэн хэсэгт анхааруулах санамж байрлуулсан анхны улс болсон. Эдгээр бодлогын дүнд чихэр, давс, өөх тосны өндөр агууламжтай бүтээгдэхүүний худалдан авалт бодлого хэрэгжиж эхлэх үетэй харьцуулахад 23.7 хувиар буурсан байна.

Олон улсын сайн туршлагыг Монгол улсдаа хэрэгжүүлэх талаар та бүхэн судлаж үзэв ?

Манай улсын хувьд бидний 2017 онд хийсэн судалгаагаар чихэрлэг ундаанд 10%-ийн онцгой татвар ногдуулснаар хэрэглээ Улаанбаатар хотод 6.8 хувь, орон нутагт 5.7 хувиар буурч, ингэснээр тогтмол хэрэглэгчдийн биеийн жин 3 жилийн дотор 0.6кг хүртэл буурах боломжтой гэж тодорхойлогдсон. Монгол Улсын Их Хурлын гишүүдээс “Онцгой татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2024 оны 1 сарын 1-ээс эхлэн 100 мл тутамд 5 гр болон түүнээс дээш чихрийн агууламжтай ундааны 1 литр тутамд 500 төгрөг, цаашид жил тутамд 25 төгрөгөөр нэмэгдүүлэх заалтуудыг өргөн бариад байна.

Ярилцсанд баярлалаа.





ЗӨВЛӨМЖ: ЧИХЭРЛЭГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ

Чихэр нь жимс, хүнсний ногоо, үр тариа, сүү, сүүн бүтээгдэхүүнүүдэд байгалиасаа хангалттай хэмжээгээр агуулагддаг тул хүн өдөр тутмынхаа хоол, хүнснээс сахарыг зохист хэмжээгээр авдаг гэсэн судалгаа бий. Тиймээс эцэг, эх, асран хамгаалагч та бүхэн бага насны хүүхдийнхээ өдөр тутамд хэрэглэх чихэрлэг бүтээгдэхүүний зохист хэмжээг тохируулан хэрэглүүлэхийг дараах зөвлөмжөөр анхааруулж байна.

- ДЭМБ-ын зөвлөснөөр насанд хүрсэн хүний хоол, хүнснээс авбал зохих элсэн чихрийн хэмжээ өдөрт 20-25 гр байна.
- Насанд хүрэгчдийн нийт нас баралтын 6.9 хувь нь чихэрлэг бүтээгдэхүүний шалтгаантай байна.
- Чихэрлэг бүтээгдэхүүний хэрэглээг өдөрт 1 порц /250 мл орчим/-оор нэмэгдүүлэхэд чихрийн шижингийн 2 дугаар хэвшинжээр өвчлөх эрсдэлийг 18, элэгний өөхлөлтийг 39 хувиар тус тус нэмэгдүүлдэг байна.
- Бүх төрлийн нэмэлт чихрээс авах илчлэгийг хоногийн нийт илчлэгийн хэрэглээний 10 хувиас хэтрүүлэхгүй байхыг ДЭМБ-аас зөвлөмж байна.

Бага насны хүүхдийн дунд тохиолдож буй хоол тэжээлийн дутагдлын дийлэнх хувь нь тэдний зохисгүй хооллолтой холбоотой байдаг. Ялангуяа сахарын замбараагүй хэрэглээ нь хүүхдийг шим тэжээлийн дутагдалд оруулж, тэдний эрүүл саруул өсөж, бойжих нөхцөлийг бууруулж, төрөл бүрийн халдварт өвчин, хоол боловсруулах замын эмгэг, цаашлаад таргалалт, чихрийн шижин, хавдар зэрэг аргаг явцтай өвчнөөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

М.УНДРАМ
АШУУИС-ийн ахлах багш, анагаах ухааны доктор

ТА УУХААСАА ӨМНӨ САЙН БОДООРОЙ

Ус	Хийжүүлсэн ундаа	Энергийн ундаа	Цай, жүс	Хийжүүлсэн ундаа
500мл	330мл	250мл	500мл	500мл
0гр	26гр	27.5гр	36гр	54гр

*Жинс 1 сахарт атог дэлгэж өгч байна.

- Савласан аливаа бүтээгдэхүүний шошгыг заавал нягталж харах нь чихрийн хэрэглээгээ тохируулах хамгийн үр дүнтэй арга юм.
- Хүнс үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ амтыг сайжруулахын тулд элдэв нэр, төрлийн сахар, чихэр агуулсан нэмэлтийг хүнсэндээ хийж, түүнийгээ өөр өөр нэршлээр савлагаан дээрээ бичиж, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх нь элбэг тул нэг бүрчлэн шалгахыг зөвлөө. Жишээ нь, бор бурам, жимсний баяжмал, эрдэнэшишийн амтлагч, сироп, зөгийн бал, инверт чихэр, соёолжны сахар, моласс, ОЗ-аар төгссөн энгийн нүүрс усны молекулууд... гэх мэт. Эдгээрийг чихрийн хэрэглээндээ нэмж тооцон, чихэрлэг бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгахыг зөвлөж байна.

Эх сурвалж: ЕТГ, ЭМЯ, ДЭМБ, АШУУИС

А.АМАРЖАРГАЛ

"Хүнсний хувьсгал" төсөл, хөтөлбөр
хариуцсан албаны дарга
Ерөнхийлөгийн Тамгын газар

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод", "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнүүд нь өөр хоорондоо нягт уялдаатай, үр дүнтэй хэрэгжсэнээр манай улсын тогтвортой хөгжлийн үндэс суурь бүрдэх учиртай.

Өнгөрсөн хугацаанд манай улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар нь ямар ч нөхцөл байдал, эрсдэл тулгарсан дархлаажсан тогтвортой, тасралтгүй, уян хатан эрэлт нийлүүлэлттэй байх ёстой гэдгийг бид сайтар ухамсарласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний 3 хөдөлгөөн нь өөр хоорондоо ус агаар мэт уялдаа холбоотойн адил Монгол хүний эрүүл байх үндсэн суурь бол яах аргагүй хүнсний аюулгүй байдал бүрэн хангагдсан байх юм. Ийм ч утгаараа "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд хүнсний хувьсгалчдын оролцоо маш чухал юмаа.

Хүнсний аюулгүй байдлыг улс орны хэмжээнд бүрэн хангахын тулд иргэн бүрийг орлогын түвшин, нийгмийн давхарга, газарзүйн байрлалаас үл хамааран эрх тэгш гол нэрийн хүнсээр хүртээмжтэй, бүрэн хангагдах боломжийг бүрдүүлэх, хэрэглэгч хүнсээ зөв сонгох, зохистой хэрэглэх боловсролтой байх үндсэн шалгууруудыг биелүүлсэн байх нь нэн тэргүүний зорилт гэж үздэг.

"Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд зорилго 2023 он гарсаар олон улсын шаардлагад нийцсэн мал төхөөрөх 2, мах боловсруулах 2, бяслаг үйлдвэрлэх 7 буюу нийт 11 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна.

Мөн энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ил талбайн хүнсний ногоо 30 хувиар, хүлэмжийн ногоо 27 хувиар, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 орчим хувиар тус тус нэмэгдэх тайлан мэдээ гарч байна.

Ялангуяа жимс жимсгэнэ, хүнсний ногооны нэр төрөл нэмэгдэж, түүхэндээ хамгийн өндөр хэмжээний ургац хураан авч, хүнсний ногооны дотоодын хангамж энэ оны эцэс гэхэд 85 хувь хүртэл нэмэгдэхээр байна.

Түүнчлэн сонгино, саримс, лууван болон өндөгний дотоодын хангамж 2023 онд 3-12 хувиар өсөх тооцоо гарчээ.

Мөн 2023 оны эхний 11 сарын байдлаар махны экспорт эрс нэмэгдэж, 277 сая ам.долларын экспортын орлого оллоо.

Үүний зэрэгцээ манай улсын хүнсний бүтээгдэхүүний импорт 12 хувиар буурсан сайхан үзүүлэлт гарлаа.

Өөрөөр хэлбэл 1 тэрбум гаруй ам.доллаароор гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан манай улс энэ жил 120 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломжийг бүрдүүллээ.



ОЮУТНЫ ХООЛ ХҮНС, ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА

2022-2023 хичээлийн жилд их, дээд сургуульд шинээр элсэгчдийг төлөөлөхүйц түүврийг хамруулан эрүүл мэндийн үзлэг хийх, эрүүл мэндийн мэдээний сан бүрдүүлэх, судалгааны төсөл болон үр дүнг ашиглан “Эрүүл оюутан” хөтөлбөрийн санал боловсруулах зорилтуудын хүрээнд судалгааг явууллаа. Монгол улсын хэмжээнд ойролцоогоор нийт 67 их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаа явуулдаг.

Бид судалгааны түүвэртээ нийслэлээс 6 сургууль, орон нутгаас 2 сургуулийг сонгон санамсаргүй түүвэрлэлтийг явуулсан. Нийслэлийн 6 сургуульд Барилга, технологийн политехник коллеж (БТПК), Монгол Солонгосын политехник коллеж, Техник технологийн политехник коллеж (ТТПК), Шинэ иргэншил мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хүнс, технологийн политехник коллеж (ХТПК)-г хамруулсан бол орон нутгаас Булган, Хэнтий аймгийн МСҮТ-ийг хамруулж судалгаанд түүвэрлэв. Судалгаанд 15-24 насны нийт 1541 оюутан хамрууллаа.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын үндсэн мэдээлэл, гэр бүл төлөвлөлт, гэрлэлтийн байдал, эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн даатгал, хүртээмж, хооллолтын байдал, дасгал хөдөлгөөн, хорт зуршил, эрсдэлт хүчин зүйлс (архи, согтууруулах ундааны хэрэглээ, тамхины хэрэглээ, дэлгэцийн хэрэглээ ба нойрсолтын чанар) зэргийг дээрх оюутнуудын дунд үнэлэв.



ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН

Нийт оюутнуудын 52% нь өдөрт эрчимтэй дасгал хөдөлгөөн 10-с илүү олон минут хийдэг, харин удаах 48% нь хөдөлгөөний идэвхигүй байна.



ЭРҮҮЛ МЭНД

Нийт оюутнуудын 45.6% ЭМДаатгалд хамрагдаагүй, 29.6% хамрагдсан эсэхээ мэдэхгүй байна. Харин 26% нь нийгмийн халамжинд амьдарч байна.







ХООЛ ХҮНС

Өглөөний цайгаа дийлэнх хэсэг буюу 36.8% нь өдөр бүр уудаг, хоол хүнс, хүнсний бүтээгдэхүүний шошго тэмдэглэгээг 31.4% нь байнга, 26.5% заримдаа хардаг ба хоол идэх үеэрээ 38.3% нь давслаг соус, амтлагч зэргийг нэмэлтээр хэрэглэдэг байна.



Цахим төхөөрөмжийн дундааж гар утсыг оюутнууд хамгийн түгээмэл ашигладаг багаад дийлэнх хэсэг нь (26.6%) нь өдөрт 6 с цаг цаг ашиглаж байна. Дэлгэцийн хэрэглээ эрэгтэйчүүдэд өндөр байгаа ба эдгээр нь оюутнуудын орондоо орох хугацаа, нойрсох, алжаал амралтаа авах хугацааг богиносгож, нойрны чанарыг бууруулж, хямралд хүргэхэд нөлөөлж байна. Цааш лавшруулбал нийт оюутнуудын 57.1% нойрны чанар дундаж хувьтай байв.





Судалгаанд хамрагдсан оюутнуудын дийлэнх хэсэг буюу 77.4% нь эрэгтэй, 51.2% цэргийн албан хаагч оюутнууд байна. Оюутнуудын 50.5% нь 2-р дамжаанд, 81.8% нь Халх үндэстэй, 70.7% нь эцэг эхтэйгээ амьдагддаг, 33.2% гэрт, 27.9% нь хашаа байшинд амьдарч байна. Дийлэнх хэсэг (95.5%) нь хараахан гэрлээгүй, 96% нь хүүхэд төрүүлээгүй байна.

Нийт оюутнуудын 52% нь өдөрт эрчимтэй дасгал хөдөлгөөн 10-с илүү олон минут хийдэг, харин удаах 48% нь хөдөлгөөний идэвхигүй байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэй оюутнууд илүү хөдөлгөөний идэвхитэй байгаа нь ажиглагдлаа. Мөн гадуур явах алхалтын тоогоороо эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байв. Иймд хөдөлгөөний идэвхийг илүү нэмэгдүүлэх зорилгоор оюутан залуулт зориулсан спортын клуб дугуйлан, тэмцээн арга хэмжээг илүү өргөн бий болгох, биеийн тамирын ач холбогдолыг ойлгуулан, хичээлийн хуваарьт цагийг нэмэгдүүлэх, мөн ахлах курс, дамжаануудад орох.

Цахим төхөөрөмжийн дундааж гар утсыг оюутнууд хамгийн түгээмэл ашигладаг багаад дийлэнх хэсэг нь (26.6%) нь өдөрт 6 ≤ цаг цаг ашиглаж байна. Дэлгэцийн хэрэглээ эрэгтэйчүүдэд өндөр байгаа ба эдгээр нь оюутнуудын орондоо орох хугацаа, нойрсох, алжаал амралтаа авах хугацааг богиносгож, нойрны чанарыг бууруулж, хямралд хүргэхэд нөлөөлж байна. Цааш лавшруулбал нийт оюутнуудын 57.1% нойрны чанар дундаж хувьтай байв.

Оюутнуудын дундах тамхи, архи согтууруулах ундааны тархалт харьцангуй бага хэдий ч цаашид анхаарч арга хэмжээ авах нь зүйтэй. Хувь хүний амин үзүүлэлт, антропометрээр БЖИ, АГ, зүрх судасны эрсдэл зэргийг үнэлж үзэхэд 69.9% хэвийн жинтэй боловч удааг жингийн дутагдал болон илүүдэл жин нь тодорхой хувийг эзэлж байна. 48.1% хөдөлгөөний дутагдалтай, 31% нойрны чанар муу, 27.3% даралт ихсэлтэй, 23.1% зүрх нь дэлсдэг, 11.1% илүүдэл жинтэй байгаа нь оюутан залуучуудын дундах халдвар бус өвчний өвчлөлийг үүсгэх эрсдэл хүчин зүйлс болж буй учир эдгээрийг бууруулахад чиглэсэн оновчтой интервенци, арга замыг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

Т.МӨНХСАЙХАН:



МАНАЙ УЛСЫН
ХҮН АМЫН

17 ХУВЬ НЬ ИДЭВХТЭЙ
ДАСГАЛ, ХӨДӨЛГӨӨН ХИЙДЭГ



СПОРТ



ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨН

Т.МӨНХСАЙХАН: МАНАЙ УЛСЫН ХҮН АМЫН 17 ХУВЬ НЬ ИДЭВХТЭЙ ДАСГАЛ, ХӨДӨЛГӨӨН ХИЙДЭГ

Та бол эмч хүн мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлого хариуцсан зөвлөхөөр ажилладаг. Дасгал, хөдөлгөөн, спорт бол эрүүл байхын салшгүй нэг хэсэг. Тэгэхээр манай улсын хүн амын хувьд, бид ер нь хэр спортлог ард түмэн юм бэ? энэ тал дээр та бидэнд мэдээлэл өгөхгүй юу?

Таны хэлж байгаачлан дасгал, хөдөлгөөн гэдэг эрүүл амьдралын салшгүй хэсэг. Бид хүн амын дунд дасгал, хөдөлгөөний зөв дадал, эрүүл амьдралын хэв маягийг бий болгосноор олон өвчлөлийн үзүүлэлтийг бууруулах боломжтой юм. Нэг тоо баримт дурдахад манай улсын хүн амын ердөө 17 хувь нь идэвхтэй дасгал, хөдөлгөөн хийдэг, спортоор хичээллэдэг хүмүүс байна. Энэ үзүүлэлтийг Азийн орнуудтай харьцуулахад Ази тивийн дундаж 60 хувь байх жишээний. Өөрөөр хэлбэл Азийн улс орнуудын хүн амынх нь 50 хувиас дээш, 60 хувь нь идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маягаа болгож, эрүүл байж чадаж байна. Иймээс бид 17 хувийг нэмэгдүүлэх чиглэлд Ерөнхийлөгчийнхөө түвшинд онцгой анхаарал хандуулан нийтийн спорт, биеийн тамирыг олон нийтэд сурталчлах, нийтийн дадал болгоход эрчимтэй ажиллаж байна.

Та сүүлийн өгүүлбэрээ нэмэж тодруулахгүй юу?

Монголынхаа хүүхэд, залууст зориулж “Президент” спорт цогцолбор байгуулахаар зураг төсөл боловсруулах ажил 95 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Энэ ажил БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хийгдэх юм.

Ерөнхийлөгч 43 тоот зарлиг гаргасан. Уг зарлигийн хэрэгжилтийн хүрээнд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд сүүлийн 20 жилд хийгдээгүй нэмэлт өөрчлөлт хийгдсэн. 2023 оноос



согтууруулах ундааны градусаас хамааран архины онцгой албан татвар хоёр дахин нэмэгдэж, литр тутмын борлуулалтаас тодорхой хувийг хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн тусламжид зарцуулахаар шийдвэрлэв.

Мөн боловсролын бүх шатны байгууллагаар дамжуулан эрүүл, чийрэг монгол иргэнийг бий болгохоор бодлогын түвшинд олон талын оролцоотой ажиллаж байна. Мөн нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй холбоод, клуб, нийгэмлэгүүдээ дэмжих чиглэлд тэдгээрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах үүднээс үндэсний хэмжээнд, анх удаа “Эрүүл Монгол хүн” фестивалийг зохион байгууллаа. Мөн спортод цаг гаргая, өөртөө цаг гаргая, эрүүл мэнддээ цаг гаргая гэх мэтээр биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах, сэдэлжүүлэх зорилгоор “Цаг гаргая” цахим нөлөөллийн аяныг олон спортын холбоодтой хамтран өрнүүллээ.

Хүүхэд залуус, өсвөр насныхны дунд өртөөчилсөн байдлаар сагсан бөмбөгийн тэмцээн уралдаануудыг зохион байгуулж, тэдгээрийн спортын цаашдын хүсэл сонирхлыг нь сонсож, дэмжих ажлуудыг дүүрэг, дүүргийн спорт хороотой хамтран тогтмол зохион байгуулсаар байна. Мөн фитнесийн чиглэлд “Чийрэг Монгол” фитнес клубтэй хамтран өсвөр насны сурагчдыг үнэ төлбөргүйгээр хамруулах ажлыг эхлүүлэн амжилттай үргэлжилж байна.



Хөлбөмбөгийн спортыг эх орондоо өргөн цар хүрээнд түгээн дэлгэрүүлэх, хөлбөмбөгийн спортыг нийтийн спорт бүхий үндэсний спортын хэмжээнд хүртэл хөгжүүлэхэд Ерөнхийлөгч дэмжин ажиллахаа илэрхийлж “Нийтийн хөлбөмбөг” үйл ажиллагааг мөн эхлүүлээд байна.

Та Монголын сагсанбөмбөгийн холбооны дэд ерөнхийлөгч, энэ спортоор дэд мастерын цолтой. Хоёр хуваагдаад байсан сагсанбөмбөгийн холбоо нэгтгэхэд таныг чухал үүрэгтэй оролцсон гэх юм билээ? Энэ талаар тодруулбал?

Монгол Улсын сагсан бөмбөгийн холбоо 2 хуваагдаж баг, тамирчин дасгалжуулагч нарт ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байсныг Монгол Улсын Ерөнхийлөгч холбоог нэгтгэх асуудалд онцгойлон анхаарал хандуулсан нь энэ салбар спортын амжилтыг ахиулахад ихээхэн үр дүнгээ өгсөн явдал болсон. Учир нь холбоо нэгдснээр багш дасгалжуулагч, тамирчид нэгдсэн бодлого, нэг зорилгын дор нэгдэж чадсанаар Сингапур улсад зохион байгуулагдсан FIBA 3X3 сагсан бөмбөгийн 2023 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчид маань амжилттай оролцож Аварга болсныг та бүхэн мэдэж байгаа байх.

Баг, тамирчдын хувьд сэтгэл зүй гэдэг маш чухал. Тиймээс холбоог нэгтгэх ажил баг тамирчдын амжилтад чухал нөлөөтэй. Өнөөдөр Монгол Улсын 3x3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ эрэгтэй баг

дэлхийд 5, Ази тивд 1 дүгээр байрт, үндэсний шигшээ эмэгтэй баг дэлхийд 11, Ази тивд 3 дугаар байрт эрэмбэлэгдэж байна. Удахгүй эрэмбээ ахиулж, тив дэлхийн томоохон амжилтуудын эзэн болно гэдэгт итгэлтэй байна.

Нийтийн биеийн тамир, спортыг өргөн хүрээнд хүн амын дунд дадал болгохоор ажилаж байна гэлээ. Яаж, хэрхэн хийхээр төлөвлөж байгаа талаар та товчхон мэдээлэл өгөхгүй юу?

Энэ чиглэлд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо, Монголын Үндэсний Олимпийн хороо, Биеийн тамир, спортын улсын хороо зэрэг холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг дэмжихээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нэг жишээ нь бид сургуульд суурилсан эрүүл, чийрэг иргэнийг бэлтгэх биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт шинэчлэл хийхээр ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, таны, миний хүүхэд биеийн тамирын хичээл дээр зүгээр заал тойроод гүйх, алхах биш, хүүхдийн тань биеийн онцлогт тохирсон аргаар чийрэгжүүлэх, бие, бялдрыг чадвахжуулах хөтөлбөртэй болгох юм. Тиймийн тулд багшийг бэлтгэх, стандарт спорт заалтай болгох, техник хэрэгслийг бэлтгэх, хүүхдийн эрүүл мэнд, биеийн тамирын чадавхыг үнэлэх гээд олон ажлуудыг цогцоор нь хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ шинэчлэлийг бүх шатны боловсролын байгууллагад нэвтрүүлэхээр төлөвлөж байна.





Тэгэхээр цэцэрлэгээс эхлүүлэх их, дээд сургууль төгсөх хүртлэх хугацаанд биеийн тамирийн хичээлээр нь дамжуулан дасгал, хөдөлгөөн, спортод дурлуулах ажлууд хэрэгжих нь гэж ойлголоо, зөв үү?

Тийм ээ, та яг зөв ойлгож. Би танд зөвхөн дасгал, хөдөлгөөн, биеийн тамир, спортын чиглэлээрх үйл ажиллагааг л хэллээ. Би системээр нь цогц арга хэмжээ авахаар ажиллаж байна. Нэг үгээр хэлбэл цэцэрлэгээс их, дээд сургууль төгсөх хүртлэх бүхэл бүтэн нэг үеийг системээр нь эрүүл мэндийн боловсролтой, эрүүл зөв зохистой хооллолтой, эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл зан үйл, амьдралын хэв маяг, дадалтай, идэвхтэй дасгал хөдөлгөөнтэй, эрүүл орчныг бүтээгч иргэдийг бий болгохоор зорьж байна. Мэдээж бусад насныхан руу чиглэсэн буруу дадлыг бууруулах чиглэлийн нөлөөллийн ухуулах ажлуудыг нас насны сегментэд нь тохируулах авч хэрэгжүүлэхээр мөн төлөвлөж байна.

Буруу дадал гээд дурьдлаа. Манай улсын хүн амын хичнээн хувь нь буруу дадалтай байна вэ?

Өнөөдөр манай улсын хүн амын ердөө 3,9 хувь л эрүүл зан үйлтэй буюу идэвхтэй амьдралын хэв маягтай байна. Энэ үнэхээр харамсалтай дүн мэдээ. Үлдсэн 96 хувь нь буруу амьдралын хэв маягтай байна гэсэн үг. Дээр дурьдсанчлан нийт хүн амын 17хон хувь нь спортоор хичээллэдэг байх жишээний. Монголчуудын согтууруулах ундааны хэрэглээг авч үзвэл дэлхийн ундажаас 3 дахин их байна. Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй 200 гаруй өвчин, эмгэг үүсдэг. Дурдаад байвал маш олон харамсалтай тоо баримтууд их бий. Иймээс бид бүх нийтийг хамарсан эрүүл амьдралын зөв хэв маягийг бий болгох, дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамирыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Мэдээж буруу дадал зуршлыг зөв болгоно гэдэг алга эргүүлэхтэй адил амархан шийдэгдэх асуудал биш. Үүнд хугацаа их орно. Мөн салбар яамдууд, төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн оролцоо гээд хамтын ажиллагаа нэн чухал юм.





НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛД

**НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОЛБООДЫГ ХҮЛЭЭН АВЧ
УУЛЗАЖ, САНАЛ СОЛИЛЦЛОО**



Идэвхтэй дасгал, хөдөлгөөн буюу нийтийн биеийн тамирыг хөгжүүлж эрүүл зан үйлийг бий болгох явдал нь Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь юм.

Энэ ч үүднээс биеийн тамир, спортыг өдөр тутмынхаа үйл хэргээрээ сурталчлан, таниулж буй холбоод, клуб, нийгэмлэгийн удирдах ажилтнуудтай

Санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа.

Нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг эрчимжүүлэх чиглэлд холбоодын саналыг сонсож, хөдөлгөөнийхөө бодлогод тусган, нийтийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд нягт хамтран ажиллахаа Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан илэрхийллээ.

Уулзалтад Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, биеийн тамир, спортын чиглэлээрх төрийн болон төрийн бус мэргэжлийн холбоод, нийт 60 орчим төлөөлөл оролцлоо.



ОЛИМПЫН АВАРГА БОЛОХ ЗОРИЛГОТой ЗАЛУУ УУЛЧИД

70
|
СПОРТ



Монголын уулчдын үндэсний холбооны залуу уулчдын төлөөлөл, багш, дасгалжуулагч нартай уулзаж ярилцлаа. Уулын авиралтын спортын төрлүүдээр олон жил хичээллэж, олон улсын тэмцээн уралдаанд эх орныхоо нэрийг гаргаж, амжилттай хичээллэж буй тамирчдадаа **Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайханы** зүгээр дэлхийн аварга болохыг ерөөж, дэмжлэг үзүүлэн ажиллахаа илэрхийлэв.



САГСАН БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “ХАН-УУЛ 2023” ТЭМЦЭЭН



Хан-Уул дүүргийн “Сагсан бөмбөг”-ийн Залуучуудын аварга шалгаруулах нөхөрсөг тэмцээнийг Эрүүл мэнд Хөгжлийн зуун ассоциаци, Хан-Уул дүүргийн Залуучуудын Хөгжлийн Зөвлөл хамтран 2023 оны нэгдүгээр сарын 28-29-ны өдрүүдэд Спортын төв ордонд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд Хан-Уул дүүргийн харъяа 30 хүртлэх насны залуус оролцсон ба эрэгтэй, эмэгтэй төрлөөр 120 гаруй тамирчид амжилттай оролцогч аваргаа шалгарууллаа. Энэхүү тэмцээнээр хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортод дурлах залуусын хандлагыг нэмэгдүүлэх, хүүхэд залуусын хүсэл сонирхолыг дэмжих, цаашдын спортын амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр залуустай санал солилцож ярилцлаа.

МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО НЭГДЭЖ, НЭГЭН ЗОРИЛГЫН ДОР БАТЖИВ



Монгол Улсын сагсан бөмбөгийн холбоо 2 хуваагдаж баг, тамирчин дасгалжуулагч нарт ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байв. Энэ асуудлыг Төрийн Тэргүүн анхааралдаа авч, холбоог нэгтгэсэн нь энэ салбар спортын амжилтыг ахиулахад ихээхэн үр дүнгээ өгсөн явдал болов.

Учир нь холбоо нэгдснээр багш дасгалжуулагч, тамирчид нэгдсэн бодлого, нэг зорилгын дор нэгдэж чадснаар Сингапур улсад зохион байгуулагдсан FIBA 3x3 сагсан бөмбөгийн 2023 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 24, эмэгтэй 18 баг өрсөлдсөнөөс Монгол Улсын үндэсний шигшээ эрэгтэй баг 1 дүгээр байр, эмэгтэй баг 6 дугаар байранд орсон үнэмлэхүй амжилтыг үзүүлж чадлаа.

Монгол Улсын 3x3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ эрэгтэй баг дэлхийд 5, Ази тивд 1 дүгээр байрт, үндэсний шигшээ эмэгтэй баг дэлхийд 11, Ази тивд 3 дугаар байрт эрэмбэлэгдэж байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫНХАН СПОРТООР ЭРҮҮЛЖИХИЙГ УРИАЛЖ “МЕДЛИГ2023”-ИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монголын эрүүл мэндийн салбарынхны дунд анх удаагаа зохион байгуулагдаж буй “МЕДЛИГ-2023” сагсан бөмбөгийн лигийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 600 гаруй тамирчид эрч хүчтэй, өрсөлдөөнтэй, ширүүхэн тоглолтуудыг 3 сарын турш үзүүлж, аваргуудаа шалгаруулснаар тэмцээн амжилттай өндөрлөлөө. Тэмцээний эрэгтэй, эмэгтэй “ҮНЭ ЦЭНЭТЭЙ ТОГЛОГЧ” нарт тус бүр 5 сая төгрөг гардуулав. Эрүүл мэндийн салбарынхан спортоор эрүүлжих, зөв дадлыг ийнхүү уриаллаа. Нийт баг тамирчдааа спортын өндөр амжилт хүсье.



ФИБА 3x3 “ULAANBAATAR SUPER QUEST” ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Дэлхий даяар олон мянган залуучуудын сонирхол болсон сагсан бөмбөгийн спорт манай улсад ч мөн адил жил ирэх тусам хөгжиж, залуучууд энэхүү спортоор идэвхтэй хичээллэн, зөв үлгэр дуурайлал авч буйд баяртай байна. 2023/04/04

Монгол Улсад ФИБА 3x3 “Ulaanbaatar Super Quest” тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

“ЦАГ ГАРГАЯ” НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫГ ӨРНҮҮЛЭВ

“Цаг гаргая” нөлөөллийн аяныг “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороотой хамтран 2023 оны дөрөвдүгээр сарын 03-ны өдрөөс зургаадугаар сарын 24-ны өдрийн хооронд орон даяар зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн төр болон төрийн бус, ИНБ-ууд өөр өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу “Өөртөө цаг гаргая, Эрүүл мэнддээ цаг гаргая, Гүйхэд цаг гаргая, Бурууд биш, зөвд цаг гаргая, Алхахад цаг гаргая, Гэр бүлдээ цаг гаргая,



Хайрлахад цаг гаргая, Хайртай бүхэндээ цаг гаргая, Спортод цаг гаргая, Ном уншихад цаг гаргая, Бүжигт цаг гаргая гэх мэтээр уриалга гарган цахим орчинд эерэг хандлагыг түгээв. Арга хэмжээнд нийт 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг 18 төрийн бус байгууллага хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 745 байгууллагын 406,973 мянган хүн хамрагдан оролцлоо.

СУРАГЧДЫН ДУНДАХ 3*3 САГСАН БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН



Хан-Уул дүүргийн төрийн өмчит болон хувийн ерөнхий боловсролын 35 сургуулийн төгсөх ангийн 250 гаруй сурагчдын дунд 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 5 өдрийн турш “3x3 аварга анги” шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ МОНГОЛ ТАМИРЧИД



Анх удаа Монгол Улсын эмэгтэй шигшээ баг FIBA Women's Asia Cup B division-д өрсөлдөх гэж байна. Тус тэмцээн нь 2023 оны 08 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд Тайланд улсын Бангкок хотноо зохиогдлоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, АУ-ны доктор Т.Мөнхсайхан үндсэн шигшээ багийн 12 тамирчдыг сонгон өмсгөлийг гардуулж өглөө. Нийт тамирчдадаа спортын их амжилт хүсье.



БЛИЦ ТАНИЛЦУУЛГА



Овог, нэр: Бат-Эрдэнэ Ариунцэцэг

Нас: 22

Төрсөн сар, өдөр: 2001.01.17

Орд: Матар

Клубийн нэр: Монгол Улсын 3x3 сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчин

Дасгалжуулагч: Сүхбаатар Тулга,
Ганболд Ундрах

Спортын гараа: Сэлэнгэ аймаг Мандал сумын Улсын тэргүүний 1-р сургууль

Шигшээ баг: Монгол Улсын 3x3 шигшээ баг

Сагсан бөмбөгөөр хичээллэж эхэлсэн он: 2015

Сагсан бөмбөгөөр хичээллэх болсон шалтгаан: Манай ах нар намайг авч явж сагс тоглодог байсан нь энэ спортод дурлах шалтгаан болсон

Хүсэл мөрөөдөл: Мундаг тамирчин болох

Хобби: Дуу сонсох, гар бөмбөг тоглох биллард тоглох

Хэлэх дуртай үг: Баярлалаа, Хайртай шүү, Мундаг даа

Амжилтууд:

2022оны Оюутны Лиг Аварга Улирлын MVP, Final MVP

FISU UNIVERSITY World cup 3x3 Basketball хүрэл медаль

ДЭД ЛИГ-2023 Аварга Улиралын MVP тоглогч

Ханжоу-2022 Азийн наадам 3x3сагсан бөмбөг төрөлд Мөнгөн медаль



Б. АРИУНЦЭЦЭГ:

Түүхэн амжилтыг үзүүлсэн Азийн наадмын шагнал хүртэх торгон мөчөөсөө хуваалцахгүй юу?

Анх удаа Азийн наадамд оролцож байгаа болохоор үнэхээр гоё байсан мөн дээрээс нь нээлтэн дээр Монгол улсынхаа төрийн далбааг барьж туг өргөсөн болохоор илүү их зоригтой болсон. Медаль авахад их эрч хүч өгсөн байх. Тэгээд медальтай монголдоо ирсэндээ маш их баяртай байгаа. Тэр үед өөрсдөө ч итгэхгүй байсан. Хамгийн гоё мэдрэмж

хэзээ ч мартагдахааргүй мөч байсан.

Сагсан бөмбөгийн спортоор анх хичээллэж эхэлсэн мөчөө дурсвал?

Анх тэгээд ах нартайгаа байнга сагс тоглодог байсан болохоор нэг мэдсэн сагсан бөмбөгт дуртай, хайртай болчихсон байсан даа. Сургуульд ороод л сургуулийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль аваад л, аймгийн шигшээд дуудагдаад л тэр үеэс хойш хичээллээд явж байна даа.

Энэ спорттой холбогдоход нөлөөлсөн хамгийн чухал хүнээ нэрлэхгүй юу?



Аав, Ээж маань юм болуу мөн ах, эгч, найзууд маань нөлөөлсөн.

Сагс тоглох, бэлтгэл хийх явцад бэртэл, гэмтэл хэр авч байв?

Би 2021 онд нуруугаа гэмтээж байсан болохоор тэрнээс болоод нилээн хэцүү байсан сэтгэл санаа хүртэл сонин болоод тэрнээс хойш бэртэл, гэмтэл авахаас маш их айдаг болсон. Бэртэл, гэмтэл хэлж ирдэггүй болохоор бэлтгэл сургуулиалтаа эхлэхийн өмнө халаалт, сунгалтаа сайн хийх юм бол гэмтэл авахаас сайн сэргийлдэг.

Та хэр хугацаанд бэлтгэл хийдэг вэ?

Өдрийн бараг 7,8 цаг бэлтгэл хийдэг. Өдөрт 2 удаа бэлтгэлдээ ордог. Бэлтгэлээ таслалгүй хийх нь амжилт гаргахад маш чухал.

Дандаа ялалт авчирна гэдэг хэцүү. Ялагдах мөчид танд ямар мэдрэмж төрдөг вэ?

Хүн угаасаа ялагдах гэж тоглодоггүй, олон ялагдах тэр мөчид хэний ч шар хөдөлж заавал дараагийн удаа хожино гэж дандаа өөрөө өөртөө хэлж байнга хурцалдаг. Олон ялагдсаны эцэст ингээд медаль авсандаа өөрөөрөө бахархаж байна.

Сэтгэл зүйгээр унасан тохиолдолд өөрийгөө хэрхэн сэргээдэг вэ? Тамирчны сэтгэл зүй тоглолтод чухал нөлөөтэй байх?

Сэтгэл зүйгээр унасан үедээ ганцаараа дуу сонсож алхамаар байдаг. Мөн хоол, амттан идэж өөрийгөө сэргээдэг. Тамирчин хүний сэтгэл зүй нь тоглолтод маш чухал байдаг болохоор тэр үед тэмдэглэл бичих юм уу эсвэл өөрөө өөрөөтэйгээ маш их ярьдаг даа.

Таны ойрын болон ирээдүйн зорилго юу вэ?

Ойрын зорилго гэх юм бол Түрүү жилийн дэд лигээр аварга авсан энэ жил аваргаа хамгаална даа. Ирээдүйн зорилго олимпид оролцохыг хүсдэг.

Сагсан бөмбөгийн спортыг та өөрийнхөөрөө тодорхойлвол?

Надад Сагсан бөмбөгийн спорт Над шиг ийм дотогшоо бүрэг дуугаа хүнийг хүнд баярласан талархсанаа илэрхийлж, нийтэч, хүнтэй харьцах харилцаанд хүмүүжилтэй болгож өгсөн гэж боддог. Би энэ спортодоо дурласан хүн.

Олон хүүхэд, залуус спортод тэр дундаа сагсан бөмбөгт дурлах болжээ. Таны хувьд сагсан бөмбөг сонирхогч хүүхэд, залууст хандаж юу гэж хэлэх вэ?

Сагсан бөмбөгөөр хичээлж байгаа, дөнгөж хичээллэх гэж байгаа дүү нартаа хэлэхэд юм хэзээ ч амархан байдаггүй болохоор шантрах үе зөндөө гарна, битгий шантраарай, хүсэл мөрөөдлийнхөө төлөө эрч хүчтэй байгаарай. Чи чаднаа гэж хэлмээр байна.





БЛИЦ ТАНИЛЦУУЛГА



Овог, нэр: Мягмарсүрэн Өлзий-Орших

Нас: 23

Төрсөн сар, өдөр: 2000.15.08

Орд: Нум

Клубийн нэр: IHC Apes

Дасгалжуулагч: Lale

Спортын гараа: Багануур дүүрэг Үүрдсайхан багш

Шигшээ баг: 2022 онд шигшээ багт багтсан

Сагсан бөмбөгөөр хичээллэж эхэлсэн он: 2015

Сагсан бөмбөгөөр хичээллэх болсон шалтгаан: Багаасаа спортод сонирхолтой байсан

Хүсэл мөрөөдөл: 5*5 шигшээ багаараа Ази тивийн аварга болох

Хобби: Snowboard

Хэлэх дуртай үг: Хичээсэн хүнийг бурхан шагнадаг

Хүндэлж явдаг тамирчин: Санчир, Билгүүн, Дөлгөөн

Амжилтууд:

2018 U18 Asia Cup – Хүрэл медаль

2019 Оюутны Азийн аварга алтан медаль

2023 Ханжоу – Азийн наадам – Хүрэл медаль



М.ӨЛЗИЙ-ОРШИХ:

Түүхэн амжилтыг үзүүлсэн Азийн наадмын шагнал хүртэх торгон мөчөөсөө хуваалцахгүй юу?

Азийн наадмын багийн спортын төрөлд олон жилийн дараа анхны медалийг эх орондоо авчирсандаа маш их баяртай байна. Анх тэмцээнд бэлдэж байх үеэсээ л тухайн мөчийг дотроо бодож, төсөөлөн зорьж байсан.

Сагсан бөмбөгийн спортоор анх хичээллэж эхэлсэн мөчөө дурсвал?

Анх манай дүүрэгт Япон багш ирсэн гэж сонсоод, бэлтгэлд нь явж үзсэн юм. Тэр үеэс хойш сагсан бөмбөгийн спортоор хичээллээд одоогийн энэ амжилтандаа хүрсэндээ баяртай байна.

Энэ спорттой холбогдоход нөлөөлсөн хамгийн

чухал хүнээ нэрлэхгүй юу?

Манай ангийнхан, найзууд их нөлөөлсөн. Манай аав ээж минь их дэмждэг байсан. Одоо хүртэл дэмждэг.

Сагс тоглох, бэлтгэл хийх явцад бэртэл, гэмтэл хэр авч байв?

Тамирчин хүний хувьд бэртэл, гэмтэл маш хэцүү зүйл. Миний хувьд нилээн хэдэн удаа хүнд бэртэд авч байсан. Бэртлээс эргэж ирэхдээ улам илүү хүчтэй сэтгэл зүйн бэлтгэлтэй болж ирсэн гэж боддог.

Та хэр хугацаанд бэлтгэл хийдэг вэ?

Долоо хоногт 5-6 өдөр бэлтгэл хийдэг. Өдөрт 2 цагаар тасралтгүй хийдэг дээ.



Дандаа ялалт авчирна гэдэг хэцүү. Ялагдах мөчид танд ямар мэдрэмж төрдөг вэ?

Ялагдах мөч бол дараагийн хожил авахад их нэмэр болдог гэж боддог. Хожигдох бүртээ туршлага сууж, ямар нэг зүйлийг шинээр мэдэж, суралцдаг. Хожигдлоо гээд шантарч болохгүй, улам хичээх хэрэгтэй гэсэн шалтгаан болж өгдөг.

Сэтгэл зүйгээр унасан тохиолдолд өөрийгөө хэрхэн сэргээдэг вэ? Тамирчны сэтгэл зүй тоглолтод чухал нөлөөтэй байх?

Хожигдсон тоглолтын дараах сэтгэл зүй маш хэцүү байдаг. Тэр үед улам илүү хичээж тоглолтондоо төвлөрөхийг хичээдэг. Өмнөх болсон зүйлсээ мартаад бүгдийг шинээр эхэлдэг. Тоглолтын өмнө аль болох тоглолтоос өөр зүйл бодохгүй байхыг хичээдэг.

Таны ойрын болон ирээдүйн зорилго юу вэ?

Ойрын зорилго бол дэд лигийн аварга болох, холын зорилго бол Asia cup 5*5 оролцох зорилготой.

Сагсан бөмбөгийн спортыг та өөрийнхөөрөө тодорхойлвол?

Хурд, хүч, ухаан, тэсвэр, тэвчээр, ойлголцол, хүмүүжил гэж хэлж болно.

Олон хүүхэд, залуус спортод тэр дундаа сагсан бөмбөгт дурлах болжээ. Таны хувьд сагсан бөмбөг сонирхогч хүүхэд, залууст хандаж юу гэж хэлэх вэ?

Хүүхэд багачууд багаасаа өөрийн зөв сонирхлыг олоод зөв спортоороо хичээллэх нь эрүүл мэнд болоод бусад бүх зүйлд нь хэрэгтэй байдаг. Тийм болохоор өөрийн сонирхож дурласан спортоосоо кайф авч, шантрахгүй хичээж өөр өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд хичээх хэрэгтэй шүү.





М.БОЛД МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Нийтийн хөлбөмбөг” төсөл амжилттай хэрэгжиж байна. Энэхүү төслийг яагаад хэрэгжүүлэх болсон талаар уншигчдад мэдээлэл өгнө үү.

Монголын Хөлбөмбөгийн Холбоо /МХБХолбоо/ Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо /ОУХБХолбоо/ болон Азийн Хөлбөмбөгийн Холбоо /АХБХолбоо/-ны гишүүн байгууллага. Эдгээр холбоодууд хөлбөмбөгийн хөгжлийн пирамидын үндэс суурь болсон сургуулийн хөлбөмбөг рүү анхаарлаа хандуулахыг зөвлөж, гишүүн байгууллагуудаараа дамжуулан, олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. ОУХБХ-ны “FIFA Football for Schools”, “Amatear football”, АХБХ-ны “Grasstoots” зэрэг хөтөлбөрүүдийг дэлхийн бүх улс орнуудад хэрэгжүүлж байна. МХБХолбоо ч гэсэн эдгээр байгууллагуудын гишүүний хувьд урт хугацааны стратеги төлөвлөгөө гарган, эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүднээс “Нийтийн хөлбөмбөг” (Grassroots)-ийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний “Нийтийн биеийн тамир” дэд хөтөлбөртэй зорилгын хүрээнд бүрэн нийцэж байгаа юм.

Тийм ч учраас МХБХолбоо 2021 онд Монгол Улсын Төрийн тэргүүн У.Хүрэлсүхтэй уулзалт хийсэн. Монгол Улсын Төрийн тэргүүн нь Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч байдаг учраас үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, олон нийт, ард түмэнд чиглэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийг дэмжин, “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрөө боловсруулан, Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулсан билээ. Монгол Улсын Ерөнхийлөгч энэхүү хөтөлбөрийг дэмжин, өөрийн ивээл дор орон даяар хэрэгжүүлэх болсонд нийт хөлбөмбөгчдийн өмнөөс баяртай байдаг юм.




“Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрөө уншигчдад дэлгэрэнгүй танилцуулж өгнө үү.

Монгол улсын бүх сум, багт хүрэх энэхүү “Нийтийн хөлбөмбөг” (Grassroots) хөтөлбөр дотроо 5 дэд хөтөлбөртэй. Үүнд:

1. Ерөнхий Боловсролын Сургуулиудаар дамжуулан охид, хөвгүүдийг дэлхийн 1 номерын спорт болсон хөлбөмбөгөөр тоглож, наадан, эрүүл чийрэг ирээдүйн иргэн болгох зорилготой. Энэ үүднээс 12, 14, 16 насны охид, хөвгүүдийн дунд “Мөрөөдлийн гоол” тэмцээнийг эхлүүлээд байна. Нийт 840 гаруй сургуулиуд сургуулийн аваргаас эхлэн, аймаг, дүүрэг, бүс, улсын “Мөрөөдлийн гоол” тэмцээнд оролцон тоглох боломжтой. 9 сараас эхэлсэн энэхүү тэмцээн 2024 оны 7 сард Олон улсын тэмцээнээр энэ жилийн тэмцээн өндөрлөнө. Эргээд 9 сард эхлэх зэргээр 4 жилийн хугацаанд энэхүү тэмцээн явагдана.”Мөрөөдлийн гоол” тэмцээнийг Биеийн тамир, спортын улсын хороо, Боловсролын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж байна.
2. Хүүхэд, багачууд, иргэд, тоглох наадах боломжтой аймаг бүрт хөлбөмбөгийн стандарт талбайг бий болгох зорилготой “30 хөлбөмбөгийн стандарт талбай” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Бүх аймаг, дүүрэг цэнгэлдэх хүрээлэнтэй боловч, шаардлага хангасан хөлбөмбөгийн талбайгүй байдаг. Энэ

4 жилд 21 аймаг, 9 дүүргийн талбайгүй байгаа газруудад улс, орон нутгийн төсөв, бизнесийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон улсын тэмцээн уралдаан хүлээн авахуйц стандартын талбай бий болсноор олон улс болон дотоодын тэмцээн уралдааныг тухайн орон нутгийн ард иргэд хүлээн авч үзэх бүрэн боломж бүрдэнэ гэж харж байна.

3. Дэлхийн 1 номерын спортыг хөгжүүлж байгаа клуб болон аймаг, дүүргийн холбоодод санхүүгийн дэмжлэг орлого маш чухал. Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниудыг уриалсан “Хамтын ажиллагаа - Түншлэл” хөтөлбөр хэрэгжиж байна. Компаниудад ажиллаж байгаа ажиллагсдын дунд хөлбөмбөгийн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах, ажиллагсад энэхүү спортоор дамжуулан эрүүл чийрэг байх, компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд ажиллагсад болон тэмцээн уралдааныг дэмжсэнээр хөлбөмбөгийг хөгжүүлэх олон төрлийн боломжууд бий болгохын төлөө ажиллана. Бид хамтаараа энэхүү гайхамшигтай спортыг Монгол улсад хөгжүүлж чадна хэмээн харж байна.
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор явагддаг “Үндэсний цом” тэмцээнийг жил бүр зохион байгуулж байгаа. Хэрвээ аймаг бүр хөлбөмбөгийн талбайтай, хүүхэд багачууд бүр “Мөрөөдлийн гоол” тэмцээнээр энэхүү спортод дуртай болчихбол “Үндэсний цом” тэмцээнийг НОМЕ болон AWAY хэлбэрээр зохион байгуулах юм. Өөрөөр хэлбэл Аваргуудын лигийн журмаар явагдвал орон нутгийн ард түмэн хайртай нутгийн багаа дэмжих, эргээд спорт аялал жуулчлал хөгжих боломжуудыг бий болгоно.



5. Энэ бүх ажлуудыг хийхэд зайлшгүй шаардлагатай ажил бол сургуулийн багш нарын хөлбөмбөгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх явдал юм. “Дасгалжуулагч багшийн боловсрол” нэртэйгээр явагдах энэхүү дэд хөтөлбөрийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлэхээр Санамж бичгийг байгууллаа. ОУХБХ-ноос хэрэгжүүлж байгаа “FIFA Football for schools” гар утасны апплейкшнийг монгол хэл дээр бий болгосон байгаа. Сумын биеийн тамирын багш гар утсаараа хөлбөмбөгийн сургалтуудыг татан авч, сурагчидтайгаа ажиллах бүрэн боломжыг 2 жилийн өмнө хэрэгжүүлсэн. Одоо бид таниулах, хэрэглүүлэх талаар ажиллана. Мөн Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартаар суурь боловсролыг заах багш нар МХБХ-ны “Е”, “D” ангиллын дасгалжуулагч байх стандарттай. Бид “Е” ангилал буюу Grassroots-ийн сургалтыг аймгуудад явуулсан. Одоо “D” ангиллын сургалтуудыг аймаг, дүүрэг бүрт явуулахаар төлөвлөж байна. 4 жилийн хугацаанд 900 гаруй багш нарыг “D” ангилалтай болгохоор төлөвлөн ажиллаж байна. Энэ өргөн далайцтай ажлыг бүхий л талаар дэмжин, ажиллаж байгаа Я.Содбаатар даргатай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, О.Баттулга даргатай БТСУХороо, Т.Ням-Очир даргатай БЕГазртаа чин сэтгэлээсээ талархаснаа илэрхийлье. Бид 2028 онд хийсэн ажилтай, бүтээсэн талбайтай, эрүүл чийрэг иргэдтэй олон хөтөлбөрүүдийн үр дүнгээ тайлагнах болно.



М

**ОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ИВЭЭЛ ДОР “МӨРӨӨДЛИЙН ГООЛ”
ТЭМЦЭЭН УЛС ОРОН ДАЯАР ЗОХИОН
БАЙГУУЛАГДАНА**

АЙМАГ БҮРД СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ХӨЛБӨМБӨГИЙН ТАЛБАЙ БАЙГУУЛНА



80
СПОРТ

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн болон “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын дунд хөлбөмбөгийн талбай байгуулахаар ажиллаж байна. Спортыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, хүүхэд багачуудын бие бялдрыг хөгжүүлэх, цаашид энэ төрлийн спортоор тууштай хичээллэх авьяаслаг өсвөрийн тамирчдыг нээн илрүүлэх

зорилгоор дээрх хамтран ажиллах гурван талт санамж бичгийг байгуулав. Тодруулбал, Биеийн тамир, спортын улсын хороо, Боловсролын ерөнхий газар, Монголын хөлбөмбөгийн холбоо хамтран ажиллахаар санамж бичигт гарын үсэг зурав.

Хамтын ажиллагааны хүрээнд:

- Аймаг, дүүрэг бүрд стандартын шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай байгуулах
- Ерөнхий боловсролын бүх сургуулиудын дунд охид, хөвгүүдийн ангилал бүхий “Мөрөөдлийн гоол” тэмцээнийг зохион байгуулах
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хөлбөмбөгийн дасгалжуулагчаар бэлтгэх зэрэг ажлууд хийгдэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР “НИЙТИЙН ХӨЛБӨМБӨГ” ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

Монголын Хөлбөмбөгийн Холбоо хөгжлийн олон талт ажлуудыг бодлогын түвшинд явуулж байгаа бөгөөд нийтийн хөлбөмбөг, өсвөрийн хөлбөмбөгийн хөгжлийг дэмжих чиглэлд 2028 он хүртэл хэрэгжүүлэх “Урт хугацааны стратеги хөтөлбөр”-төө “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрийг тусган, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний “Нийтийн биеийн тамир”-г дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Монголын Хөлбөмбөгийн Холбооны санаачилсан “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрийг дэмжин, Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор авч, нийт орон даяар хэрэгжүүлэх илгээлтээ гарган хэрэгжүүлж эхэллээ.

Үндэсний хэмжээний “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрийн хүрээнд 2027 он хүртэл:

1. Ерөнхий боловсролын бүх сургуулийн дунд охид, хөвгүүдийн ангилал бүхий “Мөрөөдлийн гоол” тэмцээнийг 2023 оны 9 сараас эхлэн, 12, 14, 16 насны ангиллаар 5 үе, шаттайгаар зохион байгуулах,
2. Олон улсын хөлбөмбөгийн тэмцээн, уралдаан зохион байгуулах стандарт хэмжээ, шаардлагыг хангасан хөлбөмбөгийн талбайг 21 аймаг, 9 дүүрэгт шинээр байгуулах,
3. Хөлбөмбөгөөр дамжуулан олон улсад үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хөлбөмбөгийн спортыг дэмжих “Хамтын ажиллагаа, түншлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
4. 21 аймаг, 9 дүүргийн шигшээ багууд оролцдог “Үндэсний цом” тэмцээнийг өргөжүүлэн, чанар, үр өгөөжийг сайжруулах,
5. Ерөнхий боловсролын бүх сургуулийн хөлбөмбөгийн багшийн ур чадварыг сайжруулах “Дасгалжуулагч багшийн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлуудыг хийнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн илгээлтийг Ерөнхийлөгчийн спорт хариуцсан зөвлөх, МХБХ-ны Ерөнхийлөгч М.Болд, Засгын газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дарга И.Баатархүү нарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр гардуулан өглөө. Илгээлтийг хүлээн авсан байгууллагууд Ерөнхийлөгчийн уриалгыг бүх талаар дэмжин, төлөвлөгөө, төсөвтөө тусган, хамтарч ажиллахаа илэрхийллээ.

Цаашид “Эрүүл Монгол хүн” санаачилгыг хэрэгжүүлэх үүднээс энэхүү илгээлтийг 9 дүүрэг, 21 аймаг, аж ахуйн нэгж байгууллага, хөлбөмбөгийн спортыг дэмждэг бүхий л байгууллагуудад гардуулан өгч, нийтийн биеийн тамирыг түгээн дэлгэрүүлэн юм.



Хоймор нутагт “Мөрөөдлийн гоол” тэмцээн эхэллээ



Монгол орны оргил цэг Алтай таван богдын хаяанд “Мөрөөдлийн гоол” тэмцээн эхэллээ



Хөлбөмбөгийн үндэс суурь болсон “Мөрөөдлийн гоол” тэмцээн Өмнийн цэнхэр говьд эхэллээ




“Мөрөөдлийн гоол” тэмцээн Сүхбаатар аймгийн Дарьганга суманд эхэллээ





ДЭЛХИЙН ХАМГИЙН ӨНДӨР ЦАЛИНТАЙ 10 ХӨЛБӨМБӨГЧИД



Нэг. Португаль тоглогч, супер од Криштиану Роналду Саудын Арабын “Аль Насср” багтай гурван жилийн гэрээ байгуулж, жилд 200 сая еврогийн цалин авахаар болсон. Ингэснээр тэрбээр дэлхийн хамгийн өндөр цалинтай хөлбөмбөгчин болсон юм. Роналду монгол мөнгөөр жилд 720 тэрбум, сард 59,7 тэрбум, долоо хоногт 1.9 тэрбум, цагт 81.7 сая төгрөгийн цалин авах нь. Энэ нь хөлбөмбөгийн спортын түүхэн дэх хамгийн өндөр цалин. Тэгвэл өнөө цагт хөлбөмбөгчдөөс хамгийн өндөр цалинг хэн, хэн авч байна вэ?



ХОЁР: Бүх цаг үеийн шилдэг болох ирээдүйтэй гэгдэж буй Киллиан Мбаппе “Парис Сен-Жермен” клубээс жилд 115 фунт стерлингийн цалин авдаг. Энэ нь Роналдугийн дараа орох өндөр цалин. Энэ жил Францын шигшээ багаа дэлхийн аваргын төлөө дахин тоглуулж, финалд гурван гоол оруулсан Мбаппе 1996 оноос хойш алтан медалийн төлөөх тоглолтод хет-трик хийсэн анхны хөлбөмбөгчин болсон. Тэр PSG-д Месси, Нэймар нарын домгуудтай хамт тоглон, амжилтын төлөө хамтдаа зүтгэж буй. Мбаппе багаа солих эсэх олны анхаарлыг татат буй. Хэрвээ багаасаа явбал Роналдугаас өндөр цалингийн санал авах магадлал бий.



ГУРАВ: Энэ жил дэлхийн аварга болох зорилгодоо хүрч, дутуугаа гүйцээн, дэлхийн сая, сая хөгжөөн дэмжигчээ баярлуулсан Лионел Месси цалингаараа гуравдугаарт бичигдэж байна. Тэрбээр “Парис Сен-Жермен” клубээс жилд 108 сая фунт стерлингийн цалин авдаг.



ДӨРӨВ: Мбаппе, Месси нарын багийн хамтрагч Нэймар “Парис Сен-Жермен” клубээс жилд 78 сая фунт стерлингийн цалин авдаг. Энэ нь хөлбөмбөгчдөөс дөрөвт орох хэмжээний өндөр цалин. Энэ жил ДАШТ-ээс мултарч, Бразилын шигшээгийн хамт дараагийн дэлхийн аваргыг хүлээхэд хүрсэн Нэймар 2017 онд дэлхийн хамгийн өндөр үнэтэй хөлбөмбөгчин болж байв.



ТАВ: Египет улсын хөлбөмбөгч Мохаммед Салах “Ливерпуль” клубээс жилд 47 сая фунт стерлингийн цалин авдаг. Юрген Клопп түүнийг “Рома”-гаас 42 сая еврогоор авахад “Дээд зэрэглэлийн хоёр ч тоглогч авах мөнгө үрлээ” гэж хөгжөөн дэмжигчид чамлаж байв. Одоо харин тэдний буруу байсныг, хөлбөмбөгийн түүхэн дэх хамгийн ашигтай наймаа болсныг цаг хугацаа, Салахын амжилт, ур чадвар харуулсаар. Уналтад ороод байсан “Ливерпуль”-ийг тэр амжилтад хүргэсэн, тод од, итгэл найдвар нь болсон. 2018 онд “Ливерпуль”-ийн удирдлага “Мохаммед Салахыг багадаа 225 сая еврогоор зарна” гэж босго тогтоож байв.



ЗУРГАА: Мбаппегаас дутахгүй тодоос тод гялалзаж буй залуу од бол яахын аргагүй Эрлин Хааланд. 23 настай тэрбээр өнөө цагт хэдийнэ дэлхийд хүлээн зөвшөөрөгдөн, супер одын хэмжээнд үнэлэгдэж байна. Хааланд “Манчестер сити” клубээс жилд 35 сая фунт стерлингийн цалин авдаг.



ДОЛОО: Польш хөлбөмбөгчин Роберт Левандовский “Барселона” клубээс жилд 31 сая фунт стерлингийн цалин авдаг. 34 настай тэрбээр 2010-2014 онд “Боруссия Дортмунд”-д, 2014-2022 онд “Бавария”-д, 2022 оноос хойш “Барселона”-д тоглож байгаа юм. Левандовский 2013 онд “Аваргуудын лиг”-ийн хагас шигшээд дөрвөн гоол оруулсын анхны тоглогч болж байв.



Жилд Эден Азар “Реал мадрид” клубээс 28 сая, Андреас Инеста 27 сая, Кевин Де Брюне “Манчестер сити”-гээс 26,5 сая фунт стерлингийн цалин авч, эхний аравт бичигдэж байна.

Хөлбөмбөгийн спортод дурлах нь – ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?


тоо баримт, сонирхолтой статистикууд /гадаад, дотоод

- Баримт 1. Хөлбөмбөг нь Хятадаас гаралтай бөгөөд МЭӨ 476 онд үүсчээ.
- Баримт 2. Хөлбөмбөгийг дэлхийд хамгийн олон хүн тоглодог, сонирхолтой спорт юм.
- Баримт 3. Хөлбөмбөг бол дэлхийн хамгийн алдартай спорт бөгөөд нэг тэрбум гаруй фанат дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг телевизээр үздэг байна. Зуны олимпоос хоёр дахин олон үзэгчтэй тэмцээн бол хөлбөмбөгийн ДАШТ.
- Баримт 4. Францын тамирчин Стефан Стэнис 1942 оны Хөлбөмбөгийн тэмцээн дээр нийт 16 удаа гоол оруулсан байдаг.
- Баримт 5. Сагсан бөмбөгийг анх хөлбөмбөгийн бөмбөгөөр тоглож байжээ.
- Баримт 6. Хөлбөмбөгийн тоглогчид дунджаар 9.65 км гүйдэг.
- Баримт 7. Дэлхийн анхны хөлбөмбөгийн клуб Англи улсад "Шеффилд" нэртэйгээр нээгдэж байсан байна.
- Баримт 8. Европын багууд 1930, 1950 оны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс бусдад нь оролцож байсан.
- Баримт 9. Роналдиньо 23 нас хүрэхдээ нийт 23 тоглолтод орж, 23 гоол хийж байсан.
- Баримт 10. Анхны өнгөт арьстай хөлбөмбөгчин Артур Вартарт байжээ.
- Баримт 11. Домогт Пеле хөлбөмбөгийг "үзэсгэлэнт тоглоом" гэж нэрлэж байсан анхны хүн.
- Баримт 12. 1964 онд Перу дахь хөлбөмбөгийн тэмцээний шүүгчийн дуудлага 300 гаруй хүнийг хөнөөсөн бослого болсон.
- Баримт 13. Абиджан 1989-1994 оны хооронд 108 тоглолтод хожигдоогүй байна.
- Баримт 14. Хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний анхны гоолыг Францын шигшээ багийн тамирчин Люсьен Лоран оруулсан байдаг.
- Баримт 15. Криштиан Роналду нь Мессигээс 869 хоногийн ах юм байна. Хамгийн сонирхолтой нь Роналдугийн хүү ч Мэссигийн хүүгээс 869 хоногоор ах гэнэ.
- Баримт 16. Мэргэжлийн хөлбөмбөгийн "бөмбөг" 120 жилийн турш хэлбэр, хэмжээгээ хадгалжээ.
- Баримт 17. Хөлбөмбөгийн "бөмбөг"-ний 80 орчим хувийг Пакистанд үйлдвэрлэдэг.
- Баримт 18. Хөлбөмбөгийн тэмцээнийг анх 1937 онд телевизээр дамжуулж байжээ. Энэ тоглолт нь Highbury цэнгэлдэх хүрээлэнд болжээ.
- Баримт 19. Хамгийн олон улаан хуудас авсан дэлхийн аваргын тэмцээн 2006 онд болж байжээ. Энэ удаагийн тэмцээний 64 тоглолтод 25 улаан хуудас тэмдэглэгдсэн.
- Баримт 20. Хамгийн олон шар хуудас авсан тэмцээн мөн л 2006 онд болж байжээ. 64 тоглолтод 310 шар хуудас.
- Баримт 21. 2018 оны ДАШТ нь ОХУ-ын ДАШТ-ий 11 дахь удаагийн тэмцээн аж. Тэдний хамгийн дээд амжилт нь 1966 онд дөрөвдүгээр байранд оржээ.
- Баримт 22. 2002 оны Хөлбөмбөгийн ДАШТ анх удаа Өмнөд Солонгос, Япон хоёр өөр улс оронд зохион байгуулагдсан.
- Баримт 23. 1966 онд ДАШТ-ий цомыг 7 хоногийн турш алдаж байжээ.
- Баримт 24. Хөлбөмбөгийн хамгийн том тэмцээн 5098 багтайгаар болжээ.



“ЭРҮҮЛ – ЭКО” ЖИШИГ ХАН-УУЛ ДҮҮРГИЙГ БИЙ БОЛГОНО

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний зорилго, зорилтын дагуу эрүүл зан үйл, амьдралын хэв маягтай нэг үеийг бий болгох зорилгын хүрээнд Хан-Уул дүүргийг жишиг, загвар дүүрэг болгохоор ажиллаж байна. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлд олон талт үйл ажиллагааг Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албанаас зохион байгуулж байна



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга

ХАН-УУЛ ДҮҮРГИЙГ ЖИШИГ, ЗАГВАР ДҮҮРЭГ БОЛГОХООР “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН ХЭРЭГЖИЖ БАЙНА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв нь 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Аддиктологийн тусламж үзүүлэх цогц клиник байгуулах
- Эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах “Жирэмсний бүлгийн хяналт”
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг
- Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Энэхүү төсөл арга хэмжээний хүрээнд “Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх клиник”-ийг шинээр байгуулан сүүлийн сарын хугацаанд архины хамаарал бүхий оноштой 25 хүнийг өдрийн эмчилгээнд, 14 хүнийг хэвтүүлэн эмчилж, сэтгэц аддиктологийн тусламж үйлчилгээнд хамрууллаа. Тусламж үйлчилгээг багаар үзүүлж байгаа бөгөөд сэтгэц аддиктологийн эмч 4, сувилагч 2, сэтгэлзүйч 1, нийгмийн ажилтан 1, өөртөө туслах бүлгийн удирдагч 1 ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэхэд цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран ажиллаж байна. Архины хэрэглээний түвшинг тогтоох AUDIT асуумж, судалгааны аргаар архинд донтох эмгэгтэй иргэдийг тогтоож, эмчилгээнд хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулан, эрчимжүүлэн ажиллаж байна. Цаашид Хан-Уул дүүргийн харьяа төрийн болон төрийн бус байгууллагаас асуумж судалгааг авч, архины хамаарал бүхий иргэдийг эрт илрүүлэн эрүүлжүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.



85

Хан-Уул дүүрэгт 20882 ахмад настан амьдардаг бөгөөд 25 хорооны 1740 ахмад настныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Цаашид ахмад настныг үзлэгт бүрэн хамруулснаар өвчлөлийн суурь судалгааг гаргаж, шаардлагатай тохиолдолд лавшруулсан тусламж үйлчилгээг үзүүлэн амьдралын чанарыг сайжруулна.

Жирэмсний бүлгийн хяналтын төслийг хэрэгжүүлэх нь “Эрүүл гэр бүлээс- эрүүл хүүхэд” төрөх, цаашид хүүхдийн суурь өвчлөлөөс сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.

“Эрүүл зүрх” төслөөр Хан-Уул дүүргийн ЕБСургуулийн 6 настай 4578 хүүхдийн зүрхний бичлэг хийж, зүрхний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан. Энэхүү төсөл нь хүүхдийн зүрхний гажгийг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулах зорилготой юм.

“Эрүүл шүд” төслөөр 52 дугаар сургуулийн 484 хүүхдэд шүдний үзлэг хийж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийж байна. Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрүүл иргэнтэй болно.

Цаашид өргөжүүлэх тусламж үйлчилгээний хүрээнд

- Мэс заслын тасагтай болж, мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлэх
- Хүүхдийн тасагтай болж, хүүхдийн тусламж үйлчилгээг өргөжүүлэхээр ажлаа төлөвлөд байна.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРААС АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ



Т.ДАМБИЙНЯМ

Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын дарга
Цагдаагийн хурандаа

Ерөнхийлөгчийн 43 тоот зарлиг болон Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Сogтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дүүргийн Цагдаагийн газраас хэд хэдэн ажлыг зохион байгууллаа. Энэ хүрээнд цогц 4, хэсэгчилсэн 6, тусгай 12 арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчдын мэргэжил арга зүйгээр хангаж давхардсан тоогоор 1262 алба хаагч ажиллаа.


Дүүргийн Эрүүл мэндийн болон Цагдаагийн газар хамтран тус дүүрэг дэх эрүүлжүүлэх байр, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон иргэд, донтох эмгэгтэй иргэдэд үзүүлэх тусламжийн өнөөгийн байдал, цаашид хийх ажлын талаар 2023 оны 10 дугаар 09-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газраас хэлэлцүүлэг зохион байгууллаа.



“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД АРХИНЫ ШАЛТГААНТ ХОРДЛОГЫН НАС БАРАЛТЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГО ТАВИН ДҮҮРГИЙН ТӨВТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ



“Та-Татгалз” нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж тодорхой үе шаттайгаар 3 удаа Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 43 сургууль 12 их, дээд сургуулийн 584 сурагч, 2361 оюутнуудад архины хор хөнөөл, түүний хор уршгийн талаар 4 төрлийн сэдвээр сургалт зохион байгуулж, 3827 санамж, сэрэмжлүүлэг тарааж тус арга хэмжээнд нэгдэх уриалга гаргаж хамтран ажилласан.

Мөн тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуй нэгж байгууллагын лед дэлгэцээр “Та татгалз” арга хэмжээний видео, шторк, иргэд, олон нийт ихээр цуглардаг 23 цэгт байрлах зар сурталчилгааны томоохон самбаруудад тус арга хэмжээний уриалгыг байршуулж, тус цагдаагийн газрын пейж хуудсанд байршуулсан 17 видео бичлэг, 4 постерыг 6888 иргэдэд түгээж, 3656 иргэнд таалагдаж, 4190 хүн хандалт хийж 1256 хүн сэтгэгдэл бичсэн, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 телевиз, 3 фм, радиогоор мэдээлэл хийж, томоохон шөнийн цэнгээний газруудаар үйлчлүүлж буй иргэдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хариуцлагын бугуйвч”, байгууллагын меню цэсэнд QR код байршуулсан шинэлэг ажлуудыг эхлүүлсэн.

Эрүүл мэндийн төвтэй хамтран 56 иргэнийг эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулан, дүгнэлт гаргуулж архины албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж 22 иргэнийг архи, согтууруулах ундаанаас татгалзуулж, 8 иргэний Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажилд зуучилж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтсээс 2023 оны 12 дугаар сарын байдлаар “Уусан бол бүү жолоод” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нийт 12 удаа зохион байгуулж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож буй 2482 зөрчлийг илрүүлэн Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу 1 жилийн хугацаагаар жолоодох эрхийг хасаж 992,800 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан.

Гудамж талбай, олон нийтийн газарт согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 хоног бүрийн “Баасан” гарагт хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуй нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу татан оролцуулж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж давхардсан тоогоор 82 чиглэлд 164 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор 66 төрлийн мэдэгдэл, шаардлагыг мөрдөгчийн мэдэгдэл 1561, зөрчлийн байцаагч /эрх бүхий албан тушаалтан/-ийн 14, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 705, нийт 2280 иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж, тогтоосон хугацаанд ирүүлээгүй, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулаагүй, шаардлага эсэргүүцсэн нийт 78 аж ахуй нэгж, байгууллагад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухайн хуулийн 30.2 дахь хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 78.500,000 төгрөгийн хариуцлага тооцож ажилласан.



Тус цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байранд 2023 онд нийт 2235 иргэнийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 629/-д дагуу хүлээн авч, эрүүлжүүлэх саатуулах байрны эмч нараас 435 иргэнд 14 сэдвийн хүрээнд архины хор хөнөөл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, яриа таниулгыг хийж ажилласан.



Эрүүлжүүлэх байрны эмч нараас 318 хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж гудамж талбай, олон нийтийн газарт архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж, ухаангүй унасан, биедээ гэмтэлтэй 65 иргэнийг яаралтай түргэн тусламжийн 103 болон дүүргийн эрүүл мэндийн төвд шилжүүлэн өгч 157 хүнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.



Эрүүл мэндийн төвд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулж байгаа “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төвтэй архины шалтгаант хордлогын нас баралтыг тодорхой хувиар бууруулах зорилгоор эрүүл мэндийн төвд хордлого тайлах 4 ортой тасаг нээх, тооцоо судалгаа, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулан ажиллаж байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар тус газрын хариуцсан нутаг дэвсгэрт 3667 гэмт хэрэг бүртгэгдэж үүнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 33 буюу 5.7 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 24 буюу 8.6% хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 12 буюу 15.8 хувиар, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 228 бүртгэгдэж 25.7% буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЦААШИД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

1. Согтуурах, мансуурах донтой эмгэгтэй талаар эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон, зөрчил үйлддэг иргэдийг “Архины албан эмчилгээ”-нд хамруулах санал, материалыг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийг илрүүлж, нэг бүрчилсэн хяналтад авах, зан төлөвийг өөрчлөн засах чиглэлээр баг, хороодын хамтарсан багийн гишүүдтэй хамтран сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.
2. Согтуугаар гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг АА болон төрийн болон төрийн бус байгууллагад хүлээлгэн өгч, хамтран ажиллах.
3. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсаны дагуу архидан согтуурахтай тэмцэх, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, гаралтыг бууруулах чиглэлээр тодорхой үе шаттайгаар албан мэдэгдлийг хүргүүлж, биелэлт үр дүнг тооцох.
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулж байгаа “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төвтэй архины шалтгаант хордлогын нас баралтыг тодорхой хувиар бууруулах зорилгоор эрүүл мэндийн төвд хордлого тайлах 4 ортой тасаг нээх, тооцоо судалгаа, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах, мөн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргэгдэн ирсэн иргэдийг хүлээн авах, тэдгээр эмнэлгийн анхан насны тусламж, үйлчилгээ үзүүлэх жишиг өрөөг тохижуулах ажлын зохион байгуулах.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР



Э.ПҮРЭВСҮРЭН

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн сэтгэц аддиктологийн эмч

АРХИГҮЙ ХАН-УУЛ ДҮҮРЭГ БОЛГОХ ЗОРИЛТ ТАВИН АЖИЛЛАЖ БАЙНА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2023 оны 4-р сард “Эрүүл Монгол хүн” үндэсний чуулган зохион байгуулж гаргасан санаачлагын дагуу Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв (ХУДЭМТ)-өөс Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх тусламж үзүүлэх цогц клиник үүсгэн байгуулхаар ажиллаж байна. Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвөөс дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс, нийслэлийн

Аддиктологийн төв , ХУЭМТ-ын сэтгэц аддиктологи кабинет , ЯТТ кабинетууд хамтран архинд донтох эмгэгтэй иргэдийг архинаас гаргах цогц клиник бий болгох зорилт тавьж ажиллаж байна. Одоогоор туршилтын хугацаанд 10 ортой сэтгэц нийгмийн нөхөн сэргээх клиник байгуулж, холбогдох шатны шийдвэр гаргах байгууллагаас албан зөвшөөрлөө хүлээж байна. Энэ хугацаанд 25 хүнийг өдрийн эмчилгээнд хамруулж 14 хүнийг хэвтүүлэн эмчлээд амжилттай хэрэгжээд явж байна. Тус төв нь Сэтгэц аддиктологийн 4 эмч, 2 сувилагч, 1 сэтгэл зүйч, 1 нийгмийн ажилтайн, 1 өөртөө туслах бүлгийн удирдагчтай /гэрээт/ нийт 9 багаар ажиллах зорилт тавин ажиллаж байна. Цаашид ХУД-ийн хүн амын дунд архины хэрэглээний түвшин тогтоох санамсаргүй түүврийн аргаар түвшинг тогтоож, архигүй Хан-Уул болох төлөвлөгөө тавьж ажиллаж байна.





ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ЭХ, НЯРАЙ, НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв нь нийт 224'018 хүн амд үйлчилдэг ба 61'126 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдтэй. Үүнээс эрсдэлт бүлгийн 2157, эмзэг бүлгийн 1503, хөгжлийн бэрхшээлтэй 272 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар нийт амьд төрөлт 4138 байсан ба эхийн эндэгдлийн 1, амьгүй төрөлтийн 11, дутуу төрөлтийн 31, гэрийн төрөлтийн 2, зулбалтын 38 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Дээрх хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 31 тохиолдсон байна.

Энэхүү таагүй үзүүлэлтүүдийг бууруулахаар жирэмсэн үеийн хяналт, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээг сайжруулах болон эх, нялхсын өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор дараах зорилтын дагуу ажиллана.

ЗОРИЛТ

1. Хан-Уул ЭМТ-ийн харьяаллын жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтад эрт хамруулж, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах
2. Жирэмсэнд бүлгийн хяналтын нэг цэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх / оношилоо, шинжилгээ, үзлэгийг нэг дор шийдвэрлэх / хүний нөөцийг чадавхжуулах
3. Төрсний дараах эх, нярай, нялхсын (ой хүртэлх) эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах
4. Жирэмсэн, төрөх, төрсний дараах эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд телемедицинийг ашиглах, эрүүл мэндийн боловсрол олгох

Эдгээр зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

1. Жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтад эрт хамруулах, тогтмол үзүүлэхийг дэмжих урамшууллын багц гаргах ба “Жирэмсний бүлгийн хяналт”-ын тусламж үзүүлэх оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
2. Хүүхдийн хөдөлгөөн сэтгэцийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн дараах тусламж үйлчилгээний алгоритм, журам боловсруулаж гэрийн эргэлтийг нэмэгдүүлэх
3. “Жирэмсний бүлгийн хяналт”-аар нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж лабораторийн шинжилгээ

оношилгоог нэг дор нэг цэгийн үйлчилгээ бүрдүүлэх мөн пренатал оношилгооны хоёрол ба гурвал тестийг дүүрэгтээ үзүүлэх нөхцөлийг ханган ажиллах.

4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдлыг эрт илрүүлэх, өртөгсдөд үр дүнтэй дэмжлэг
5. Бүлгийн хяналтаар жирэмсэн эхчүүдэд жирэмсэн үеийн хооллолт, шим тэжээлийн зохистой байдал, жирэмсэн үеийн дасгал хөдөлгөөн, жирэмсэн үеийн аюултай шинжийн талаарх эрүүл мэндийн боловсрол олгох.
6. Нярайн шарлалтыг эрт оношлох, шарлалттай үед фото эмчилгээнд дүүрэгтээ эмчлэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.
7. Нэг нас хүртэлх хүүхдэд хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн оношлогоог 3, 6, 9 12 сартайд тогтмол хийх
8. Төрсөн эх нярайд зориулсан багц бэлтгэн, төрсний дараа амаржсан эх, нярайд гэр бүл төлөвлөлтийн аргууд, хүүхдийг хөхөөр хооллох, асрах, сувилах, зөвлөгөө өгөх журам, заавар боловсруулж, батлуулах
9. Төрсний дараах сэтгэл гутралын оношилгоог хийж зөвлөгөө зөвлөмж өгөх
10. Өрхийн эмч, эх баригч бага эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарыг чадавхжуулах сургалтанд тогтмол хамруулах.

“ЖИРЭМСНИЙ БҮЛГИЙН ХЯНАЛТ” ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жирэмсний бүлгийн хяналт” нь дараах 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгийг агуулна. Үүнд:

- а) Эмнэлзүйн үзлэг, үнэлгээ
- в) Эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох
- с) Жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг.

“Жирэмсний бүлгийн хяналт”-ын хүрээнд хяналтад анх орж байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний хугацаа, нас, оршин суугаа газрыг харгалзан, нэг бүлэгт хуваарилна. “Жирэмсний бүлгийн хяналт”-ын тусламж үйлчилгээг зохион байгуулахын гол давуу тал нь жирэмсэн эхчүүд эмнэлзүйн чанартай тусламж үйлчилгээний зэрэгцээ, хувь хүний туршлагаа хуваалцах, хэлэлцүүлэг өрнүүлэх, жирэмсний үеийн нийгмийн ба сэтгэлзүйн дэмжлэгийг хангах явдал юм.



Энэхүү тусламж үйлчилгээг сайжруулснаар дараах үр дүнд хүрнэ.


1. Жирэмсний хяналтын эрт хамрагдалтыг дэмжих, хяналтад тогтмол үзүүлэх урамшууллын загвар, багц бий болгоно.
2. “Жирэмсний бүлгийн хяналт”-аар нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
3. Эх барих эмэгтэйчүүдийн эмч нар болон эх баригч бага эмч нарын жирэмсний хяналт, жирэмсний дараах хяналтын тусламж үйлчилгээ үзүүлэх үр чадвар сайжирна.
4. Өрхийн ба хүүхдийн эмч нарын жирэмсний хяналт, жирэмсний дараах хяналт, нярай, нялхаст тусламж үйлчилгээ үзүүлэх үр чадвар сайжирна.
5. Лабораторийн ба бусад эмч мэргэжилтнийг чадавхжуулна.
6. Өрхийн ба сумын эрүүл мэндийн төвд нярайн шарлалтыг эрт оношилж, эмчлэх, хянах чадавх бүрдүүлэх.
7. Төрсний дараах сэтгэл гутралын скрининг оношилгоог тогтмолжуулах
8. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдлыг эрт илрүүлэх, өртөгсдөд үр дүнтэй дэмжлэг үзүүлэх
9. Хүүхдийн хөдөлгөөн, сэтгэцийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх скрининг оношилгоог хэвшүүлэх
10. Төрсний дараа амаржсан эх, нярайд гэр бүл төлөвлөлтийн аргууд, хүүхдийг хөхөөр хооллох, асрах, сувилах виртуал зөвлөгөө өгөх журам, аргачлал боловсруулж, хэрэгжүүлнэ.
11. Жирэмсэн, төрөх, төрсний дараах тасралтгүй хяналтын програм хангамжаар хянаж зөвлөгөө мэдээллийг авна.



ШҮДНИЙ ЭМГЭГИЙН СУДАЛГАА

Шүд цоорох өвчний тархалт дэлхийн улс орнуудын дундаж 40-45 хувь байхад Монгол улсын дундаж 80-99 хувьтай буюу хоёр дахин их байгаа бөгөөд шүдний эмгэгийн илрүүлэг, эмчилгээ чиглэлд олон төсөл, хөтөлбөр хэрэгжсэн хэдий ч дорвитой өөрчлөлт гарахгүй байгаатай уялдан сонгосон сургуулийн сурагчдын дундах эмгэгийг илрүүлж, оношилгоо, эмчилгээний шийдлийг боловсруулах нь нэн чухал байна.

Энэ удаад Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 52 дугаар ЕБС-ийн сурагчдад холбогдох мэргэжлийн багтай хамтран шүдний цоорлыг илрүүлж, шүдний цооролтой хүүхдүүдийг оношилж, эмчилгээний хэрэгцээг тогтоохоор тус сургуулийн нийт 4056 хүүхдийн 70 хувиас дээш буюу 2954 сурагчийг хамруулан нэг сарын хугацаанд шүдний өвчлөлийг үнэлэв.



- Мөн хүний шүдийг сүүн болон байнгын гэж хоёр ангилж үздэг сүүн шүд нь бага насны хүүхдүүдэд, байнгын шүд нь өсвөр үе болон насанд хүрэгчдийн шүд байна. Сүүн шүдний өвчлөлийн 90 хувь нь дээд доод араа буюу ямар нэг хоол хүнс захлах хэсгийн шүд эзэлж байсан бол байнгын шүдний өвчлөлийн 81 хувь нь сүүн шүдний өвчлөлтэй ижил байна.
- Асуумж судалгаанд оролцсон 1-6 дугаар ангийн сурагчдын 77 хувь нь шүдээ өдөрт 2 удаа угаадаг, 6 хувь нь 3 удаа угаадаг, 15 хувь нь 1 угааж байгаа нь сурагчдын дунд шүд угаалт хангалтгүй байгааг илтгэж байна.
- Асуумж судалгаанд оролцсон 7-12 дугаар ангийн сурагчдын 74 хувь нь шүдээ өдөрт 2 удаа угаадаг, 10 хувь нь 3 удаа угаадаг, 13 хувь нь 1 угааж байгаа нь сурагчдын дунд шүд угаалт хангалтгүй байгааг илтгэж байна.
- Мөн 1-6 дугаар ангийн сурагчдын сурагчдын 55 хувь нь шүдний эмнэлэгт үзүүлдэг ба тэдгээрийн 44 хувь нь шүд цоорсон үед эмнэлэгт хандаж 53% нь шүдээ ломбодуулах эмчилгээ хийлгэсэн байна. Сүүлийн оны байдлаар /2023/ 70 хувь нь энэ онд шүдний эмнэлэгт хандсан байна.
- 1-6 дугаар ангийн сурагчдын сурагчдын хооллолтын 99 хувь нь нүүрс ус агуулсан хоол хүнс их бага хэмжээгээр хэрэглэдэг байна. Сүү тарагны хэрэглээ 92%, мах махан бүтээгдэхүүний хэрэглээ 85% байна.
- 7-12 дугаар ангийн сурагчдын хооллолтын 99 хувь нь нүүрс ус агуулсан хоол хүнс их бага хэмжээгээр хэрэглэдэг байна. Сүү тарагны хэрэглээ 88%, мах махан бүтээгдэхүүний хэрэглээ 90% байна.



Олон талт хамтын ажиллагаа



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Япон улсын “Токушюүкай медикал групп”-ийн дэмжлэгтэйгээр Монгол улсад Зүрх, судасны төв байгуулна.



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зорилтот бүлгийн хүүхдүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд Бүгд Найрамдах Солонгос улсын “Грийн хоспитал”-тай хамтарч ажиллах, санамж бичиг байгуулав 20230215



Бүгд Найрамдах Солонгос Улсын Ханна банк, “Грийн хоспитал”-тай хамтран Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүргэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр эмнэлгүүдэд ажиллав 20230216



Зүрх, судасны үндэсний төв байгуулах ажлын хүрээнд Япон улсын Эрүүл мэндийн сайд, Ноён Кацүнобу Катотай уулзаж, санал солилцлоо 20230214-19



Нагоягийн Анагаах ухааны төгсөлтийн сургуулийн Эрүүл мэндийн тусламжийн зохион байгуулалтын хөтөлбөрийн багтай уулзалт хийв 20230226



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний бодлого, чиглэлийг эрчимжүүлэх хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч, Др.Сокорро Эскаланте дэмжиж ажиллахаа илэрхийлэв. 20230405



Сургуулийн сэтгэл зүйч, эмч нарыг чадавхжуулах сургалтыг Кристина Нобелийн Хүүхдийн Сантай хамтран эхлүүлэв. 20230405



Япон улсын “Токушюүкай медикал групп”-тэй Монгол улсад Зүрх, судасны төв байгуулах ажлын хүрээнд манай улсаас эхний 10 хүний бүрэлдэхүүнтэй баг “Токушюүкай медикал групп”-д туршлага судлахаар явлаа. 20230122



БНСУ-аас 18 хүнтэй эмч нарын баг СХД, ЧД-ийн эмнэлгүүдэд ажиллаж байна. 14 хоногийн хугацаанд дээрх дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд зорилт бүлгийн хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төслийн үйл ажиллагааг явууллаа. 20230605-22



Эрүүл мэндийн ажилтны өдрөөр салбараа манлайлан ажиллагсад шагнагч гардууллаа 20230814



Хятад-Монгол эм, эмнэлгийн судалгааны хүрээлэнгийн удирдлагын багтай уулзав 20230901



Эм зүйн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн түүхэн ой тохиов 20230923



БНСУ-ын Ассамблейн дэд дарга Ким Ён Жү өрхийн эмнэлэгт ажиллаа.



ДЭМБ-ын IV форумд ЕТГ-ын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга О.Чимэдсүрэн илтгэл тавив. 20230727



Монгол улсад цусны алба үүсэж хөгжсөний түүхт 60 жилийн ой тохиов 20231006



Эрүүл мэндийн салбарынхан 160 мянган мод тарж ургууллаа 20231007



Нэгдсэн үндэсний байгууллагын өдөр тохиолоо 20231024



Эмгэг судлалын алба үүсэж хөгжсөний 90 жил тохиов 20231030



НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлаг хүлээн авч уулзлаа



“Эрүүл мэндийн төлөөх шийдэл” дугуй ширээний хэлэлцүүлэг



“Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөрийн баг Өмнөговь аймагт ажиллаа



“Эрүүл Монгол Хүн” Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цаг гаргая” аяныг орон даяар эхлүүлэв



Хэтрүүлж биш, хэмжээнд нь “Сахараа багасгая” нөлөөллийн аяныг өрнүүлэв 20230514



“Эрүүл Монгол хүн” үндэсний фестивалийг улс орон даяар зохион байгууллаа 20230531



“Үеэ хайрлая” нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа



Өвөрхангай аймгийн Хужирт, Бат-Өлзий сумдын иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулав



Ахмадын сайн дурын үзлэг зохион байгууллаа



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УТАСНЫ ЖАГСААЛТ, ХАЯГ

Хан-Уул дүүрэг

7777 1965

Хан-Уул дүүрэг, 3 хороо, Үйлдвэр 17042

Хан-Уул эрүүл мэндийн төв

11 341003

Хан-Уул дүүрэг, 3 хороо Үйлдвэр 17042

Хан-Уул нэгдсэн эмнэлэг

70049266

Хан-Уул дүүрэг, 3 хороо, Яармаг

Хан-Туул хүүхдийн сэргээн засах төв

11 341598

Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,

Чингисийн өргөн чөлөө 58

Мөнхбадрах өрхийн эмнэлэг

7222 1001

ХУД-ийн 1-р хороо 120-ийн 18, 19-р байрны голд

Тэрмэстий өрхийн эмнэлэг

88251452, 70105003

ХУД-ийн 2-р хороо 23 байрны ард цогцолбор байр

Энхтитэм өрхийн эмнэлэг

88251453

ХУД-ийн 3-р хороо хас банкны хажууд

22, 23 байрны голд

Цэц-До өрхийн эмнэлэг

70049154

ХУД-ийн 4-р хороо 34-р сургуулийн ар талд

Манал-Үйлс өрхийн эмнэлэг

9990 8382

ХУД-ийн Яармаг 2-р буудал,

5-р хорооны цогцолбор байр

Чанд-Авиа өрхийн эмнэлэг

7004 9197

ХУД-ийн 6-р хороо Нүхтийн 30-р гудамж

АЯУТ өрхийн эмнэлэг

88251483

ХУД-ийн 9-р хороо, Нисэхийн эцэс 107-ийн

хашаа, ХУД-ийн 9-р хорооны зүүн талд

Амин-Тус өрхийн эмнэлэг

8825 2658

ХУД-ийн 10-р хороо 63-р байрны баруун хойно

“Амгалан-Өрх” ӨЭМТ

7211 8229

ХУД-ийн 11 хороо Зайсангийн эцэс,

Мөнхзайсан 1-42 тоот

Био-Асралт өрхийн эмнэлэг

7049 2135

ХУД-ийн 12-р хороо Биокомбинат – СОД шатахуун

түгээгүүрийн хойд талд

Туул тосгон эмнэлэг

7049 7118

ХУД-ийн 13-р хороо 144 цэцэрлэгийн зүүн талд

Энх амгалан өлзийт өрхийн эмнэлэг

85858433

ХУД-ийн 14-р хороо, Барилга 0-1-1

“Мэндсаруул-Өрх” салбар ӨЭМТ

7270 3867

ХУД-ийн 15-р хороо 25-р байр

“Энхбуянт-Манал-Өрх” ӨЭМТ

88251586

Нисэхийн дэнж цогцолбор байр буянт ухаа 1

хороололын зүүн хойд талд

“Амгалан-Оргил-Өрх” ӨЭМТ

7272 8229

ХУД-ийн 17 хороо Удирдлагын Академи

сургуулийн баруун талд 48-р байр

Уясах өрхийн эмнэлэг

9113 2215

Жаргалантын эхний 6 тоот 60 -р

сургуулийн ард талд

20-р хорооны өрхийн эмнэлэг

8825 1463

ХУД-ийн 20-р хороо 946 байрны хорооны

хажууд

Жинст өрхийн эмнэлэг

ХУД-ийн 21-р хороо Буянт-Ухаа 2-р

хороолол

“Амгалан-Өрх” ӨЭМТ-ийн салбар 22-р хорооны ӨЭМТ

7222 8229

ХУД-ийн 22 хороо Цагаан суварга

44-р байр 0 тоот

Цэц-До өрхийн эмнэлэг

7004 9154

ХУД-ийн 4-р хороо 34-р сургуулийн ар талд

Эрдэнэ Энхсаран Өрх

7000 0424

ХУД-ийн 24-р хороо, Вивасити М16 байр

Энхбуянт-Манал 2 өрхийн эмнэлэг

88251586

25-р хороо

19-р хорооны өрхийн эмнэлэг

8825 2657

ХУД-ийн 19-р хороо 115-р сургуулийн

хойно 53-р байр

18-р хорооны өрхийн эмнэлэг

7272 3867

ХУД-ийн 18-р хороо Оргил рашаан

сувилалын чанх ард

Хашчагнуур өрхийн эмнэлэг

8825 2657

ХУД-ийн 7-р хороо Жаргалантын эхний

6 тоот 60 -р сургуулийн урд талд



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



01

ЭРҮҮЛ ОРЧИН,
ЗӨВ ХООЛЛОЛТ



02

ИДЭВХИТЭЙ
ХЕДЭЛГЭЭН



03

ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ



04

ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ



**ЭРҮҮЛ
МОНГОЛ
ХҮН** ҮНДЭСНИЙ
ХЕДЭЛГЭЭН



**ЭРҮҮЛ
МОНГОЛ
ХҮН** **ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨН**



Ерөнхийлөгчийн Тамгын Газрын
"Эрүүл Монгол хүн" төсөл, хөтөлбөр хариуцсан алба

☎ 11-26 29 91

🌐 www.eruulmongolhun.mn

📘 Эрүүл Монгол хүн хөдөлгөөн